

МОНГОЛ УЛС ДАХЬ
ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
25 ЖИЛИЙН ЗАМНАЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
(1992-2017)

2017 он 2 сар

ЖАЙКА Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Байгууллага

International Development Journal ХХК
System Science ConsultantsХК

MG
JR
17-002

Оршил үг

2017 он бол анх 1992 онд ЖАЙКА-гийн 2 сайн дурын гишүүн Монголд томилогдон ирснээс хойш 25 дахь жилээ угтаж буй түүхэн жил юм. Өнөөг хүртэл ЖАЙКА-гийн сайн дурын 650 гаруй гишүүн боловсрол, эрүүл мэнд, спорт, япон хэлний боловсрол зэрэг олон төрлийн салбарт үйл ажиллагаагаа явуулж, хувь нэмрээ оруулж ирсэн. Өнөөдрийн байдлаар (2017 оны 2-р сар) 60 гаруй сайн дурын гишүүн Монгол улсад ажиллаж байна.

Анхны гишүүн томилогдсон 1992 оны үед, Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжээд удаагүй байсан ба эдийн засаг нийгмийн байдал тогтворгүй, хоол хүнс болон түлш, эм бэлдмэл ховор байсан зэрэг ард түмний ахуй амьдралын нөхцөл хүнд байдалтай байсан гэж дуулддаг. Сайн дурын гишүүд маань ч мөн ийм хүнд хэцүү нөхцөлд хамтдаа ажиллаж амьдрах болсон учраас тухайн нутгийн ард иргэдтэй эн зэрэгцэн, тэдэнтэй ижил хэлээр ярьж, Японы арга барилыг тулгах бус, илүү бат бөх итгэлцлийн харилцааг тогтоож, асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөг хамтдаа боловсруулан ажиллаж ирсэн. Хэдийгээр эдгээр алхмууд нь ахиц удаантай байсан хэдий ч яваандаа Монголын цаашдын хөгжлийн хэмнэлтэй хөл нийлүүлэн өнөөгийн Монголыг дэмжих хүний нөөцийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж ирсэн юм.

ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн томилж эхэлсний 25 жилийн ой тохиож буйтай холбогдуулан, тухайн үеийн Монгол талын хүлээн авагч, хамтрагч нарыг хамруулан өмнөх гишүүдийн үйл ажиллагааг тэмдэглэн нэгтгэж, холбоотой бүх хүмүүсийн хамтын хөрөнгө болгохыг зорьсон нь энэхүү судалгааг хэрэгжүүлэх болсон учиртай юм.

2016 оны 2-р сард Монгол улсын Засгийн газраас, Монгол улсын ирээдүйн хөгжлийн бодлого болгон "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (Mongolia Sustainable Development Vision 2030)"-ыг боловсруулсан. Үүнд: 2030 он хүртэл нэг хүнд ноогдох үндэсний нийт орлогыг 17,500 америк долларт хүргэнэ гэх мэт томоохон хөгжлийн зорилтуудыг тавьсан байдаг. Монгол улсын Засгийн газрын эдгээр зорилтод хүрэх хүчин чармайлтыг хэрхэн яаж дэмжих вэ гэдэг нь ЖАЙКА-ийн шинэ сорилт болоод байна. Сайн дурын үйл ажиллагааны хувьд 25 жилийн түүхээ сэтгэлдээ цэгнэн, цаг үе нийгмийн өөрчлөлттэй уян хатан хувьсаж Монголын ард түмэнтэй хамт улам их эрч хүчтэйгээр хамтран ажиллах шинэ замыг нээн явах болно.

25 жилийн урт хугацаа өнгөрсөн болохоор тухайн үеийг мэдэх холбогдох хүмүүс болон, холбогдох материалыг олж авахад маш их хүндрэл учирсан хэдий ч, энэхүү судалгааны ажлын гүйцэтгэгч болох International Development Journal ХХК ба System Science Consultants ХК-иас бүрдсэн хамтарсан аж ахуйн нэгж үнэхээр сайн ажилласан юм. Мөн түүнчлэн, Монгол болон Япон талын холбогдох хүмүүс, өмнөх ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн хамтын ажиллагааны ачаар уг судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж чадсан юм. Энэ боломжийг ашиглан хамтран ажилласан, тусалж дэмжсэн бүх хүмүүстээ чин сэтгэлээсээ талархан буйгаа илэрхийлье.

2017 оны 2-р сар

ЖАЙКА Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
Монгол дахь Төлөөлөгчийн газар
Дарга Сато Мүцүми

Агуулгын хүснэгт

Оршил үг

Агуулгын хүснэгт

Нэр томъёо, хэллэгүүд/Товчлол

Монгол Улс дахь ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн байршлын зураг

Гэрэл зураг

1-Р БҮЛЭГ.	СУДАЛГААНЫ ТОЙМ	1
1.1	Судалгааны удирдтгал нөхцөл ба зорилго	1
1.2	Судалгааны хамрах хүрээ ба аргачлал	1
1.3	Судалгааны багийн бүтэц.....	2
1.4	Судалгааны хөтөлбөр	2
2-Р БҮЛЭГ.	МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ БА ЯПОН УЛСЫН ТУСЛАМЖИЙН ЧИГ ХАНДЛАГЫНТУХАЙ.....	3
2.1	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тойм.....	3
2.1.1	Ерөнхий байдал	3
2.1.2	Улс төр, эдийн засаг	3
2.2	Монгол Улсын Засгийн газрын сүүлийн үеийн хөгжлийн бодлого.....	4
2.3	Япон улсын тусламжийн тойм.....	5
2.3.1	Япон улсын тусламжийн дүн ба хоёр улсын харилцаа	5
2.3.2	Монгол Улсад үзүүлж буй Япон Улсын тусламжийн чиг хандлага	7
2.4	Япон Улсын тусламжийн бодлого ба сайн дурын гишүүдийг илгээх төлөвлөгөө	9
3-Р БҮЛЭГ.	ЭХЭН ҮЕИЙН ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	11
3.1	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээр байгуулав	11
3.1.1	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүдийг хүлээн авах тухай хэлэлцээртэй холбогдуулан Монгол Япон хоёр орны авч явуулсан арга хэмжээ.....	11
3.1.2	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг томилох бэлтгэл шат.....	11
3.1.3	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг илгээх бэлтгэл ажил.....	12
3.1.4	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг бүртгэх, сонгох.....	13
3.1.5	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүний илгээлтийн өмнөх бэлтгэл ажил.....	13
3.2	ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны эхлэл.....	13
3.2.1	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүний томилолт	13
3.2.2	Далайн чанад дахь ахмад сайн дурын гишүүдийг илгээж эхэлсэн нь	14
3.2.3	ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын өөрчлөлт	14
4-Р БҮЛЭГ.	ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОЛТ АМЖИЛТ	16
4.1	ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны үзүүлэлт	16
4.1.1	ЖАЙКА-ийн сайн дурынхан томилогдсон он болон мэргэжил тус бүрээр ангилан	

	харуулсан үзүүлэлт	16
4.1.2	ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн орон нутаг дахь үйл ажиллагаа.....	18
4.2	Голлох салбарын шилжилт хөдөлгөөн.....	19
4.2.1	Япон хэлний боловсрол	20
4.2.2	Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ).....	23
4.2.3	Бага, дунд, бүрэн дунд боловсрол	24
4.2.4	Эрүүл мэнд	27
4.2.5	Сэргээн засалч (хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл яриа, сонсгол засалч)	28
4.2.6	Спорт.....	28
4.2.7	Голлох 4 салбарын үйл ажиллагааны үр дүн ба цаашид шийдвэрлэх асуудлын тойм.....	30
4.2.8	Бусад ажил мэргэжил.....	32
4.3	Хүлээн авагч талын үнэлгээ (ярилцлага).....	33
4.3.1	Сангийн яам.....	33
4.3.2	Эрүүл мэндийн яам.....	34
4.3.3	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам.....	34
4.3.4	Жүдо бөхийн холбоо.....	34
4.3.5	Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургууль.....	35
4.3.6	Улсын 3 дугаар төв эмнэлэг.....	35
4.3.7	Тархины саажилттай хүүхдийн 10 дугаар цэцэрлэг.....	36
4.3.8	IV ДЦС	37
4.3.9	Эрдэнэт хотын Биеийн тамир спортын газар	37
4.3.10	Дархан-Уул аймаг 18-р сургууль	38
4.3.11	Дархан хотын Ус сувгийн удирдах газар.....	38
4.3.12	Булганы 2-р цэцэрлэг	39
4.3.13	Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг.....	40
5-Р БҮЛЭГ.	ЯПОН-МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН ТҮВШИН ДЭХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН	
	ХАРИЛЦАА	42
5.1	Япон-Монголын орон нутгийн түвшин дэх хүүхэд залуучуудын харилцаа	42
5.1.1	Япон Монгол хоёр орны хооронд ах дүүгийн харилцаатай болоод найрамдалт	42
5.1.2	Япон Монгол Улсын төрийн бус байгууллагын бусад үйл ажиллагаа.....	46
6-Р БҮЛЭГ.	МОНГОЛ УЛС ДАХЬ ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ	
	ЦААШДЫН ТӨЛӨВ БА ЗӨВЛӨМЖ	47
6.1	ЖАЙКА-ийн 25 жилийн сайн дурын үйл ажиллагааны үр дүнгийн тойм	47
6.1.1	Үр дүнгийн тойм	47
6.1.2	Монгол Улсын хөгжлийн хэрэгцээг харгалзан үзэх	47
6.1.3	Монгол Улсын холбогдох байгууллагуудын үнэлгээ	48
6.2	Монгол Улсын хөгжлийн бодлого ба цаашдын чиг хандлага	48
6.2.1	Монгол Улсын эдийн засгийн хөгжил	48
6.2.2	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030	49
6.2.3	Япон Улсын ХАЁТ үзүүлэх улс орны үзүүлэлт	49

6.3	Япон Улсын Засгийн газрын ODA-ийн чиглэл.....	49
6.3.1	Япон Монгол 2 орны гадаад харилцаа	49
6.3.2	Хөгжлийн хамтын ажиллагааны үндсэн зарчим	50
6.3.3	Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.....	51
6.3.4	Сайн дурын үйл ажиллагааны асуудлууд.....	51
6.4	Олон Улсын байгууллагын тусламжийн чиг хандлага	51
6.4.1	Үйл ажиллагааны тойм.....	51
6.4.2	Олон Улсын байгууллага гэх мэт бусад тусламжийн байгууллагуудтай хамтран ажиллах.	51
6.5	ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны цаашдын төлөв.....	52
6.5.1	ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны чиг хандлагын уулзалтаар хэлэлцсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх	52
6.5.2	Томилгооны хэмжээ	53
6.5.3	Хамтын ажиллагааны салбар	53
6.5.4	Орон нутаг дахь өрнөл.....	54
6.5.5	ODA-ийн бусад тогтолцоотой тогтоох уялдаа холбоо	54
6.5.6	Цаашдын үйл ажиллагааны өрнөл.....	55
Хүснэгт 1-1 Судалгааны багийн бүтэц.....		2
Хүснэгт 1-2 Судалгааны ерөнхий явцыг харуулсан хүснэгт		2
Хүснэгт 2-1 "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030"-ийн 10 томоохон зорилт		5
Хүснэгт 2-2 Хоёр орны ODA-ийн он ба тусламжийн төрлөөр ангилан харуулсан үзүүлэлт		6
Хүснэгт 2-3 ЖАЙКА-ийн Монгол дахь техникийн хамтын ажиллагааны тусламж		7
Хүснэгт 2-4 Монгол Улсад үзүүлэх тусламжийн бодлогын өөрчлөлт.....		8
Хүснэгт 2-5 Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө (2016 оны 4-р сар).....		10
Хүснэгт 3-1 Гишүүдийн холбоо барих газрын өөрчлөлт.....		15
Хүснэгт 4-1 ЖАЙКА-аас томилогдсон сайн дурын гишүүдийн тоо, он тус бүрээр		16
Хүснэгт 4-2 ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн бүс нутагт хуваарилагдсан байдал.....		19
Хүснэгт 4-3 Монгол Улсад томилсон гишүүдийн мэргэжлээр ангилсан үзүүлэлт.....		20
Хүснэгт 4-4 Салбар тус бүрийн үйл ажиллагааны үр дүн ба цаашид шийдвэрлэх асуудал		30
Хүснэгт 4-5 Улсын 3-р төв эмнэлэгт томилогдсон сэргээн засах эмчилгээний салбарын JOCV нарт хандсан сэргээн засах эмчилгээний тасгийн даргын ярианаас		36
Хүснэгт 5-1 Япон Монгол хоёр орны орон нутгийн захиргаадын хоорондын		42
Хүснэгт 6-1 Япон Монгол хоёр Улсын хооронд байгуулсан голлох олон Улсын гэрээ хэлэлцээрүүд.....		50
Хүснэгт 6-2 ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны цаашдын өрнөл (жишээ).....		55
График 2-1 Монгол улсын хүн амын өөрчлөлт (1990-2020 он) (нэгж: 1 сая хүн)		3
График 2-2 Монголын нэг хүнд ногдох ДНБ-ний өөрчлөлт (нэгж: ам.доллар)		4
График 4-1 Мэргэжил тус бүрээр Монгол Улсад томилсон байдал		17
График 4-2 Нийслэл болон орон нутаг дахь сайн дурынхны харьцаа, он тус бүрээр.....		19
График 4-3 Япон хэлний багш нарын томилгоо		21

График 4-4 Сургуулийн өмнөх боловсрол дахь томилолтын үзүүлэлт	24
График 4-5 Бага сургуулийн сургалтын байдал (МУБИС дахь илгээлтийг оруулсан болно)	25
График 4-6 Байгалийн шинжлэх ухааны багшийн томилгоо.....	26
График 4-7 Биеийн тамирын хөгжил.....	26
График 4-8 Сувилагч,нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эх баригчийн томилгоо	27
График 4-9 Хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл яриа, сонсгол засалчийн томилгоо.....	28
График 4-10 Гар бөмбөгийн мэргэжлээр илгээгдсэн ЖАЙКА-ийн сайн дурынхны томилгоо	29

Хавсралт

Хавсралт 1: Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүн (JOCV)-ийг томилон ажиллуулах тухай хэлэлцээр	1
Хавсралт 2: Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр	7

Нэр томъёо, хэллэгүүд

Монгол нэршил	Англи нэршил	Тайлбар
ЖАЙКА-ийн сайн дурынхан	JICA Volunteers	ЖАЙКА-ийн сайн дурынхны ерөнхий нэршил. Нас, хүсэлт гаргагч буюу гишүүнийг илгээгчээс шалтгаалан 4 төрөлд хуваадаг. Ази, Африк зэрэг хөгжиж буй бүс нутагт үйл ажиллагаагаа явуулах "Японы Залуу Сайн Дурынхан (20-39 нас)" ба "Ахмад сайн дурын гишүүд (40-69 нас)", Төв болон Өмнөд Америкийн Никкей (Япон гаралтай) нийгэмд үйл ажиллагаагаа явуулах "Япон гаралтай нийгмийн залуу сайн дурынхан (20-39 нас)", "Япон гаралтай нийгмийн ахмад сайн дурынхан (40-69 нас)" гэж ангилдаг.
Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхан	Japan Overseas Cooperation Volunteers (JOCV)	"Өөрийн эзэмшиж буй мэдлэг чадвар болон туршлагаасаа хөгжиж буй орнуудын иргэдтэй хуваалцах" хүсэл эрмэлзэлтэй 20-39 насны залуусыг гишүүнээр элсүүлж, 1965 онд байгуулагдсан.
Ахмад сайн дурынхан	Senior Volunteers (SV)	1990 онд "Ахмад хамтын ажиллагааны мэргэжилтэн" нэрээр үйл ажиллагаагаа эхлүүлж, 1996 онд "Далайн чанад дахь ахмад сайн дурынхан" хэмээн нэрээ шинэчилсэн. Хамрагдах нас 40-69.
Техникийн хамтын ажиллагаа	Technical Cooperation	Хөгжиж буй орнуудын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс Япон Улсын дэвшилтэт техник технологи, ур чадвар, мэдлэгийг хөгжиж буй орнуудын иргэдэд зааж сургах туслалцааны хэлбэр.
Буцалтгүй тусламж	Grant Aid	Хөгжиж буй орнуудын эдийн засаг нийгмийн хөгжилд шаардлагатай барилга байгууламж барьж байгуулах, материал тоног төхөөрөмжийн худалдан авалтыг дэмжих зорилгоор эргэн төлөх шаардлагагүй, буцалтгүй тусламжийн хэлбэр. Орлогын түвшин доогуур, хөгжиж буй орнуудад голлон хэрэгжүүлдэг.
Хөнгөлөлттэй зээл	Loan Aid	Японы иенээр зээл олгодог учир "иенийн хөнгөлөлттэй зээл" ч гэж нэрлэдэг. Хөгжиж буй орнуудын хөгжлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор, хөгжиж буй орнуудад урт хугацааны, бага хүүтэй, уян хатан нөхцөлтэй хөгжлийн санхүүжилт буюу зээл олгодог тусламжийн хэлбэр.
Төслийн зохицуулагч (Сайн дурын ажилтан)	Volunteer Coordinator	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын гадаад дахь төлөөлөгчийн газарт байрлан, ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааг дэмжиж, аюулгүй байдлыг хангаж, шинэ томилгооны судалгаа хийх, холбогдох байгууллагуудтай холбоо барьж зохицуулах гэх мэтээр сайн дурынханд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. 2008 оны 10 дугаар сар хүртэл "сайн дурын зохицуулагч" гэж нэрлэдэг байсныг "төслийн зохицуулагч" болгон нэгтгэж, сайн дурын үйл ажиллагаанаас бусад зарим үйл ажиллагааг хариуцуулсан.
Хамтрагч тал	Counterpart (CP)	Техникийн хамтын ажиллагаа үзүүлэхээр хөгжиж буй орнуудад илгээгдсэн ЖАЙКА-ийн сайн дурынхантай хамтран ажиллаж, Япон Улсын дэвшилтэт техник технологийг заалган авч байгаа хүлээн авагч орны мэргэжилтэн, холбогдох албан тушаалтныг нэрлэнэ.
Монгол төгрөг	MNT (Mongolian tögrög)	Монгол Улсын валютын нэгж. Энэхүү материалд олон Улсын валютын код болох MNT гэж тэмдэглэнэ.
Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл	COMECON (Council for Mutual	Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл. 1949 онд хуучин ЗХУ-ын удирдлаган дор зүүн Европын орнууд голчилсон социалист орнуудын хоорондын эдийн засгийн

(ЭЗХТЗ)	Economic Assistance)	хамтын ажиллагааны байгууллагыг барууны орнуудад нэрлэдэг байсан нэршил. ЗХУ задарснаар 1991 онд татан буугдсан.
Өөрчлөн байгуулалт	Perestroika	1980 оны сүүлийн хагасаас эхлэн ЗХУ-д эхэлсэн Улс төрийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх хөдөлгөөн.
Шинэчлэл	—	Хуучин БНМАУ байх үеийн сүүлийн үеийн "шинэчлэл" гэсэн утгатай ба хуучин ЗХУ-ын перестройка-гийн монгол хувилбар.
Монгол Улс дахь ЖАЙКА-ийн сайн дурын байгууллагын сэтгүүл "Баасан"	—	Баасан нь монгол хэлээр баасан гараг гэсэн утгатай үг бөгөөд, монгол дахь ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагаа, амьдрал ахуйг нийтлэл болгон танилцуулдаг. 1992 онд анхны дугаараа гаргаж, No.1-50 (2012 он) дугаараа цаасаар хэвлэж гаргасан бол түүнээс хойш "Баасан онлайн" болж өөрчлөгдсөн (http://baasanonline.blog.fc2.com/).

Товчлол

Товчлол	Англи нэршил	Монгол нэршил
C/P	Counterpart	Хамтрагч тал
GDP	Gross Domestic Product	Дотоодын нийт бүтээгдэхүүн
IMF	International Monetary Fund	Олон Улсын валютын сан
JICA	Japan International Cooperation Agency	ЖАЙКА-Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
JOCA	Japan Overseas Cooperative Association	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны нийгэмлэг
JOCV	Japan Overseas Cooperation Volunteer	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүн
KOICA	Korea International Cooperation Agency	БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
NRSO	National Registration and Statistical Office of Mongolia	Монгол Улсын Бүртгэл Үндэсний Статистикийн Хороо
ODA	Official Development Assistance	Хөгжлийн албан ёсны тусламж
SDGs	Sustainable Development Goals	Тогтвортой хөгжлийн зорилтууд
SV	Senior Volunteers	Ахмад сайн дурын гишүүд
UNV	United Nations Volunteers	НҮБ-ын сайн дурынхан

ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдийн Монгол улс дахь үйл ажиллагаа



СӨБ (Орхон аймаг 9-р цэцэрлэг)



Бага боловсрол
(Дархан-Уул аймгийн 1-р сургууль)



Биеийн тамир (Орхон аймаг 7-р сургууль)



Жудо (Дархан-Уул аймгийн жудо бөхийн холбоо)



Гар бөмбөг
(Монгол улсын гар бөмбөгийн холбоо)



Хөдөлмөр засалч
(Улсын 3-р төв эмнэлэг)



Эх баригч
(Булган аймгийн Эрүүл мэндийн газар)



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрсэн хүний дэмжлэг (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо)

1-Р БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ТОЙМ

1.1 Судалгааны удирдтгал нөхцөл ба зорилго

ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагаа нь хөгжиж буй Улс орны хүсэлтэд үндэслэн, тэдгээр Улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг хүссэн япон иргэдийн тухайн оронд явуулах үйл ажиллагааг дэмжих зорилготой бөгөөд Япон Улсын хөгжлийн албан ёсны тусламж (ODA)-ийн хүрээнд Японы олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ийн харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг. Гол зорилго нь, 1) Хөгжиж буй орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжил, сэргээн босголтод хувь нэмэр оруулах, 2) Найрамдалт харилцаа, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх, 3) Глобал хандлагыг төлөвшүүлж, сайн дурын туршлагаас нийгэмдээ эргэжхувь нэмэр оруулах. Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхан (JOCV: Japan Overseas Cooperation Volunteers цаашид өнөөгийн нэршил болох "JOCV" гэж тэмдэглэнэ.) нь 1965 онд үйл ажиллагаагаа эхлүүлж, өнөөдрийг хүртэл 40,000 гаруйхүнийг хамарчээ.

Монгол Улсын хувьд Япон Улсын засгийн газартай 1991 оны 3 дугаар сарын 26-ны өдөр “Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээр” (JOCV) байгуулснаар 1992 оны 4 дүгээр сард анхны 2 JOCV гишүүнийг (япон хэлний сургалт) илгээжээ. 1999 онд "Японы далайн чанад дахь ахмад сайн дурынхныг (SV: Senior Volunteers) хүлээн авах тухай протокол"-д гарын үсэг зурж 2000 оны 11 сард далайн чанад дахь ахмад сайн дурын гишүүдийг томилж эхэлсэн байна. 2016 оны 10 дугаар сарын байдлаар ЖАЙКА-ийн сайн дурын нийт 643 гишүүн (JOCV: 505 гишүүн, SV: 135 гишүүн, НҮБ-ын сайн дурын 3 гишүүн) Монгол Улсад ажиллаж, хөгжилд нь хувь нэмрээ оруулжээ. 2016 оны 10 дугаар сарын байдлаар Монголд томилогдон ажиллаж буй сайн дурын гишүүдийн тоо 62 байгаа бөгөөд ЖАЙКА-ийн мэргэжилтэн хамгийн олон тоогоор илгээдэг Азийн орны нэг нь Монгол Улс болж байна. Техникийн хамтын ажиллагааны нэг болох ЖАЙКА-ийн Монгол дахь сайн дурынхны үйл ажиллагаа нь буцалтгүй тусламж, иений хөнгөлөлттэй зээлтэй эн зэрэгцэх хамтын ажиллагааны нэгэн чухал төрөл юм.

2016 оны 2 дугаар сард Монгол Улсын засгийн газар “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (Mongolian Long Term Development Vision)”-ыг боловсруулсан. Энэхүү үзэл баримтлал нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2015 оны 9 дүгээр сард баталсан “2030 хөтөлбөр” (SDGs)-өөр тавигдсан хөгжлийн зорилтуудыг Монголд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн гэж үзэж болох бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхэд ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагаа зэрэг Япон Улсын тусламж дэмжлэг чухал үүрэгтэй юм.

Эдгээр нөхцөл байдалд үндэслэн, 2017 онд Монголд ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийг томилж эхэлснээс хойш 25 жил болж байгаатай холбогдуулан, ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны замналыг тайлан болгож нэгтгэхэд энэхүү судалгааны зорилго оршино. Судалгааны тайланд өнөөдрийг хүртэлх ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны талаар холбогдох хүмүүсийн дурсамж яриа, мэдээлэл, материалуудыг эмхэтгэж, үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, Монголдахь ЖАЙКА сайн дурынханы хамтын бүтээл болгон нэгтгэв. Мөн түүнчлэн Монгол дахь 2 талын хамтын өв болгон дүрс бичлэг (япон, монгол, англи хэлээр), болон товхимол (монгол, англи хэлээр) хэвлэн гаргана.

1.2 Судалгааны хамрах хүрээ ба аргачлал

Судалгааны хамрах хүрээ болон аргачлал нь :

- 1) Судалгааг Монгол Улс болон Япон Улсад хийв.
- 2) Судалгааны хамрах хүрээ нь Монгол дахь холбогдох хүмүүс, Монгол Улсад томилогдон ажиллаж буй ЖАЙКА-ийн сайн дурын залуу болон ахмад гишүүд (JOCV, SV), төслийн зохицуулагч нар байв.
- 3) ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн илтгэл тайланд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ, ЖАЙКА-ийн өмнөх үеийн ажилчид болон ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн төлөөлөл, мөн ах дүүгийн харилцаатай орон нутгийн захиргаадын судалгааг Япон Улсад хийв.
- 4) Бусад орны сайн дурын байгууллага болох АНУ-ын Энх тайвны корпус (Peace Corps),

КОИСА (БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага), мөн Монгол дахь сайн дурынхныг нэгтгэн ажиллаж байгаа Монголын сайн дурын байгууллагуудын сүлжээ (NMVO)-ээс ярилцлага авав.

5) Судалгааныаргачлалнь:

1. Ном товхимол, илтгэл тайланд дүн шинжилгээ хийх
2. Асуулга судалгаа явуулах
3. Ярилцлага авах
4. Тухайн орон нутагт очиж сурвалжлага хийх зэрэг болно.

1.3 Судалгааны багийн бүтэц

Судалгааны баг нь доорхи 6 гишүүдээс бүрдэнэ.

Хүснэгт 1-1 Судалгааны багийн бүтэц

Овог нэр	Хариуцсан ажил үүрэг	Харьяалал
Шикама Ёшифуса	Багийн удирдагч Үйл ажиллагааны төлөвлөлт	International Development Journal ХХК
Сагава Чиэ	Мэдээллийн дүн шинжилгээ Үйл ажиллагааны төлөвлөлт	System Science Consultants ХК
Акияма Ёшико	Мэдээлэл цуглуулах Замнал шинжилгээ	System Science Consultants ХК
Кинжо Тошимицу	Мэдээлэл цуглуулах (хувь хүний намтар) Товхимол хэвлэх	International Development Journal ХХК
Каваи Рюүичи	Дүрс бичлэг хийх (найруулагч)	Ортас Жапан ХХК
Кинжо Масаказү	Дүрс бичлэг хийх (зураглаач)	Ортас Жапан ХХК

1.4 Судалгааны хөтөлбөр

Энэхүү судалгааг 2016 оны 9 дүгээр сарын 28-наас 2017 оны 2 дугаар сарын 28-ны өдөр хүртэл 5 сар гаруй хугацаанд явуулав. Ажлын ерөнхий төлөвлөгөөг доорхи хүснэгтэд харуулав. Судалгааны нарийн мэдээллийг хавсралт материалаас харна уу.

Хүснэгт 1-2 Судалгааны ерөнхий явцыг харуулсан хүснэгт

Үйл ажиллагаа	Хугацаа	2016 он				2017 он	
		9сар	10сар	11сар	12сар	1сар	2сар
(1) Япон дахь урьдчилсан бэлтгэл ажил		↔					
(2) Монгол дахь судалгаа 1 (2016.10.5 - 10.21)			↔				
(3) Япон дахь үйл ажиллагаа 1				↔	↔	↔	
(4) Монгол дахь судалгаа 2 (2017.1.16 - 1.20)						↔	
(5) Япон дахь үйл ажиллагаа 2							↔
Үр дүн (тайлан илтгэл, дүрс бичлэг, товхимол)			▲ Үйл ажиллагааны төлөвлөгөө			▲ Эцсийн бүтээгдэхүүний хувилбар	▲ Эцсийн бүтээгдэхүүн

2-Р БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ БА ЯПОН УЛСЫН ТУСЛАМЖИЙН ЧИГ ХАНДЛАГЫН ТУХАЙ

2.1 Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тойм

2.1.1 Ерөнхий байдал

Монгол Улс нь зүүн Азийн хойд хэсэгт байршилтай далайд гарцгүй Улс бөгөөд зүүн болон урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-той, баруун талаараа БНХАУ-ын Уйгурын өөртөө засах оронтой, хойд талаараа ОХУ-тай хиллэдэг. Японы газар нутгаас 4 дахин том, 3,061,000 хүн амтай (2015 оны Монгол Улсын Үндэсний статистикийн хороо (цаашид "NRSO" гэх)). Нийслэл Улаанбаатар хотын хүн ам нь 1,345,500 (2015 оны NRSO) хүн ба нийт хүн амын 44% нь нийслэлдээ төвлөрсөн. Хүн амаараа хоёрт ордог Орхон аймгийн Эрдэнэт хот 89,564 хүн амтай (2015 онд), гурав дахь хот болох Дархан-Уул аймгийн Дархан хот нь 80,652 хүн амтай (2015 онд) байна. ОУВС-ийн мэдээллээс үзвэл Монгол Улсын хүн амын тоо нь доорхи хүснэгтийн дагуу байсан бөгөөд 1990 оноос 2015 он хүртэлх 25 жилийн хугацаанд 1,000,000 гаруй хүнээр өсчээ. Цаашдаа ч 2020 он хүртэл хүн ам өсөх төлөвтэй байна.




График 2-1 Монгол улсын хүн амын өөрчлөлт (1990-2020 он) (нэгж: 1 сая хүн)

※2015-2020 оны үзүүлэлт нь ОУВС-аас 2016 оны 4 дүгээр сард гаргасан тооцоолол
(Эх сурвалж: ОУВС-Дэлхийн эдийн засгийн төлөв мэдээллийн сан (2016 оны 4-р сарын хэвлэл))

Монголын хүн амын нягтаршил (хүн/км²) нь 1,4 (1990 онд)-өөс 1,8 (2012 он) болон өөрчлөгдсөн хэдий ч дэлхийд хамгийн бага нягтралтай хэвээр байна. Хүн амд эзлэх гадаадын иргэдийн тоо хэмжээ (1990 онд) 0,3%, (2012 онд) 0,6% болж, томоохон өөрчлөлт гараагүй байна.

Орон нутгийн засаг захиргааны нэгж нь Япон Улсын мужтай дүйцэх аймаг 21, аймаг дотроо японы тосгонтой дүйцэх сум 347, мөн сум нь дотроо хамгийн бага нэгж болох баг 1,681 байдаг. Сумын дундаж хүн ам нь 3,000 орчим бөгөөд баг нь 50-100 өрхтэй. Улаанбаатар хот болон Эрдэнэт, Дархан зэрэг аймгийн төв хотуудад хүн амын төвлөрөл нэмэгдсээр байна. Хот суурин газрын хүн амын харьцаа нь (1990 онд) 57,0%-иас (2015 онд) 71,2% болж өссөн байна.

2.1.2 Улс төр, эдийн засаг

Монгол Улс 1990 оны ардчиллын дараа, чөлөөт сонгуулиар олон намын тогтолцоонд шилжиж, 1992 онд шинээр баталсан Үндсэн хуулийнхаа дагуу аль аль нь шууд сонгогдох нэг танхимтай УИХ болон Ерөнхийлөгч зэрэгцэн орших хосолсон хэлбэрт парламентийн засаглал (Хагас Ерөнхийлөгчийн засаглал)-тай /Парламентаас ЗГ-ын кабинетаа бүрдүүлдэг/болжээ.

Үндсэн үйлдвэрлэл нь уул уурхай, мал аж ахуй, жижиглэн худалдаа, хөнгөн үйлдвэрлэл юм. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 1990 оноос хойш, доорхи графикт харуулсны дагуу өсч ирсэн. Монгол

Улс, ардчиллын дараа зах зээлийн эдийн засагт шилжих бүтцийн өөрчлөлт хийж, 1994 оноос эдийн засгийн өсөлт нь эерэг болсон боловч 2008 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын улмаас 2009 онд сөрөг үзүүлэлт рүү (-1.3%) унасан байна. Үүний дараа, уул уурхай, байгалийн баялгийн өсөлт, олон Улсын зах зээл дэх үнийн сэргэлттэй холбогдон 2010 онд 6,4%, 2011 онд 17,3% хүрч эдийн засгийн огцом өсөлт гарсан. Гэсэн хэдий ч өнөөгийн эдийн засгийн өсөлт нь 2,3%, инфляцийн түвшин 1,9%, ажилгүйдлийн түвшин 8,3% (аль аль нь 2015 оны NRSO үзүүлэлт) болж, 1) Хятад-Оросоос хамааралтай эдийн засаг 2) Инфляцийн түвшний огцом өсөлт 3) Баян хоосны ялгаа эрс нэмэгдэх зэргээр эдийн засгийн тулгамдсан олон асуудалтай учраад байна¹. 2016 оноос инфляцийн чиг хандлага илэрч, уул уурхайгаас хэт хараат болсноос аж үйлдвэрийн бусад салбарыг хөгжүүлж, олон талт болгоход бэрхшээл үүсээд байна.




График 2-2 Монголын нэг хүнд ногдох ДНБ-ний өөрчлөлт (нэгж: ам.доллар)

※Тухайн жилийн валютын ханшаар ам.долларт хөрвүүлэн тооцсон.

※2015, 2016 оны үзүүлэлт нь ОУВС-аас 2016 оны 4 дүгээр сард гаргасан тооцоолол

※SNA (үндэсний тооцооны систем)-д үндэслэсэн үзүүлэлт

(Эх сурвалж: ОУВС-Дэлхийн эдийн засгийн төлөв мэдээллийн сан (2016 оны 4-р сарын хэвлэл))

2.2 Монгол Улсын Засгийн газрын сүүлийн үеийн хөгжлийн бодлого

2016 оны 4-р сард "2030 он хүртэлх Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-ыг УИХ-аас баталсан. Энэхүү үзэл баримтлалыг 2015 оны 9-р сард Нью-Йорк дахь НҮБ-ын төв байранд зохион байгуулагдсан Ерөнхий Ассамблейн Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний чуулганаар баталсан "Тогтвортой хөгжлийн 2030 Хөтөлбөр (SDGs)"-тэй нягт уялдуулж боловсруулсан бөгөөд цаашид, Япон Улсын хөгжлийн хамтын ажиллагааны бодлогод тусгагдана гэж ойлгож болох юм.

Монгол Улсын Засгийн газар, "Салбар бүрийг тасралтгүй, тогтвортой хөгжүүлснээр Higher middle income countries (өндөр орлоготой улс орнууд)-ын эгнээнд багтаж, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой, ардчилсан засаглалыг хэрэгжүүлнэ". Гэсэн зорилтыг тавин

- 1) Эдийн засгийн тогтвортой хөгжил,
- 2) Нийгмийн тогтвортой хөгжил,
- 3) Байгаль орчны тогтвортой хөгжил,
- 4) Тогтвортой хөгжлийн засаглалын асуудлуудын талаар зорилт тавьсан байна.

Доорхи хүснэгтэд 10 гол зорилтыг жагсаав. Үүнд:

¹ Япон улсын ГХЯ-ны цахим хуудас: Монгол улсын үндсэн мэдээлэл: <http://www.mofa.go.jp/mofaj/area/mongolia/data.html> (хандалт 2016/9/6)

Хүснэгт 2-1 "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030"-ийн 10 томоохон зорилт

Монгол хэл	
1	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлогыг 17,500 америк долларт хүргэж, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ.
2	Эдийн засгийн дундаж өсөлтийг 2016-2030 онд 6,5%-иас доошгүй байлгана.
3	Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.
4	Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80% нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.
5	Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100%-дхүргэж, боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.
6	Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ.
7	Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно.
8	Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээрдэлхийн эхний 30 орны нэг болно.
9	Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно.
10	Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна.

(Эх сурвалж: Mongolia Sustainable Development Vision 2030)

2.3 Япон улсын тусламжийн тойм

2.3.1 Япон улсын тусламжийн дүн ба хоёр улсын харилцаа

Япон Улс 1972 онд Монгол Улстай дипломат харилцаа тогтоож, 1973 онд Япон Улс болон Монгол Улсын нийслэлд тус тусын ЭСЯ-дыг байгуулан, 1974 онд Соёлын харилцаа тогтоох тухай Тохиролцоонд гарын үсэг зурсан юм. Гэвч, Монгол Улсын социалист нийгмийн байгуулал нь Японыхоос эрс ялгаатай байснаас 1977 оны "Говь ноолуурын (Улсын) үйлдвэрийг барих" буцалтгүй тусламж болон түүнтэй холбогдох техникийн туслалцааг үл тооцвол маш хязгаарлагдмал туслалцааг үзүүлж байсан².

Монгол Улс социалист системээс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990 оноос хойш Япон Улсын хөгжлийн албан ёсны тусламж (ODA)-аар дамжуулан хоёр орны харилцаа бэхжиж, өргөн хүрээнд олон салбарт нягт харилцаа, хамтын ажиллагаа бий болсон байна. 2014 оны эцсийн байдлаар тусламжийн өнгөрсөн хугацааны нийт дүнг авч үзвэл, хөнгөлөлттэй зээл 89 тэрбум иен, буцалтгүй тусламж 108 тэрбум иен, техникийн хамтын ажиллагааны тусламж 46,6 тэрбум иен байна. Эдгээр тусламж нь IV-р ДЦС-ын засварын ажил, бага, дунд сургуулийн барилга, цэвэр бохир усны барилга байгууламжийг барьж байгуулах, зам тавих гэх мэт эдийн засаг, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг гардан явуулахболовсон хүчин бэлтгэхэд зориулагджээ.

Монгол Улсын зүгээс ч мөн адил Япон Улсад хүнд хэцүү үед тусламж үзүүлж ирсэн. 1995 оны 1-р сарын 17-ны өдрийн Ханшин-Аважигийн их газар хөдлөлтөөс 5 өдрийн дараа буюу 22-ны өдрийн үдэш Шадар сайд Пүрэвдорж Монгол Улсын Засгийн газрын тусгай онгоцоор Кансай нисэх онгоцны буудалд бууж, яаралтай тусламжийн барааг (2,100 ширхэг ноосон хөнжил, 500 хос бээлийг) хүргэж ирсэн юм. Ингээд "Удаан хугацаагаар байх нь Та бүхэнд төвөг учруулна" хэмээгээд 90 минутын дараа Монгол руугаа буцсан. 2004 оны 10-р сарын 23-нд болсон Нийгата мужийн Чүүэцү газар хөдлөлтийн үед ч мөн адил Монгол Улсын Засгийн газраас 520 ширхэг ноосон хөнжил өгч туслалцаа үзүүлсэн. 2011 оны 3-р сарын 11-ний өдрийн Японы зүүн хэсгийн их газар хөдлөлтийн үед Монгол Улсын Засгийн газар, газар хөдөлсөн дараагийн өдөр болох 12-ны өдөр Япон Улсад туслах хандивын данс нээж 14-нд тусламжийн бараа болох ноосон хөнжил, ноолууран цамц зэргийг

² Ишлэл:Монгол улсад суугаа Япон улсын элчин сайдын яам"Япон улсаас Монгол улсад үзүүлсэн тусламж" нийтэлсэн он тодорхойгүй, <http://www.mn.emb-japan.go.jp/news/japan.pdf> (хандалт 2016/9/28)

хүргэсэн. Мөн, 1 сая америк долларын Засгийн газрын тусламжаас гадна, төрийн албан хаагч, хотын захиргааны бүх ажилчид 1 өдрийн цалингаа хандивлан тусламж дэмжлэг үзүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын нээсэн хандивын дансанд олон тооны хувийн байгууллага төдийгүй хувь хүмүүсээс 150 сая иений тусламж хуримтлагдсан юм. Түүнчлэн, 2016 оны 4-р сарын 14-нд болсон Кумамотогийн газар хөдлөлтийн үеэр, Монгол Улсын Засгийн газар 50,000 америк долларын тусламж үзүүлэхээр баталж, 8-р сарын 16-нд хүлээлгэн өгчээ³. Энэ мэтчилэн хоёр орны хоорондын харилцаа улам бат бөх болж байна. Мөн, Монгол Улс нь Япон Улсын голлон ач холбогдол өгч буй асуудлуудыг НҮБ-ын хуралдаан дээр дэмждэг найрсаг Улс бөгөөд Япон Улс, Азийн бүс нутаг болон олон улсын тавцанд хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэх түнш юм.

Япон Улсаас 2014 он хүртэлх хугацаанд Монгол Улсад үзүүлсэн тусламжийг, тусламжийн төрөл болон тусламжийн хэмжээгээр дараах хүснэгтэд схемчлэн харуулав.

Хүснэгт 2-2 Хоёр орны ODA-ийн он ба тусламжийн төрлөөр ангилан харуулсан үзүүлэлт
(нэгж: зуун сая иен)

Он	Иений хөнгөлөлттэй зээл	Буцалтгүй тусламж	Техникийн хамтын ажиллагаа
1990 он хүртэлх нийт тусламж	—	56.04	4.66
1991	48.36	33.08	4.02
1992	24.59	39.08	6.81
1993	33.21	45.35	18.10
1994	47.53	59.05	22.72
1995	44.93	58.25	23.37
1996	58.27	48.03	18.13
1997	42.98	50.46	19.33
1998	—	52.75	24.65
1999	—	53.74	19.29
2000	61.39	65.68	19.58
2001	—	55.12	28.45
2002	—	40.60	27.37
2003	—	30.85	24.52
2004	—	18.80	14.69
2005	29.81	40.06	20.46
2006	—	43.30	22.04
2007	288.07	41.34	19.49
2008	—	31.53	16.14
2009	28.94	28.19	18.15
2010	50.00	47.78	16.77
2011	15.50	50.09	24.47
2012	—	34.04	23.62
2013	117.36	31.85	24.17
2014	—	23.94	19.35

(Эх сурвалж : Гадаад хэргийн Яамны хөгжлийн хамтын ажиллагааны тайлан, ODA-ийн тайлан)

Үүнээс гадна, дээр дурдагдсан тусламжаас ЖАЙКА-ийн хэрэгжүүлсэн техникийн хамтын ажиллагааны тусламжийг доорхи хүснэгтэд харуулав.

³ Эх сурвалж: "Сүүлийн үеийн Монгол Улсын байдал ба Япон Монголын харилцаа"
<http://www.mofa.go.jp/mofaj/files/000047765.pdf> (хандалт 2017/1/24)

Хүснэгт 2-3 ЖАЙКА-ийн Монгол дахь техникийн хамтын ажиллагааны тусламж

ЖАЙКА-ИЙН ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА											
Он	ТХА-ны зардал (100 сая иен)	Хэлбэр тус бүрээр (мянган иен)						Хамтын ажиллагааны сайн дурынхан (хүн)		Бусад сайн дурынхан (хүн)	
		Дадлагажигч (хүн)	Мэргэжилтэн (хүн)	Судалгааны баг (хүн)	Тоног төхөөр өмжийн ханди в (сая иен)	ТХА-ны төсөл (төслийн тоо)	Хөгжлийн суд алгаа (судалга аны тоо)	шинэ	үргэлжлэл	шинэ	үргэлжлэл
(1990 он хүртэлхнийг)		114	28	76							
1991	NA	36	8	46	170 (нийт)	0	2	1	0	0	0
1992	6.81	60	8	133	90	0	6	6	1	0	0
1993	18.1	83	27	165	NA	1	8	4	7	0	0
1994	22.72	92	28	206	0	1	7	11	20	0	0
1995	23.37	111	59	205	47.07	1	11	14	18	0	0
1996	18.13	132	65	138	152	1	7	14	25	0	0
1997	NA	104	76	170	177.05	3	9	11	27	0	0
1998	24.65	118	71	295	328.67	3	6	15	25	0	0
1999	19.29	119	74	180	149.96	2	6	19	27	0	1
2000	19.58	132	64	184	173	0	2	29	37	3	0
2001	19.18	132	64	193	211.59	1	1	16	49	6	3
2002	18.33	160	65	161	128.28	2	6	25	45	16	8
2003	15.26	145	48	122	64.57	0	1	20	38	10	18
2004	14.69	180	63	184	108.26	0	1	27	42	7	22
2005	14.57	168	67	67	71.83	3	0	38	47	28	15
2006	16.26	266	120	64	132.03	5	0	29	59	11	32
2007	14.63	353	117	100	225.89	1	0	16	55	8	31
2008	11.54	360	111	86	27.55	0	0	13	37	7	15
2009	12.87	236	171	53	700.7	Нийт тоог гаргаагүй		40	25	13	10
2010	13.15	234	262	11	43.016			24	51	12	19
2011	17.66	262	257	123	93.63			21	55	6	25
2012	17.03	236	253	275	0			20	41	5	18
2013	18.21	238	194	210				33	36	0	10
2014	19.35	284	431	66	төдөрхөйгүй	27	49	1	5		
нийт	403.37	4,107 хүн 5,781,815	2,408 хүн 9,074,321	3,362 хүн 14,872,378				472 хүн 4,482,471	133 хүн 1,357,704		

(Эх сурвалж: ЖАЙКА-ийн жилийн тайлан)

2.3.2 Монгол Улсад үзүүлж буй Япон Улсын тусламжийн чиг хандлага

1991 оноос 2016 он хүртэлх хугацаанд Япон Улсаас Монгол Улсад үзүүлсэн тусламжийн чиг хандлагыг дараах 4 үед хувааж болно.

(1) Эхэн үеийн тусламжийн бодлого (1991 оноос 1995 он хүртэл)

Монгол Улс, эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа буюу 1991-1992 онуудад Японы засгийн газар, монголын иргэдийн амьдралыг тогтворжуулах, дэд бүтцийг дэмжих, экспортыг дэмжих, импортыг орлох хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх, боловсон хүчин бэлтгэхэд онцлон анхаарч тусламж үзүүлж байсан юм. Үүний дараагаар, Монгол Улсын эдийн засгийн өөрчлөлтийн үе болох 1993-1995 онуудад эдийн засгийн хямралаас гарах тусламжаас илүүтэйгээр дунд болон урт хугацааны хөгжлийн тусламж шаардлагатай болж өөрчлөгдсөний дагуу Япон Улсаас үзүүлэх тусламж, яаралтай тусламжийн хэлбэрээс төсөл дээр суурилсан тусламж руу шилжжээ.

Энэхүү хугацаанд Япон Улсаас үзүүлж байсан тусламжийн чиглэл нь:

- 1) Эдийн засаг, дэд бүтцийг сайжруулах (Төмөр замын тээврийн чадавхийг бэхжүүлэх төсөл, Улаанбаатар хотын авто замыг сайжруулах төсөл, Нийтийн тээврийн чадавхийг сайжруулах төсөл зэрэг),
- 2) Хүнсний тусламж, Газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлэх (Махны үйлдвэрийг сайжруулах төсөл, Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг сайжруулах төсөл, үр тарианы агуулах барих төсөл зэрэг),
- 3) Амьжиргааны үндэс суурийг дэмжих (эмнэлгийн үндсэн тоног төхөөрөмжийг нийлүүлэх төсөл зэрэг),
- 4) Өвсний үндэс буцалтгүй тусламж зэргийг дурдаж болно.

(2) Зах зээлийн тогтолцоонд шилжих үеийн тусламжийн бодлого (1996 оноос 1999 он хүртэл)

Монгол Улс 1996-1999 онуудад тусламжийн эрэлт хэрэгцээ нь эдийн засгийн дэд бүтцийг

хөгжүүлэх хэлбэрээс эдийн засаг, мөнгө санхүү, төсвийн удирдлагад холбогдох мэдлэгийн дэмжлэг, боловсон хүчин бэлтгэх зэрэг оюуны дэмжлэг, нөгөө талаас жижиг, дунд аж үйлдвэр, экспортын үйлдвэрийг хөгжүүлэх зэрэг аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих туслалцаа руу шилжиж, өөрчлөгдсөн байна. Япон Улсын Засгийн газар 1997 оны 3-р сард Монгол Улс руу эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааны баг илгээж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөөн дээр үндэслэн, тэргүүлэх салбарыг сонгох, сонгосон салбар тус бүрт хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны тусламжийн бодлогын талаар хэлэлцсэн. Энэ үеэс эхлэн, Монгол Улсад үзүүлэх тусламжийн бодлого (тухайн Улсад хэрэгжүүлэх хөгжлийн хамтын ажиллагааны бодлого)-ын баримт бичгийг зориуд боловсруулах болжээ. Японы ГХЯ-аас боловсруулсан Монгол Улсад үзүүлэх тусламжийн (одоогийн "тухайн улсад хэрэгжүүлэх хөгжлийн хамтын ажиллагааны бодлого" гэгдэх) бодлого доорхи байдлаар өөрчлөгдөж ирсэн байна.

Хүснэгт 2-4 Монгол Улсад үзүүлэх тусламжийн бодлогын өөрчлөлт

Он	1997-2000	2001-2003	2004-2011	2012-
Тусламжийн бодлого	<ol style="list-style-type: none"> 1. Аж үйлдвэрийг дэмжих эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэх 2. Зах зээлийн эдийн засагт шилжиж байгаатай холбогдуулан оюун ухааны салбарт дэмжлэг үзүүлэх, боловсон хүчин бэлтгэх 3. Мал аж ахуй, газар тариалангийн хөгжлийг эрчимжүүлэх 4. Амьдралын эх үүсвэрийг дэмжих 5. Байгалийн нөөцийн менежмент 	<ol style="list-style-type: none"> 1. Зах зээлийн эдийн засагт шилжихэд бодлого, бүтэц, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, боловсон хүчин бэлтгэх 2. Аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих эдийн засгийн дэд бүтэц ба нөхцөл байдлыг бүрдүүлэх 3. Газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлэх 4. Амьдралын эх үүсвэрийг дэмжих 	<ol style="list-style-type: none"> 1. Зах зээлийн эдийн засгийг дэмжих системийг боловсруулах, боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх 2. Орон нутгийн хөгжлийн дэмжлэг 3. Байгаль орчныг хамгаалах дэмжлэг 4. Эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийг боловсруулах 	<ol style="list-style-type: none"> 1. Уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, засаглалыг бэхжүүлэх 2. Бүх нийтэд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэсэн дэмжлэг 3. Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх

(Эх сурвалж: Япон Улсын ГХЯ-ны ODA-ийн тайлан, Улс тус бүрийн тусламжийн бодлого)

(3) Эдийн засгийн хямралын өмнөх үеийн тусламжийн бодлого (2000 оноос 2008 он хүртэл)

2000-2002 онуудад Монгол Улсад зуд болсонтой холбогдуулан Япон Улсын Засгийн газраас мал аж ахуйн тогтвортой менежментийн тогтолцоо, бүтцийг бий болгох тал дээр хамтарч ажиллах болсон. Орон нутгийн амьдрал ахуйн нөхцлийг сайжруулах тал дээр анхаарч, сургуулийн барилга байгууламж болоод харилцаа холбоог сайжруулахад тусламж үзүүлсэн. Мөн, 2002 оноос Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвд суурилсан хувийн хэвшлийн салбарын боловсон хүчинг бэлтгэх дэмжлэг үзүүлж ирсэн. 2004-2008 онд, Монгол Улс зах зээлийн эдийн засагт багтай шилжиж, суурь нь бөх болсон боловч, баян ядуугийн ялгаа эрс нэмэгдэж эхэлсэн. Түүнчлэн, хот хөдөөгийн ялгаа ихсэж, эдийн засгийн дэд бүтэц болох зам тээврийн салбар, нийгмийн дэд бүтэц болох боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хэмжээ буурч, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бүрэлдээгүй, хүний нөөцийн хомсдол гэх мэт олон төрлийн асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай болсон.

Энэ үеийн онцгойлон дурдах ёстой зүйл бол, 2006 онд тухайн үеийн төрийн тэргүүд харилцан айлчлал хийж Монгол, Японы Иж бүрэн түншлэл амжилттай хөгжиж ирснийг тэмдэглээд ирэх 10 жилд харилцааг шинэ шатанд гарган хөгжүүлэх үүднээс “10 жилийн үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжүүлэхээр санал нэгдсэн явдал юм.

Энэ үед Монгол Улсын засгийн газар Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжиж Ядуурлыг Бууруулах Стратеги (EGSPRS)-г боловсруулж, 2003 оны 9-р сард энэхүү стратегийн баримт бичгийг Дэлхийн Банк болон ОУВС-д албан ёсоор хүлээн зөвшөөрүүлжээ. Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжиж

Ядуурлыг Бууруулах Стратеги EGSPRS нь, Монгол Улсын Засгийн газраас эхлэн, хандивлагч донор, ТББ-аас гадна, ядуу болон нийгмийн эмзэг давхаргынхныг хамарсан өргөн хүрээнд ард түмний санал бодлыг тусгасан эдийн засгийн болон нийгмийн тэнцвэртэй хөгжлийн стратегийн баримт бичиг болсон юм⁴.

Монгол Улсын Засгийн газар нь, 2005 оны "Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр"-т (National Development Programme of Mongolia) тулгуурлан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод (Millennium Development Goals-MDG) суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ыг боловсруулж, 2008 онд УИХ-аар батлуулжээ.

(4) Эдийн засгийн хямралын дараах үеийн тусламжийн бодлого (2009 оноос өнөөдрийг хүртэл)

Лийман шок⁵-оос үүдсэн эдийн засгийн хямралын дараа 2009-2011 он хүртэл, Монгол Улсад үзүүлэх тусламжийн тэргүүлэх чиглэл дээр нэмж, уул уурхайн салбараас хамааралтай байсан аж үйлдвэрийг олон талт болгож хөгжүүлэх, Улаанбаатар хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулахад чиглэсэн дэмжлэг үзүүлэхэд хүч анхаарлыг хандуулахаар болсон. Мөн, 2009 онд Монголын эдийн засгийн уналт -1,3% болж унасныг харгалзан, ОУВСангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжиж, Япон болон Дэлхийн Банк (WB), Азийн Хөгжлийн Банк (ADB)-аас зээл, тусламж үзүүлэхээр болсон. ОУВСангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд Япон Улсын Засгийн газраас 2009 онд Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөр (1-р шат)-ийн хүрээнд 2 тэрбум 894 сая иенийн зээлийг⁶, 2011 онд дээрхи хөтөлбөрийн (2-р шат)-ны хүрээнд 1 тэрбум 55 сая иенийн зээлийг тус тус олгосон.

2012 оноос хойш, Япон Улсаас Монгол Улсад үзүүлж байгаа тусламжийн үндсэн чиг баримтлал (хэтийн зорилт)-ыг "Эдийн засгийн тогтвортой өсөлтөөр дамжуулан ядуурлыг бууруулахад чиглэсэн Монгол Улсын бие даасан хүчин чармайлтыг дэмжих" явдал гэж тодорхойлоод,

- 1) Монгол Улсын эдийн засгийн цаашдын хөгжлийн гол түлхүүр болох уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, тус салбарын хүний нөөцийг хөгжүүлэх
- 2) Уул уурхайн салбарын орлогын зохистой менежментийг бүрдүүлэхэд чиглэсэн засаглалыг бэхжүүлэх
- 3) Аж үйлдвэрийг төрөлжүүлэхийг зорьж, жижиг дунд болон бичил үйлдвэрлэлийн салбарт ажлын байр нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах
- 4) Улаанбаатар хотын дэд бүтцийн бүтээн байгуулалт болон хот төлөвлөлт, менежментийн чадавхыг сайжруулах гэсэн чиглэлүүдийг тэргүүлэх чиглэлээр авч, хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

2.4 Япон Улсын тусламжийн бодлого ба сайн дурын гишүүдийг илгээх төлөвлөгөө

ЖАЙКА-ийн сайн дурынхныг илгээх хөтөлбөр нь, Монгол Улсын бодлого болон Япон Улсаас үзүүлж буй зээл тусламжийн бодлогын дагуу хэрэгжиж байгаа бөгөөд, 2016 оны 4-р сарын байдлаар Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө (хөтөлбөрөөр ангилсан) ба сайн дурын гишүүдийн оролцоо нь дараах байдалтай байна.

⁴ Ишлэл: ГХЯ-ны улс тус бүрийн мэдээллийн ном, Монгол улс 2005 он

⁵ Lehman шок - 2008 оны 9-р сарын 15-ны өдөр АНУ-ын хөрөнгө оруулалтын Lehman Brothers банк дампуурснаас дэлхийн санхүүгийн хямрал үүссэн үйл явдлыг ерөнхийлөн нэрлэдэг. англи үгний японжсон хэлбэр бөгөөд, ихэвчлэн "the financial crisis (of 2007-08)" гэдэг. <https://ja.wikipedia.org/wiki/%E3%83%AA%E3%83%BC%E3%83%9E%E3%83%B3%E3%83%BB%E3%82%B7%E3%83%A7%E3%83%83%E3%82%AF>

⁶ Эх сурвалж: "Сүүлийн үеийн Монголын эдийн засаг"

<http://www.mn.emb-japan.go.jp/news/EconomyofMongolia2011Aug.pdf> (хандалт 2017/1/24)

Хүснэгт 2-5 Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө (2016 оны 4-р сар)

Хөгжлийн асуудлууд	Хамтын ажиллагааны хөтөлбөрийн нэр	Сайн дурынхны мэргэжлийн төрөл
Уул уурхайн салбарын тогтвортой хөгжил болон засаглалыг бэхжүүлэх	Уул уурхайн салбарын хөгжлийн менежментийг бэхжүүлэх хөтөлбөр	—
	Засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр	—
Бүх нийтэд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэсэн дэмжлэг	Хувийн хэвшлийг дэмжих хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжийг хөгжүүлэх • Мэргэжил олгох сургалт • Орон нутгийн хөгжил
	Хөдөө аж ахуйн менежментийг дэмжих хөтөлбөр	—
	Нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> • Боловсрол • Биеийн тамир, сэтгэл зүйн боловсрол • Эрүүл мэнд, эмчилгээ • Халамж
Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх	Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах

(Эх сурвалж: Японы ГХЯ-с Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө 2016 оны 4-р сар)

2005 онд Монгол Улсын Боловсролын яамнаас гаргасан "Шинэ үндэсний стандарт"-ын бодлоготой уялдуулан боловсролын салбарын сайн дурын гишүүнийг анх илгээснээр сайн дурынхны хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн юм. Энэ нь, томилогдон очсон газарт нь хэдийгээр шийдвэрлэх асуудал олон байлаа ч, нэг сайн дурын гишүүн тодорхой нэг асуудлыг шийдвэрлэх зорилттой очиж байгаа тул түүндээ л анхаарлаа төвлөрүүлэхээс өөр аргагүй болдог нөхцөл байдлыг засч залруулах үүднээс анхны үеийн сайн дурынхны зохицуулагчид /одоогийн төслийн зохицуулагч/ томилогдон очсон сайн дурын гишүүний "цэгийн" үйл ажиллагааг холбогдох байгууллагын үйл ажиллагаатай холбон өгч үйл ажиллагааны хүрээг нь тэлэх талаар бодож ирсэнтэй холбоотой юм.

2011 оны 9-р сар, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар "Сайн дурын гишүүдийг цаашид томилоход баримтлах үндсэн бодлого"-ыг тодорхойлсноор хүсэлт гаргах удирдамж болж өгсөн юм.

3-Р БҮЛЭГ. ЭХЭН ҮЕИЙН ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээр байгуулав

Монгол Улстай байгуулсан “Японы далайн чанад дахь сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээр”-т 1991 оны 3-р сарын 26-ны өдөр Токио хотод, Японы ГХЯ-ны сайд Накаяма Таро болон Монголын ГХЯ-ны сайд Цэрэнпилийн Гомбосүрэн нар гарын үсэг зурав. Ингэснээр Монгол Улс ЖАЙКА-ийн сайн дурынхан үйл ажиллагаагаа явуулах 53 дахь улс болсон.

ЖАЙКА-ийн сайн дурынхан монголд томилогдох болсон нөхцөл байдлыг тухайн үеийн Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн байдалтай уялдуулан танилцуулбаас:

3.1.1 Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүдийг хүлээн авах тухай хэлэлцээртэй холбогдуулан Монгол Япон хоёр орны авч явуулсан арга хэмжээ

Анхны зохицуулагчийн үүргийг гүйцэтгэж байсан Ооно Тацүогийн хэлснээр 1990 оны 3-р сард МАХН төрийн эрхээс буусны дараагаар, ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих нь тодорхой болж Монгол Улсын ГХЯ, Япон Улсын ODA-г хүлээн авах бэлтгэл ажлаа эхлүүлсэн. Оросод япон хэл сурсан Монгол Улсаас Япон Улсад суугаа элчин сайд Хүрэлбаатар (2016 оны байдлаар) болон Япон Улсын буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн Говь ноолуурын үйлдвэрийн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор Шиншюүгийн их сургуулийн нэхмэл сүлжмэлийн факультетэд суралцсан Жигжидийг татан авч, хүний нөөцөө бэлтгэсэн.

Социалист нийгэм нуран унахын хамт, зах зээлийн эдийн засагт шилжих сонголт хийсэн Монгол Улсад үр ашигтай дэмжлэг үзүүлэхийг зорьж байсан Япон Улсын ЭСЯ-аас хамтын ажиллагааны сайн дурынхныг илгээх шаардлага байгаа тухай дүгнэлт гаргаж, ГХЯ-аар дамжуулан Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (одоогийн ЖАЙКА)-д сайн дурынхныг илгээх талаар судлаж үзэхийг хүссэн⁷.

1990 оны хавар, эдийн засаг хамтын ажиллагааны багийг илгээж, ГХЯ-ны эдийн засаг хамтын ажиллагааны газар техникийн хамтын ажиллагааны 1-р хэлтсийн даргаас, Монгол Улсад Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхны үйл ажиллагааг танилцуулсан байна⁸.

Японы ГХЯ-аас Монгол Улсад сайн дурынхныг илгээх талаар судалгаа хийх зааварчилгаа авсан хамтын ажиллагааны сайн дурынхны албанаас Монгол Улсын нийгмийн нөхцөл байдал, амьдрал ахуйн талаар мэдээлэлгүй байснаас гадна өвлийн улиралд -30 хэм хүртэл хүйтэрдэг бүсэд гишүүдээ явуулж байсан туршлагагүй байсан тул бодит байдлын тухай ойлголттой болохын тулд 1990 оны 10-р сард богино хугацааны мэргэжилтэнг 3 сараар томилж ажиллуулсан⁹.

Ийнхүү Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхны үүсгэн байгуулалтад гар бие идэвхитэй оролцож байсан Ерөнхий сайд Кайфү Тошикигийн үед социалист нийгмээс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад Монгол Улсад үзүүлэх тусламжийн нэг төрөл болгон Токио хотноо 1991 оны 3-р сарын 26-ны өдөр “Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурагджээ.

3.1.2 Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг томилох бэлтгэл шат

“Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурснаас хойш 3 сарын дараа, Ватанабэ Сэйго (Томилгооны 1-р хэлтсийн дарга)-гоор ахлуулсан урьдчилсан судалгааны баг 1991 оны 6-р сарын 22-ны өдрөөс 26-ны өдөр хүртэл Монгол Улсад судалгаа хийсэн. Энэхүү багт оролцож байсан Ватанабэ Хажимэгийн хэлснээр, судалгаа хийхээр японоос хөөрөх үед Монгол дахь хөтөлбөр, уулзах хүн очих газар зэрэг бүгд

⁷ Ишлэл: Баасан 50 дахь дугаарын тусгай нийтлэл Элчин сайд Такэнори Шимизү

⁸ Японы ЭСЯ-ны Элчин сайд Шимизү Такэноригийн ярианаас

⁹ Японы ГХЯ-ны ажилтантай хийсэн ярианаас

тодорхойгүй байсан боловч, Буянт-Ухаа нисэх онгоцны буудалд буухад Монголын Худалдаа аж үйлдвэрийн яамны ажилтан Л.Насанбуян, Японы ЭСЯ-ны орчуулагч эмэгтэй нар судалгааны хөтөлбөрийг анх танилцуулж байсан. Монгол Улсад суугаа Япон Улсын ЭСЯ дээр очиход Элчин сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчээс Монгол Улс нь Япон Улсын аж үйлдвэрийн дэвшилтэт техник технологийг маш ихээр сонирхож байгааг ярьж, Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг яаралтай томилон ирүүлэхийг хүсч байжээ. Судалгааны багийн хөтөлбөр болон айлчлах байгууллагын нэрсийг Монголын Худалдаа аж үйлдвэрийн яам бэлтгэсэн ажээ. Судалгааны хүрээнд Монголд уулзсан хүлээн авагч байгууллагууд нь бүгд Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүнийг хүлээн авахад маш идэвхтэй байр суурь баримталж байгааг мэдэрсэн. Айлчилсан газруудад: Боловсролын яам, Техникийн их сургууль, Гадад хэлний дээд сургууль, МУИС, АНУ-ын Энх тайвны корпус, Хөдөө аж ахуйн яам, археологийн мэргэжилтэн шаардагдах үндэсний музей тус тус оржээ. Мөн амьдрах орчны судалгааны хүрээнд эмнэлэг, зах зэргийг үзэж танилцсан.

Судалгааны үеэр, “Японы долоо хоног” өдөрлөгийн арга хэмжээ санамсаргүй давхцаж, наадмын талбайд Японы рок хамтлаг тоглолт хийж, Япон Улстай харилцаа холбоо тогтоох эхлэл тавигдсан байв. Томилогдон ирэх гишүүд хоол хүнс худалдан авах тал дээр санаа зовоох зүйл байсан хэдий ч шинээр үйл ажиллагаагаа явуулах улс орон гэхэд онц гойд хүндрэл байхгүй гэсэн сэтгэгдэлтэйгээр судалгааг дуусгажээ.

3.1.3 Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг илгээх бэлтгэл ажил

1991 оны 8-р сард (тухайн үеийн) Япон Улсын Ерөнхий сайд Тошики Кайфү Монгол Улсад анх удаа албан ёсны айлчлал хийсэн. Ардчилсан нийгэмд шилжсэн Монгол Улс эдийн засгийн хувьд хямарсан, олон Улсын дэмжлэг шаардлагатай байсан. Тухайн оны 3-р сард Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан Япон Улсын ГХЯ-ны сайд Накаяма ч мөн адил энэ удаагийн албан ёсны айлчлалын гишүүнээр хүрэлцэн ирсэн. Сонинд бичсэнээс үзэхэд, Япон Улсын Ерөнхий сайд Тошики Кайфү "Монгол Улсыг олон улсаас зээл тусламж авах тогтолцоог бүрдүүлэхэд Япон Улс идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ" гэдгийг илэрхийлж, ОДА-ийн хүрээнд “Олон Улсын харилцаа холбооны сүлжээ байгуулах төсөл” (буцалтгүй тусламж), “Улсын Филармонид хөгжмийн зэмсэг худалдан авах төсөл”, 2 тэрбум иений Япон Улсын Засгийн газрын “Төслийн бус буцалтгүй тусламж”¹⁰, “Улаанбаатар хотын IV-р ДЦС-ын үр ашгийг дээшлүүлэх төсөл” (буцалтгүй тусламж) болон “Мэргэжилтэн илгээх тусламж” үзүүлэхээр болсон гэжээ¹¹.

Япон Улсын Ерөнхий сайд Тошики Кайфү Монгол Улсад айлчилсанаас хойш 1 сарын дараа буюу 9-р сард, Токио хотноо "Монгол Улсад хандивлагч орнуудын анхдугаар зөвлөлдөх уулзалт"¹²-ыг зохион байгуулсан. Монголын тал, ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих тухайгаа зарлаж, 1990 онд ЗХУ задран, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагаа задарсан нь Монгол Улсын эдийн засгийн байдалд хүндээр тусч байгаа тухай ярьж, нийгмийн бухимдлыг багасгахын тулд яаралтай туслалцаа үзүүлэхийг хандивлагч орнуудаас хүссэн байна. Ерөнхий нарийн бичгийн дарга Аокигийн хэлснээр, хандивлагч орнуудын уулзалтыг даргалсан Япон Улсын хувьд Монгол Улсын Засгийн газрын Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг яаралтай илгээх тухай хүсэлтэд үндэслэн, хамтын ажиллагааны гишүүдийг хүлээн авах тухай хэлэлцээр байгуулагдаж, урьдчилсан судалгааны баг хүсэлтийн агуулгыг тодруулах судалгаа

¹⁰ Монгол улсын эдийн засгийн бүтцийг сайжруулах хуримтлагдсан өр нь нэмэгдэж, төлбөрийн тэнцэл алдагдаж эдийн засгийн байдал хүндэрч гүнзгийрсэн Хөгжиж буй орнууд Дэлхийн банк болон Олон улсын валютын сан гэх мэт байгууллагатай хамтран ажиллаж, зохицуулалт хийн эдийн засгийн бүтцийг сайжруулахад шаардлагатай бүтээгдэхүүнийг худалдан авахад зориулагддаг ба 1987 онд байгуулагдсан. Барилга байгууламж болон гамшгийн үеийн тусламж гэх мэт үйл ажиллагаа (төсөл)-д зориулагдах санхүүгийн тусламж биш учир "Төслийн бус буцалтгүй тусламж" гэж нэрлэдэг.

¹¹ Эх сурвалж: 1991 оны 8-р сарын 14-ний, Асахи сонин

¹² Хандивлагч орнуудын анхдугаар хурал (1991 оны 9-р сард Токио хотноо зохион байгуулагдаж, 14 улсын, 5 олон улсын байгууллага оролцсон): Тусламжийн нийт дүн: 150 сая ам.доллар байсан. 10-р хурал (2003 оны 10-р сар Токио) хүртэл хуралдсан.

явуулсныг харгалзан аль болох ойрын хугацаанд “Сайн дурынханыг зохицуулах газар”-ын албан байрыг байгуулж, эхний ээлжийг илгээхээр болсон.

Нөгөөтэйгүүр, “Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхны нарийн бичгийн даргын газар”-аас хүйтэн бүс рүү илгээх хамгийн анхны илгээлт болохыг харгалзан, 1-р ээлжийн багийг хүйтний эрч суларсан 1992 оны 4-р сараас эхлэн томилохоор болж, төлөөлөгчийн газрыг байгуулах бэлтгэл ажлаа эхлүүлж, 1991 оны 12-р сард анхны төлөөлөгчийн газрын ажилтан, зохицуулагчийг¹³ сонгосон.

3.1.4 Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг бүртгэх, сонгох

Монгол Улсаас Япон Улсын дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, их дээд сургуулиудад хичээл заалгах хүсэлтэй байсан ба хүсэлт гаргасан мэргэжлийн төрөл нь: япон хэлний багш, эмэгтэй болон хүүхдийн хувцас, дотоод засал чимэглэл, системийн инженер, цахим инженер, цахим тоног төхөөрөмж, каратэ, жүдо, гар бөмбөг зэрэг байсан.

Сонгон шалгаруулалтын хувьд, Монголын талын хүсэлтэд нийцүүлэхээс гадна, гишүүдийг хурдан томилох үүднээс 1991 оны хаврын сонгон шалгаруулалтад тэнцэгсдээс багийн гишүүдэд нэр дэвшүүлсэн. Хаврын сонгон шалгаруулалтад Монгол Улсын нэр дурдагдаагүй байсан боловч, сонгон шалгаруулалтын 3-р шатанд тэнцэгсдтэй харилцан ярилцсаны үр дүнд япон хэлний багш 2 хүн, эмэгтэй болон хүүхдийн хувцасны мэргэжилтэн 1 хүн тус тус томилогдохоор болсон. 1991 оны намрын сонгон шалгаруулалтаас эхлэн Монгол Улсын нэр дурдагдсан. Монголын талаас тавьж буй шаардлага маш өндөр байсан тул шаардлагад нийцэх боловсон хүчин олж сонгоход хүндрэлтэй байснаас 2-р ээлжинд 2 хүн, 3-р ээлжинд 2 хүн томилогдсон. (Ооно зохицуулагчтай хийсэн ярианаас иш татав).

3.1.5 Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүний илгээлтийн өмнөх бэлтгэл ажил

1-р ээлжийн гишүүдийн хэлний бэлтгэлийг Д.Наранцэцэг багш Комаганэ бэлтгэлийн төв дээр 3 сарын хугацаатай явуулсан. Томилогдон очих газрын нөхцөл байдлын талаар лекцийг хэлний бэлтгэлийн сургалт эхлэхийн өмнөхөн Монгол Улсын 23-р дунд сургуульд Оосакагийн их сургуулиас япон хэлний багшаар томилогдон ажиллаж байсан Табучи Хитоши хариуцан уншсан. 2-р ээлжийн гишүүдийн хэлний бэлтгэл нь Комаганэ бэлтгэлийн төв дээр 79 хоногийн хугацаатайгаар явагдсан. Томилогдох гэж буй газрын нөхцөл байдлын талаарх хичээлийг Азийн Их Сургуулийн захирал асан, хүндэт профессор Коибүчи Шин-ичи хариуцаж явуулсан. Коибүчи багш Японы ЭСЯ-нд томилогдож байсан туршлагатай тул, олны мэдэхгүй Монгол Улсыг танилцуулж, бэлтгэлд хамрагдаж буй гишүүдийн сэтгэл зовнилыг алга болгоход хүчин чармайж байв. Монгол хэлний багш Наранцэцэг нь 1991 онд Япон Улсад ирж, Монгол Улсад томилогдох гишүүдийг 1-р ээлжээс эхлэн хариуцаж, өнөөдрийг хүртэл Нихонмацу бэлтгэлийн төв дээр багшаар ажиллаж байгаа билээ¹⁴. Коибүчи болон Нарантуяа багш нар монгол хэл суралцагсад зориулж “монгол хэлний хэлц үгсийн жишээ” номыг хамтран бичиж Дайгакүшёорин компаниар хэвлүүлэн гаргасан байдаг.

3.2 ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны эхлэл

3.2.1 Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурын гишүүний томилолт

1992 оны 4-р сарын 9-ний өдөр, Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхны 1-р ээлжээр (1991 оны японы санхүүгийн жилийн 3-р бүлэг) Обата Масахико (япон хэл, Гадаад хэлний дээд сургуульд), Мүраками Ёшифүми (япон хэл, 23-р дунд сургууль) нар Монгол Улсад томилогдсон бөгөөд тэд Бээжингээр дамжин Буянт-Ухаа нисэх онгоцны буудалд буусан байна. Хоёр долоо хоногийн өмнө төлөөлөгчийн газраа шинээр байгуулж гишүүдийг хүлээн авах бэлтгэл ажлаа хангасан зохицуулагч ба харъяалагдан очиж буй холбогдох байгууллагууд халуун дотноор хүлээн

¹³ Өнөөдрийн байдлаар "төслийн зохицуулагч (сайн дурын ү.а)" боловч, энэ бүлэгт тухайн үеийн нэрийг ашиглав

¹⁴ Наранцэцэг багш 2016 оны хичээлийн жилээр ажлаа хүлээлгэж өгөх төлөвлөгөөтэй байгаа.

авч, ажилдаа орсон байна. Гэмтэл авч эмчилгээний улмаас 4-р сарын томилолтоор явж чадаагүй Киношита Акико гишүүн (оёмол хувцасны Тахь корпораци) 5-р сарын 29-нд ажлаа хүлээн авсан. 1992 оны 7-р сарын 16-ны өдөр, 2-р ээлжийн (1992 оны японы санхүүгийн жилийн 1-р бүлэг) 2 гишүүн (япон хэл, дотоод засал чимэглэл)-ий хувьд ч мөн адил харьяалагдан очиж буй холбогдох байгууллагууд нисэх онгоцны буудал дээр хүлээн авч, баяртай байгаагаа илэрхийлсэн. 3-р ээлжийн (1993 оны японы санхүүгийн жилийн 1-р бүлэг) 2 гишүүн (системийн инженер) 1993 оны 7-р сард ажилдаа орсон. 1 жил томилгоо байхгүй өнжсөн боловч энэ нь Монгол Улсаас ирүүлсэн хүсэлтийн шаардлага өндөр байснаас Япон Улсад зохион байгуулсан шалгаруулалтад тэнцэх хүн гараагүйгэй холбоотой байлаа. Гэсэн хэдий ч, үүний дараагаар гишүүдийг тогтвортойгоор илгээн, мэргэжилтнүүдээр хангаж байжээ.

3.2.2 Далайн чанад дахь ахмад сайн дурын гишүүдийг илгээж эхэлсэн нь

Далайн чанад дахь ахмад сайн дурынхан (SV) гэдэг нь 1996 оны ахмад хамтын ажиллагааны мэргэжилтэн гэдэг үгнээс өөрчлөн гаргасан нэршил бөгөөд 1999 оны 7-р сард (тухайн үеийн) Япон Улсын Ерөнхий сайд Обүчи Кейзогийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр, “Япон Улсын ахмад сайн дурынхныг хүлээн авах тухай протокол”-д гарын үсэг зурсан байна. 2000 оны 11-р сард Монгол Улс руу 3 гишүүн (бизнесийн менежмент, чанарын менежмент, төгөлдөр хуурын тохиргоо) илгээснээр SV үйл ажиллагаа эхэлжээ. Үүнээс хойш хүсэлт гарах мэргэжлийн төрөл, японы Го даам, хот төлөвлөлт, агаарын теннис, газар хөдлөлтөд тэсвэртэй архитектур дизайн, менежментийн дадлага, ашиг шимтэй ургамлын нөөцийг хөгжүүлэх, материалын шинжлэх ухаан, мэдээллийн инженер, япон хэл, ерөнхий архитектур, машины засвар үйлчилгээ, нийгмийн халамж, удирдлагын менежмент (Эрдэнэт), агаарын тээврийн үйлчилгээ, геофизик, уул уурхайн удирдлагын менежмент, суурь боловсрол, олон Улсын удирдлагын менежмент, музей судлал, хот төлөвлөлт гэх зэргээр өргөн хүрээг хамрах болж, олон жилийн туршид хуримтлуулж ирсэн техник технологио хуваалцсан нь үр дүнгээ өгсөн юм.

Эрдэнэт хотод удирдлагын менежментээр 2005 онд гишүүн илгээснээр орон нутгийн томилгоо эхэлжээ. Мөн IV-р ДЦС-д 2002 оны 11-р сард багаар илгээлт хийсэн ба холбогдох салбаруудаар ангилан нэг дор 7 гишүүнийг, 2005 онд 4 гишүүнийг томилжээ. 2007 оны 11-р сард ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар нээгдсэний 10 жилийн ой тохиож, хэрэгжүүлж ирсэн төслүүд дотроос тусламжийн үр өгөөж өндөр, төсөл амжилттай хэрэгжсэн байгууллагаар IV-р ДЦС-ыг тодруулж сайшаасан байна. Үүний дараа, 2008 онд 1 гишүүн, 2009 онд 2 гишүүн, 2010 онд 1 гишүүн, 2011 онд 2 гишүүнийг цахилгаан станцын хяналт шалгалт, засвар үйлчилгээнд илгээж хувь нэмэр оруулсан. SV нь 2016 оны 10-р сарын эцэс хүртэлх хугацаанд 135 гишүүн томилсон байна.

3.2.3 ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын өөрчлөлт

ЖАЙКА-ийн төлөөлөгчийн газар нь 1992 оны 3-р сард Улаанбаатар зочид буудлын 1 өрөөг түр оффисоор ашиглан, нээгдэж байсан бөгөөд тус оны 8-р сарын 1-ний өдөр Худалдаа Аж Үйлдвэрийн яамны 11-р давхарт шилжин, төлөөлөгчийн газраа албан ёсоор нээсэн байна. 1997 оны 1-р сарын 1-ний өдөр “Сайн дурынханы төлөөлөгчийн газар”-аас ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар болгон нэрээ шинэчилж өөрчилснөөр хуучин Япон Улсын ЭСЯ-ны байранд нүүн орж ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар болгон нээлтээ хийсэн. Үүний дараагаар, 2003 оны 12-р сард Vodi Tower-ын 7-р давхарт нүүн орж, өнөөдрийг хүрчээ. Энэ хугацаанд “Гишүүдийн холбоо барих газар”-ыг байршлыг тодруулахад эхэндээ хүндрэл гарч байсан боловч, аажмаар шийдвэрлэгдэснийг дурдах нь зүйтэй.

Хүснэгт 3-1 Гишүүдийн холбоо барих газрын өөрчлөлт

Хугацаа	Газар
1992 оны 3 сар-1994 оны 7 сар	Холбоо барих газар байхгүй
1994 оны 8 сар-1995 оны 6 сар	Зохицуулагч гишүүдийн гэрийн хажуугийн өрөө (Гадаадын иргэдийн тусгай байр)
1995 оны 7 сар-1996 оны 12 сар	Дипломат корпусынхны орон сууц
1997 оны 1 сар-2003 оны 12 сар	ЖАЙКА-ийн төлөөлөгчийн газрын байран дотор
2003 оны 12 сар- өнөөдөр	Сүхбаатар дүүргийн Шүрэн билдинг 4 давхар

(Эх сурвалж: холбогдох байгууллагууд, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга, төслийн зохицуулагч нарын ярилцлагаас)

4-Р БҮЛЭГ. ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОЛТ АМЖИЛТ

4.1 ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны үзүүлэлт

4.1.1 ЖАЙКА-ийн сайн дурынхан томилогдсон он болон мэргэжил тус бүрээр ангилан харуулсан үзүүлэлт

ЖАЙКА-гаас илгээсэн сайн дурын гишүүдийн тоог онд харгалзуулан гаргавал, доорхи хүснэгтийн дагуу байна. Үүнд: 2016 оны 10-р сарын эцсийн байдлаар нийт 643 гишүүн байна. 1991 оны эхний илгээлтийн дараагаар, 1994 онд томилогдсон гишүүдийн тоо жилд 2 оронтой (12 гишүүн) болж, 1998 онд жилд 20 гишүүн болжээ. 2002 онд жилд 40 гишүүн илгээх хэмжээнд хүрч, 2009 онд өнгөрсөн хугацаанд хамгийн их болох жилд 56 гишүүнийг томилсон байна. Сүүлээр, тухайн жилээс хамааран томилогдох гишүүдийн тоо өөрчлөгдөж байсан ч, жилд 30 гаруй гишүүдийг томилж байсан байна.

Хүснэгт 4-1 ЖАЙКА-аас томилогдсон сайн дурын гишүүдийн тоо, он тус бүрээр

Он	Нийт	Илгээгдсэн гишүүдийн хэлбэр					
		JOCV	SV	Ахмад гишүүн*1	Богино хугацаа (залуу)*2	Богино хугацаа (ахмад)*3	НҮБ сайн дурын ажилтан*4
1991	3	3	—	—	—	—	—
1992	2	2	—	—	—	—	—
1993	7	7	—	—	—	—	—
1994	12	12	—	—	—	—	—
1995	11	11	—	—	—	—	—
1996	10	10	—	—	—	—	—
1997	10	9	—	—	—	—	1
1998	20	20	—	—	—	—	—
1999	22	22	—	—	—	—	—
2000	28	25	3	—	—	—	—
2001	25	15	6	1	2	1	—
2002	40	19	19	—	2	—	—
2003	30	19	10	1	—	—	—
2004	48	25	19	—	1	2	1
2005	38	24	10	2	2	—	—
2006	41	21	9	—	8	2	1
2007	25	15	5	—	1	4	—
2008	20	12	5	—	2	1	—
2009	56	42	13	—	1	—	—
2010	33	19	13	—	1	—	—
2011	26	19	5	—	2	—	—
2012	25	20	5	—	—	—	—
2013	33	32	—	—	1	—	—
2014	28	27	1	—	—	—	—
2015	35	33	2	—	—	—	—
2016 (10сар дуустал)	15	—	—	—	—	—	—
нийт	643	463	125	4	23	10	3

ТАЙЛБАР:*1 : JOCV туршлагатай, ахмад гишүүдийн хэлний шалгалтад тэнцсэн, шуурхай дайчин байхын зэрэгцээ ялангуяа дэвшилтэт мэргэжлийн болон хэлний чадвартай, орон нутгийн нөхцөл байдлын

【Тодруулга: ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газарт илгээж буй гишүүдийн мэргэжлийн төрлийг харуулсан хүснэгт】

Ерөнхий ангилал	Бүдүүвчилсэн ангилал	Нарийвчилсан ангилал	Тайлбар
Бүх нийтэд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэсэн дэмжлэг	Аж үйлдвэрийн салбарыг төрөлжүүлэхийн тулд ЖДҮ-г голлон анхаарах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжийг хөгжүүлэх	ХАА-н салбарыг хамарна Аж үйлдвэрийн нийгэмлэг болон холбоодын мэргэжилтэн зэргийг хамарна
		Мэргэжил олгох сургалт	Их дээд сургууль, мэргэжил олгох сургууль, коллеж зэрэг боловсролын байгууллагуудын техникийн холбоотой мэргэжил
		Орон нутгийн хөгжил	Сумын хөгжлийг дэмжих гишүүд, олон нийтийн хөгжлийг хамарна
	Нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах	СӨБ	—
		Бага, дунд, бүрэн дунд боловсрол	Биеийн тамирыг хамарна
		Биеийн тамир, сэтгэл зүйн боловсрол	Залуучуудын үйл ажиллагааг хамарна
		Япон хэл	—
		Эрүүл мэнд	—
		Сэргээн засах эмчилгээ	—
	ХБИ-дэд үзүүлэх дэмжлэг	Нийгмийн ажилтанг хамарна	
Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх		Байгаль орчныг хамгаалах	Байгаль орчны боловсрол орно
		Дэд бүтэц, хот төлөвлөлт, хот байгуулалт	—
Бусад			Японы Го даам, радио телевизийн газрын мэргэжилтэн, яам, агентлаг зэрэг албан газрын компьютерийн мэргэжилтэн, музей, соёлын газар гэх мэт

(Эх сурвалж: ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

4.1.2 ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн орон нутаг дахь үйл ажиллагаа

Доорхи графикт, нийслэлд томилогдсон сайн дурын гишүүдийг (хөх өнгөөр) мөн орон нутагт томилогдсон гишүүдийг (улбар шар өнгөөр) илэрхийлж харьцуулсан болно. Орон нутаг дахь үйл ажиллагаа нь 1994 онд эхэлж, 1998 оноос орон нутагт ажиллаж буй сайн дурын гишүүд тодорхой хувийг эзлэх болсон. 2012 онд нийслэлд болон орон нутагт ажиллах сайн дурын гишүүдийн харьцаа хөрвөж, орон нутагт томилогдох гишүүд дийлэнх хувийг эзлэх болсон байна.

Нийслэл Улаанбаатар хотод (Багануур дүүрэг орсон) 2016 оны 10-р сарын сүүл гэхэд 421 гаруй сайн дурын гишүүн томилогдсон. Улаанбаатар хот руу илгээх томилолт эхэндээ алгуурханаар өсөж байсан боловч 2000-2005 онуудад огцом өссөн байна. 2005 оны үеэс SV-ийн илгээлт ихсэж, өнөөдрийг хүртэл тодорхой хэмжээний гишүүдийг илгээсээр байгаа боловч сүүлийн жилүүдэд, JOCV, SV-ийн аль алиных нь илгээлтийн тоо цөөрч байна.




График 4-2 Нийслэл болон орон нутаг дахь сайн дурынхны харьцаа, он тус бүрээр
(Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

Эхний илгээлтээс 3 жилийн дараа буюу 1995 оны 2-р сард, нийслэл Улаанбаатар хотоос өөр хот болох Орхон аймгийн Эрдэнэт хотод гар бөмбөгийн гишүүн томилогдсон. Дараагийн 1996 оны 12 сараас 1999 оны 12-р сар хүртэлх хугацаанд, тус аймгийн биеийн тамирын хороонд ахин гар бөмбөгийн гишүүн томилогдсон. Энэ нь орон нутаг дахь үйл ажиллагааны эхлэл болсон юм.

2000 оны эцэс гэхэд 129 гишүүн илгээснээс, 108 гишүүн нь Улаанбаатар хотод томилогдсон байсан ба энэ үед Монгол Улсын 2 дахь том хот болох Дархан-Уул аймгийн Дархан хотод 16 гишүүн, Орхон аймгийн Эрдэнэт хотод 5 гишүүн томилогдсон байжээ.

Хүснэгт 4-2 ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн бүс нутагт хуваарилагдсан байдал

Бүс нутаг	Гишүүдийн тоо	Бүс нутаг	Гишүүдийн тоо	Бүс нутаг	Гишүүдийн тоо
Улаанбаатар хот	422	Говьсүмбэр аймаг	9	Говь-Алтай аймаг	5
Дархан-Уул аймаг	60	Дорноговь аймаг	9	Ховд аймаг	5
Орхон аймаг	29	Өмнөговь аймаг	8	Өвөрхангай аймаг	4
Булган аймаг	29	Завхан аймаг	6	Архангай аймаг	3
Сэлэнгэ аймаг	23	Төв аймаг	6	Баян-Өлгий аймаг	2
Дорнод аймаг	17	Хөвсгөл аймаг	6	Нийт	643

(SV орсон болно)

(Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

4.2 Голлох салбарын шилжилт хөдөлгөөн

Монгол Улсад илгээж байгаа сайн дурын гишүүдийн дийлэнх хувийг боловсрол (япон хэлний боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, бүрэн дунд боловсрол), эрүүл мэнд (сэргээн засах эмчилгээ), биеийн тамирын салбар эзэлж байснаараа онцлог байлаа. Эдгээр голлох салбаруудад томилогдож, үйл ажиллагаанд биечлэн оролцож байсан сайн дурынхны гэрчлэн хэлсэн агуулгыг доор тэмдэглэв.

Хүснэгт 4-3 Монгол Улсад томилсон гишүүдийн мэргэжлээр ангилсан үзүүлэлт
(салбар тус бүрээр) (1992 оноос 2016 оны 10-р сарын эцсийн байдлаар)

Мэргэжил	JOCV	SV	Хамгийн олон гишүүн томилогдсон үе
Япон хэлний боловсрол	62	11	2001 - 2005он (25 хүн)
СӨБ	40	2	2006 - 2010он (14хүн)
Бага, дунд, бүрэн дунд боловсрол	67	3	2011 - 2015он (30хүн)
Эрүүл мэнд	43	1	2011 - 2015он (16хүн)
Сэргээн засах эмчилгээ	22	1	2011 - 2015он (12хүн)
ХБИ, ХБХ-дэд үзүүлэх дэмжлэг	15	7	2006 - 2010он (13хүн)
Биеийн тамир, сэтгэл зүйн боловсрол	88	1	2011 - 2015он (25хүн)
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжийг хөгжүүлэх	19	52	2001 - 2005он (31хүн)
Мэргэжил олгох сургалт	88	34	2001 - 2005он (40хүн)
Орон нутгийн хөгжил	11	0	2006 - 2010он (7хүн)
Байгаль орчныг хамгаалах	5	3	2006 - 2010он (5хүн)
Дэд бүтэц, хот төлөвлөлт, хот байгуулалт	3	6	2006 - 2010он (3хүн)
Бусад салбар	30	14	2006 - 2010он (16хүн)

(Эх сурвалж: "Монгол Улсад томилсон үзүүлэлт" -Microsoft Excel мэдээлэл, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын мэргэжлийн ангилал-аас иш татав)

4.2.1 Япон хэлний боловсрол

(1) Япон хэлний боловсролын салбарын хөгжлийн байдал

Япон хэлний боловсролын салбар нь Монгол Улсад сайн дурынхныг анх удаа илгээсэн, үйл ажиллагааны эхлэл болсон салбар бөгөөд, өнөөдрийг хүртэл тогтвортой үргэлжилж ирсэн салбар юм. Монгол дахь япон хэлний боловсролын эхлэл нь 1974 онд “Соёлын харилцаа тогтоох тухай тохиролцоо”-нд гарын үсэг зурснаар тавигдаж, тухайн жилдээ МУИС-иас Токиогийн Гадаад хэлний дээд сургуульд монгол хэлний багш, дараагийн жил нь буюу 1975 онд Токиогийн Гадаад хэлний дээд сургуулиас МУИС-д япон хэлний багш тус тус томилогдож ажиллажээ. Үүнтэй уялдан, МУИС-ийн монгол хэл, уран зохиолын факультетэд (туслах мэргэшлээр) япон хэлний курс нээгдсэн 1975 оныг Монгол Улсад япон хэлний боловсрол олгож эхэлсэн тэмдэглэлт он болгож, ойн баяраа тэмдэглэж иржээ. 1990 онд ардчилсан хөдөлгөөн өрнөж, тухайн үед гадаад хэлний сургалтанд голлож байсан орос хэлнээс гадна, англи хэлийг заавал сурах хэл болгож, япон хэл, солонгос хэлийг сонголтоор сурах хэл болгон заах нь түгээмэл болсноор Монгол Улсад япон хэлний сурах явдал огцом нэмэгдсэн юм¹⁵. 1990 онд (10 жилийн) 23-р сургуульд бага дунд боловсролд анх удаа япон хэлний боловсрол олгож эхэлсэн байна. Эхэн үед, Оосакагийн гадаад хэлний дээд сургуулийн оюутан, сайн дурын гишүүн болох хувь хүн япон хэл зааж байсан бол, 1992 оноос Монгол Улсад анхны JOCV сайн дурын япон хэлний 2 багш томилогдон ирсэн. 1992 оны үеэс гадаад хэлний боловсрол олгодог хувийн их дээд сургуулиуд олноор байгуулагдаж, Монгол Япон хоёр Улсын харилцаа хурдацтай хөгжсөнөөр япон хэл эзэмшигсдийн хэрэгцээ нэмэгдэж, япон хэлний тэнхим олноор нээгдэж байсан¹⁶.

Дараах графикт, сайн дурынхныг томилогдсон байгууллага тус бүрээр үзүүлэв. Япон хэлний боловсролын салбарт ажилласан илгээлтийн ихэнх нь Улаанбаатар хотод төвлөрч байсан бөгөөд, 1997-2008 онд Дархан-Уул аймаг болон Ховд аймагт томилогдож байсан ч түүнээс бусад орон нутагт өргөжөөгүй байна. Улаанбаатар хотын хувьд, ХУИС, ШУТИС зэрэг дээд боловсролын байгууллага болон 23-р сургууль, 18-р сургуулиудад бага, дунд сургуулийн аль алинд заах сайн дурын гишүүдийг илгээж байсан байна. 2005 оноос хойшхи чиг хандлагыг авч үзвэл, МУБИС-т

¹⁵ Япон улсаас Монгол Улсад сууж байсан Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд асан Кидокоро Такүогийн ярианаас

¹⁶ Ишлэл: Монгол дахь Япон сан (2014) <https://www.jpf.go.jp/j/project/japanese/survey/area/country/2014/mongolia.html> (хандалт 2016/10/28)

ахмад сайн дурын гишүүн томилох, Улаанбаатар хотын боловсролын газарт гишүүн илгээх үйл ажиллагаа 2014 он хүртэл үргэлжилсэн байна. 2015 онд Монгол Улс дахь япон хэлний боловсролын 40 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулагдсан.

Аймаг	Томилогдсон газар / Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16	
Улаанбаатар хот	Дээд боловсрол олгох байгууллага	ХУИС	■	■	■	■	■	■	■	■																	
		ШУТИС				■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
		МУБИС															■	■	■	■	■	■	■	■	■	■	■
		МУИС				■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
		МУИС-ын Орхон дахь салбар Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургууль													■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
	СУИС														■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	
	Бага дунд боловсрол олгох байгууллага	23-р сургууль	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
		18-р сургууль							■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
		3-р сургууль			■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
		Монгени цогцолбор сургууль													■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
Шинэ Монгол сургууль																										■	
48-р сургууль															■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	
84-р сургууль															■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	
Дархан-Уул	Оюуны ирээдүй цогцолбор сургууль							■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■		
	19-р сургууль													■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	
Ховд	Ховд дээд сургууль																									■	
Улаанбаатар хот	Боловсролын газар																									■	
	Улаанбаатар хотын боловсролын газар																									■	

График 4-3 Япон хэлний багш нарын томилгоо

(Эх сурвалж: Монгол Улс дахь томилгооны байдал -Microsoft Excel мэдээлэл-ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

(2) Монгол Улс дахь япон хэлний боловсролд гарсан өөрчлөлт

1) Эхэн үе

Анхны JOCV япон хэлний багшийн ажиллах эхэн үед (1992 он), япон хэлний монгол нарын тоо цөөн байсны дээр Япон улсад сурч байсан туршлагагүй, мэдлэгийн түвшин ч хангалтгүй байсан. Мөн сурах бичиг хангалтгүй, сургалтын хөтөлбөр байхгүй зэрэг олон асуудал байжээ.

Мүракамигийн гаргасан тайланг үзвэл, Малайзи Улсад сургалтанд хамрагдахаар болж, газар дээр нь үзэж танилцсан үеийнхээ япон хэлний боловсролын байдлыг тэмдэглэсэн байдаг. Тэмдэглэлд үндэслэвэл, сургалтын хөтөлбөр болон сургалтын туслах материалыг өмнөх JOCV-ийн сайн дурын гишүүд нь бэлтгэсэн байсан. Сургалтын материал нь хүний тоогоор бэлтгэгдэж, сурагчид хотын номын сангаас толь бичиг худалдан авах боломжтой байжээ. Мөн түүнчлэн, багш нар худалдаа наймаа хийх зэрэг хувийн амьдралдаа төдийлөн их цаг зарцуулах шаардлагагүй, хичээлд бэлтгэх хугацаа хангалттай, бүх зүйл нь бэлэн учраас ямар нэг "зүйл" шинээр бэлтгэх шаардлагагүй байсан. Эдгээр нөхцлүүдийг хараад атаархах сэтгэл төрсөн хэдий ч, нөгөөтэйгүүр хүндрэл бэрхшээлд анхаарлаа хандуулах бус анхдагч сайн дурын ажилтан байх нь хүнд боловч урам зориг бадраасан зүйл юм байна гэдгийг ойлгож мэдэрсэн хэмээсэн байдаг. Учир нь Малайзид томилогдсон гишүүд нэгэнт бэлтгэгдсэн сургалтын хөтөлбөрийн дагуухичээлээ заадаг учир өөрсдөө бодож боловсруулах шаардлагагүй амар хялбар байдаг ч, сургалтын хөтөлбөрийн нэгэн хэвт байдалд баригдан өөрийн хүссэн, төгс гэж бодож байгаа байдлаар хичээлээ зааж чаддаггүй гэсэн гомдол санал хэд хэдэн хүнээс гарсан ажээ.

2) Орон нутаг (Дархан) дахь япон хэлний боловсрол

1998 оны 8-р сараас 2008 он хүртэл япон хэлний 5 багш томилогдсон Дарханы 7-р дунд сургууль (одоогийн Оюуны ундраа цогцолбор сургууль)-ийн захирал Нарантуяагаас тухайн үеийн нөхцөл байдлын тухай асууж ярилцсан. Зайлшгүй үзэх шаардлагатай орос хэл, англи хэлээс гадна 3 дахь гадаад хэлийг сонгох үедээ өмнө нь японд сурч байгаад тухайн үед төмрийн үйлдвэрт ажиллаж байсан Мөнхжаргалын зөвлөгөө болон сурагчдын эцэг эхийн зөвлөлийн саналыг нэгтгэж, хүүхдүүдийн илүү ихээр сонирхож буй хэл гэж үзэн япон хэлийг сонгосон түүхтэй ажээ. Тухайн үед япон хэл нь Монгол Улсад ховор, энэ хэлийг огт мэддэггүй хүмүүс үнэхээр их байсан. Сурах бичиг ч байгаагүй. Японы соёлыг мэдрэхэд л хангалттай гэсэн бодолтой байлаа. Мөн, JOCV-ийн хичээлийн заах арга барилаас, бусад гадаад хэлний багш нар ч суралцаасай гэж хүсч байсан. Бодит байдал дээр ЖАЙКА-ийн сайн дурынхан хичээлийн бэлтгэл, заах арга барил, хичээл зүтгэл зэргээрээ бусад багш нарт сайн нөлөө үзүүлж байсан. Хамгийн анх томилогдож ирсэн JOCV Танин Акеми гуай япон хэлний хичээлээр сурсан зүйлээ танилцуулах япон хэлний баярыг зохион байгуулснаас хойш өнөөдрийг хүртэл жил бүр зохион байгуулж байгаа. Өнөөдөр япон хэлний 2 монгол багш ажиллаж байгаа хэдий ч унаган япон хэлтэй хүнтэй харьцах боломж багассан нь бэрхшээл учруулж байгаа ажээ. Япон хэлний сургалтын үр дүнг асуухад зохион бичлэг болон уран илтгэлийн уралдаанд оролцсон хэд хэдэн ялагч байгаа тухай болон Японд богино болон урт хугацаагаар суралцах боломж олгож байгаа тухай ярьж байлаа.

3) Эргүүлийн багшийн хэлбэр

2007 оноос хойш сургуулиудад тус тусад нь гишүүд томилдог байсан хэлбэрээс боловсролын газарт харьяалуулан хэрэгцээт газарт нь томилж ажиллуулах хэлбэрт шилжиж эхэлсэн. 2007 онд томилогдсон Фүжии Мики JOCV, тухайн үед томилогдсонахмад сайн дурын гишүүний хамтаар хотын бага, дунд боловсролыг хариуцан ажилладаг Улаанбаатар хотын боловсролын газрын гадаад хэлний хэлтсийн япон хэл хариуцсан албанд томилогдож, дунд боловсрол олгох байгууллагуудаар тойрч, япон хэлний багш нарыг сургах, зааварчилгаа өгөх үйл ажиллагааг явуулсан. Нийслэлийн боловсролын газарт урт хугацааны сайн дурын гишүүн ажилласан нь анхны тохиолдол байсан бөгөөд эхэндээ газрын дарга болон хамтрагч нар сайн дурын гишүүнээр юу хийлгэхээ, өөрсдөө юу хийхийг зорьж байгаагаа мэдэхгүй байгаа мэт байсан хэмээн Фүжии JOCV-ийн тайланд бичсэн байна. Мөн, Боловсролын газар дахь үйл ажиллагааныхаа талаар “Аль нэг сургуулийн сурагч болон

багш нарын япон хэлний чадварыг сайжруулахад мэргэжилтэн дагнаж томилох арга барил нь илүү үр өгөөжтэй боловч, өнөөгийн Монголын бага, дунд боловсрол нэг алхам урагшлах шатандаа ирж багш нарыг сургах болон сургалтын стандарттай болоход чиглэсэн арга хэмжээ шаардлагатай болж байна. Энэ тал дээр томилогдон очсон газар маань боловсролын газар байсан учир тодорхой арга хэмжээг авч чадсан юм.” гэж тэмдэглэн үлдээжээ. Үүний сацуу, зөвхөн Япон Улсаас ирсэн сайн дурын гишүүн төдий бус нийслэлийн боловсролын газрын удирдах хүн гэдэг утгаараа, дээрээс өгсөн заавар журмыг мөрдөхөөс өөр сонголтгүй, байр суурь нь сул, залуу монгол багшийн талд асуудлыг шийдвэрлэж туслах үе чгарч байсан гэжээ.

4) 2016 оны өнөөгийн байдал

Анхны JOCV-г илгээж эхэлснээс хойш 25 жил өнгөрсөн 2016 оны байдлаар, МУИС-ын харъяа Улаанбаатар дээд сургуульд томилогдсон Сава Томоко JOCV-ийн тайланд үндэслэвэл, өмнөх SV болон JOCV нарын үйл ажиллагааны үр дүнд Улаанбаатар хотын япон хэлний боловсролын түвшин өндөржиж, “Япон төв” болон “Япон хэлний багш нарын холбоо”-ны үйл ажиллагаа идэвхжиж, япон хэлний сургалтын тухай материал болон судалгааны ажил, туршлага солилцох уулзалт, семинар олноор зохион байгуулагдаж байгаа тухай тэмдэглэсэн байна. 2014 оны 5-р сарын 1-ний байдлаар Монгол Улсаас Япон Улсад 1,548 оюутан сурч байгаа нь улс орноор нь ангилахад дэлхийд 11-р байранд орж байгаа хэдий ч 10,000 хүн тутмаас 5,34 хүн нь Япон Улсад сурч байгаа гэдэг үзүүлэлтээр дэлхийд 1-рт орж байгаа юм¹⁷. Мөн хамтрагч болж байгаа япон хэлний курсын багш нар бүгд Япон Улсад богино болон урт хугацаагаар суралцаж байсан туршлагатай тул япон хэлний чадвар өндөр, япон хэлээр харилцахад хүндрэлгүй байсан. “Япон хэлний багш нарын холбоо”-ны судалгааны тайлан ба судалгааны хуралдаанд оролцох үед монгол багш нарын япон хэлний чадвар өндөр түвшинд байгаа нь, илүү сайн заах аргад суралцах гэсэн хүсэл эрмэлзэл ихтэй байгаа нь гүн сэтгэгдэл төрүүлсэн. Мөн, JOCV япон хэлний багш өнөөгийн байдлаар зөвхөн Улаанбаатар хотод томилогдож байгаа тул орон нутагт илгээгдсэн бусад мэргэжлийн ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд япон хэл заахад хүрдэг тухай яриаг олонтаа сонсож байсан хэмээн өгүүлжээ.

4.2.2 Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)

Сургуулийн өмнөх боловсролын салбарт гишүүд илгээх томилгоо нь 1994 онд Улаанбаатар хотын 42-р цэцэрлэг, 14-р цэцэрлэгээр эхэлсэн байна. Улаанбаатар хотод 2000 оноос 2011 он хүртэлх хугацаанд сургуулийн өмнөх насны боловсрол олгох багш нарыг бэлддэг их дээд сургууль болон Багануур дүүргийн боловсролын газарт ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийг тогтмол илгээж байсан бөгөөд 2005 оноос хойш хотын олон цэцэрлэгүүдэд JOCV ажиллаж байсан байна. Орон нутагт 1998 оноос гишүүдийг илгээж, Дархан-Уул аймаг, Булган аймаг, Сэлэнгэ аймаг, Ховд аймаг, Өмнөговь аймаг, Говьсүмбэр аймаг, Орхон аймгийн цэцэрлэгүүдэд үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

¹⁷ “Засгийн газрын тэтгэлгээр сурч буй гадаад оюутнуудын тойм” 2015 оны 5-р сар, Монгол Улс дахь Япон улсын ЭСЯ, Ишлэл: http://www.mn.emb-japan.go.jp/jp/bunka/2014nihon_ryugakuseido_jp.pdf (хандалт 2016/12/1)

Аймаг	Томилгогдсон газар/Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16		
Улаанбаатар хот	42-р цэвэрлэг																											
	14-р цэвэрлэг																											
	Бага насны хүүхдийн боловсролын багш бэлтгэх сургууль / дээд сургууль																											
	УБ хотын боловсролын газар Багануур дүүргийн боловсролын газар																											
	133-р цэвэрлэг																											
	61-р цэвэрлэг																											
	22-р цэвэрлэг																											
	31-р цэвэрлэг																											
	57-р цэвэрлэг 135-р цэвэрлэг Сүжаташанд (ТББ)																											
	Дархан	Сувиллын ясли																										
4-р цэвэрлэг																												
Аймгийн боловсрол соёлын газар																												
Булган	1-р цэвэрлэг																											
	2-р цэвэрлэг																											
Сэлэнгэ	4-р цэвэрлэг																											
	Боловсрол соёлын газар																											
Ховд	5-р цэвэрлэг																											
Өмнөговь	Боловсрол соёлын газар																											
Говьсүмбэр	Боловсрол соёлын газар																											
Орхон	9-р цэвэрлэг																											
	10-р цэвэрлэг																											

График 4-4 Сургуулийн өмнөх боловсрол дахь томилолтын үзүүлэлт

(Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

2007 оны 8-р сард ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас “Боловсролын салбар дахь сайн дурын гишүүдийн өнөөгийн байдал ба тулгамдаж буй асуудал”, “Боловсролын яамны шинэчлэл, хамтын ажиллагааны бодлого”-ыг нэгтгэн дүгнэсэн байна. Тухайн үеийн Монгол Улсын Боловсролын бодлогын удирдлага менежментэд ур чадвар дутах, шаардлагатай боловсон хүчний дутагдлаас багш нарынзаах арга, ур чадвар муудах, боловсролын салбарын дэд бүтэц сул хөгжилтэй байх, хөдөө орон нутагт сургалтын орчин муу байх, сургууль завсардалт их байх зэрэг олон асуудал тулгарч байжээ. Энэ үед 2005 оны 9-р сард Монгол Улсын Засгийн газраас “Боловсролын шинэ стандарт” гарган нэвтрүүлж, "Хүүхэд төвтэй" сургуулийн өмнөх боловсролын сургалтын хуулийг мөрдөж эхэлсэн.

2015 оны байдлаар мөрдөгдөж буй БСШУЯ-ны сургуулийн өмнөх боловсролын талаархи гарын авлага болох “Тоглоом ашигласан сургалт (гар доорхи материалаар хийж болох сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалтын материалыг түгээн дэлгэрүүлэх, дуу хөгжим, дүрслэх урлаг, биеийн тамир зэрэг хүүхдийн сэтгэн бодох чадвар болон авьяасыг хөгжүүлэх арга барил, нас болон хөгжлийн түвшинд нь тохируулан заах аргачлал түгээх зэрэг)”-ыг хэрэгжүүлэх үүднээс жилд ЖАЙКА-аас 1-2 сайн дурын гишүүн ажиллаж байна.

4.2.3 Бага, дунд, бүрэн дунд боловсрол

(1) Бага сургуулийн боловсрол

Монгол Улсын боловсролын тогтолцоо нь 6-3-3 жилийн систем (бага анги бжил, дунд анги 3

жил, ахлах анги 3 жил) бөгөөд бага, дунд сургуулийн 9 жил нь заавал эзэмших ёстой суурь боловсрол юм. Үндсэндээ, бага, дунд, ахлах анги нь нэг дор байдаг ерөнхий боловсролын сургууль зонхилдог. Өмнө нь 10 жилийн системтэй (бага дунд анги 8 жил, ахлах анги 2 жил) байсан боловч, 2005 оны 9-р сараас 11 жилийн систем (бага анги 5 жил, дунд анги 4 жил, ахлах анги 2 жил)-тэй болж, олон улсын стандартад нийцүүлж 2008 оноос эхлэн өнөөгийн 12 жилийн системд шилжсэн байна.

Бага сургуулийн сайн дурын гишүүн багш илгээх анхны томилгоог 2001 онд Орхон аймгийн “Баян-Өндөр цогцолбор сургууль”-иас эхлүүлсэн. Үүний дараа Сэлэнгэ аймаг, Булган аймаг, Дархан-Уул аймгийн бага сургуулиар сайн дурын гишүүн илгээх үйл ажиллагааны хүрээг тэлж, өнөөгийн байдлаар Орхон аймаг, Сэлэнгэ аймаг, Дархан-Уул аймаг, Дорноговь аймаг, Дорнод аймагт сайн дурын гишүүн ажиллаж байна.

Аймаг	Томилгогдон газар/Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16
Орхон	Баян-Өндөр цогцолбор сургууль																									
	Боловсрол соёлын газар																									
	Жаргалант сургууль																									
Сэлэнгэ	1-р сургууль																									
	4-р сургууль																									
Булган	Эрдмийн Өргөө цогцолбор сургууль																									
Дархан-Уул	18-р сургууль																									
Улаанбаатар хог	Сэтгэмж цогцолбор сургууль																									
	МУБИС																									
	“Боловсрол” цогцолбор сургууль																									
	20-р сургууль																									
Говьсүмбэр	Боловсрол соёлын газар																									
Дорноговь	Дорноговь аймгийн 1-р сургууль																									
	Дорноговь аймгийн 2-р сургууль																									
Дорнод	Хан-Уул цогцолбор сургууль																									
	Чойбалсан 5-р сургууль																									
	12-р сургууль																									
	5-р сургууль																									

График 4-5 Бага сургуулийн сургалтын байдал (МУБИС дахь илгээлтийг оруулсан болно) (Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

Монгол Улсад 2005 оны 9-р сараас СӨБ-ын шатнаас эхлэн хэрэгжүүлж ирсэн цээжлэх үйлдэлд төвлөрсөн сургалтын арга барилыг өөрчилж, сэтгэн бодох чадвар суулгах, “хүүхэд төвтэй” хичээл явуулах шинэ заах аргын удирдамж (цаашид, шинэ стандарт гэх)-ийг гаргасан. Гэвч, сургалтын талбар дээр энэхүү эрэлт хэрэгцээнд таарсан сургалт явуулж чадах туршлагатай багшийн тоо эрс дутагдаж байсан тул сайн дурынхнаас тусламж хүссэн байна¹⁸. Түүнчлэн, “Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйг сайжруулах төсөл” (2006 оноос 2009 он), “Төслийн 2-р үе шат (2010 оноос 2013 он)” тус тус хэрэгжиж, “Хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын арга зүй”-г хэвшүүлэх техникийн хамтын ажиллагааг ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн. Бага сургуулийн сургалтад хамаарах ЖАЙКА-ийн сайн дурынхныг энэхүү төслийн үр дүнг сайжруулах үүднээс илгээж ирсэн юм.

Томилогдон ирж буй бага сургуулийн багш нар Монгол Улсын шинэ сургалтын хөтөлбөр болох “Хүүхэд төвтэй” хөтөлбөрөөр сургалтыг явуулж байгаа тул өөрийн хариуцсан хичээлийн нэр төрөл тус бүрээр хичээл заах, хичээлд бэлтгэх, семинар зохион байгуулах зэргээр дамжуулан монголын багш нарт арга барил, технологи шилжүүлж, тус бүртээ зохих үр дүнд хүрсэн байна.

¹⁸ 2009 оны 1-р бүлэг Бага сургуулийн багш хүлээн авах хүсэлтийн судалгаанаас иш татав

(2) Байгалийн шинжлэх ухааны багш

2007 оноос эхлэн байгалийн шинжлэх ухааны багшийг илгээж эхэлсэн байдаг. Байгалийн шинжлэх ухааны багш авах хүсэлт гаргах болсон шалтгаан нь бага сургуулийн багштай адил бөгөөд сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэн хүүхэд төвтэй хичээлийг явуулах үндэсний шинэ стандарт (2005 он)-ыг боловсруулан хэрэгжүүлснээр шинжлэх ухаан, байгалийн ухааны сургалтын ач холбогдол ихэссэнтэй холбоотой ажээ.

Аймаг	Томилгосон газар/Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16
Улаанбаатар хот	Сэтгэмж цогцолбор сургууль																									
	Сэтгэмж цогцолбор сургууль																									
	97-р сургууль																									
	97-р сургууль																									
Дархан-Уул	Дархан 16-р сургууль																									
	Дархан 15-р сургууль																									
Сэлэнгэ	Сүхбаатар 4-р сургууль																									
	Сүхбаатар 4-р сургууль																									
Говьсүмбэр	Боловсрол соёлын газар																									
Дорнод	Боловсрол соёлын газар																									
Булган	Боловсрол соёлын газар																									
Дорноговь	Сайншанд 3-р сургууль																									

График 4-6 Байгалийн шинжлэх ухааны багшийн томилгоо

(Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

(3) Биеийн тамир

Биеийн тамирын мэргэжилтэн сайн дурынханыг илгээх ажил 2003 оноос эхлэж, 2016 оны 10-р сар хүртэлх хугацаанд тасралтгүй явагдаж, 15 гишүүн илгээсэн байна. Анхны удаагийн болон хоёр дахь удаагийн зэргээр үргэлжлэн сайн дурынхныг хүлээн авч ирсэн байгууллага ч байдаг ажээ. Улаанбаатар хот болон орон нутгийн сургууль, боловсролын газарт сайн дурынхан харьяалагдаж байна.

Биеийн тамирын хичээлийг нас, бие бялдарт нь таарсан олон төрлийн дасгал хөдөлгөөнийг заах зорилго тавьж, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх хүүхэд төвтэй хичээл явуулах шинэ заах аргын удирдамж 2005 оны 9-р сард батлагдсан. Гэвч, сургалтын талбар дээр энэхүү эрэлт хэрэгцээнд таарсан сургалт явуулж чадах туршлагатай багшийн тоо дутагдалтай байсан тул сайн дурынхнаас тусламж хүссэн байна. Сайн дурын багшийн үйл ажиллагаанд, биеийн тамирын хичээлийг заахаас гадна, гар бөмбөг болон сагсан бөмбөг зэрэг спортын тодорхой төрлөөр дугуйлан хичээллүүлэх явдал орж байжээ.

Аймаг	Томилгосон газар/Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16
Орхон	Орхон цогцолбор сургууль																									
	Аймгийн боловсрол соёлын газар																									
	7-р сургууль																									
Улаанбаатар хот	97-р сургууль																									
	Гүн галуутай цогцолбор сургууль																									
Булган	МУБТДС																									
Сэлэнгэ	1-р сургууль																									
	Сүхбаатар 4-р сургууль																									
Дархан-Уул	Боловсрол соёлын газар																									
	Од цогцолбор сургууль																									
	18-р сургууль																									
Завхан	15-р сургууль																									
	Боловсрол соёлын газар																									
Говь-Алтай	Хангайшир Эрдэм цогцолбор сургууль																									

График 4-7 Биеийн тамирын хөгжил

(Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

(4) Дуу хөгжим

Дээр дурдсан 2005 оны Монгол Улсын боловсролын салбар дахь шинэчлэлээс улбаалан, өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн цээжлэх үйлдэлд тулгуурласан сургалтын арга барилаас хүүхдийн сэтгэн бодох чадвар болон төсөөлөн бодох чадварт суурилсан “хүүхдийн хөгжлийг дэмжих арга барил”

руу шилжсэн. Гэтэл энэхүү шинэ стандарт нь газар дээр ажиллаж буй багш нарт ойлгомжгүй, илүү бодит заах арга зүйг нэвтрүүлэх шаардлага гарсантай холбогдон дуу хөгжмийн багш илгээх хүсэлт гарсан байна. Дуу хөгжмийн мэргэжилтэй 3 сайн дурын гишүүн 2010 оноос эхлэн өнөөг хүртэлх хүртэлх хугацаанд томилогдсон байна.

4.2.4 Эрүүл мэнд

(1) Сувилагч, эрүүл мэндийн ажилтан, эх баригч

ЖАЙКА-ийн сайн дурынхны эрүүл мэндийн салбар дахь дэмжлэг 1998 оны 12-р сард Улаанбаатар хотын 2-р эмнэлэгт сувилагч томилсноор эхэлсэн. Уг эмнэлэгт нийт 3 гишүүн томилогдон ажилласан. Эрүүл мэндийн салбарт ирж ажилласан сайн дурынхнаас хамгийн олон нь сувилагч бөгөөд 2016 оны 10-р сар хүртэлх хугацаанд 21 сувилагч ирсэн байна. 2011 онд хавдар судлалын үндэсний төвд сувилахуйн ухаанаар мэргэшсэн гишүүн илгээгджээ. Мөн, 10 хүн нийгмийн эрүүл мэндийн сайн дурын ажилтнаар томилогдон ирсэн бөгөөд анхны эрүүл мэндийн ажилтан 2010 онд Улаанбаатар хотын Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвд ирж ажилласан байна. Эрүүл мэндийн ажилтны хувьд “Нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэсэн мэргэжил Монгол Улсад байдаггүй тул үйл ажиллагааны талаар ойлголт авч, хамтран ажиллах хүн бий болтол хугацаанд энд би юу хийх вэ, ирэх шаардлага байсан юм уу гэх зэргээр өөртөө асуулт тавьж, өөртөө хариулж суух өдрүүд олон байсан хэмээн нэгэн гишүүний тайланд дурджээ. 2016 оны 10-р сар хүртэлх хугацаанд 2 эх баригч томилогдон ажилласан бөгөөд 2013 онд Завхан аймгийн эрүүл мэндийн төв ба Булган аймгийн Эрүүл мэндийн төвд хуваарилагдаж байжээ.

Аймаг	Томилогдсон газар/Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16	
Улаанбаатар хот	Улсын 2-р эмнэлэг																										
	Улсын 3-р эмнэлэг																										
	Хавдар судлалын үндэсний төв																										
	Багануур дүүрэг Эрүүл мэндийн төв																										
Орхон	АШУҮИС Их Сургуулийн Нэгдсэн эмнэлэг																										
	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Өмнөговь	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Говьсүмбэр	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Булган	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										
	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										
	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Төв	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										
Сэлэнгэ	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										
Завхан	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										
Дорноговь	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Дархан-Уул	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										
	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Хөвсгөл	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										

График 4-8 Сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эх баригчийн томилгоо (Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

4.2.5 Сэргээн засалч (хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл яриа, сонсгол засалч)

ЖАЙКА-ийн сайн дурынхныг илгээж байсан Монгол Улсын онцгой нэгэн салбар бол хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл яриа, сонсгол засалч гэх мэт сэргээн засах эмчилгээний салбар юм. 2004 онд тархины саажилттай хүүхдийн 10 дугаар цэцэрлэгт анхны гишүүнийг томилж, үүний дараагаар Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв, Улсын Клиникийн 3 дугаар төв эмнэлэг зэрэгт гишүүдийг илгээж, цар хүрээгээ тэлжээ. Мөн түүнчлэн, 2011 онд Монгол Улсад хөдөлгөөн засалчаар мэргэшсэн анхны сувилагчид (13 хүн) сургууль төгссөнөөр боловсон хүчин сургах сайхан боломж хэмээн үзэж, сэргээн засах эмчилгээний салбарыг өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавьсан¹⁹.

Аймаг	Томилогдон газар/Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16	
Улаанбаатар хот	Сувицлын 10-р ясли																										
	Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв																										
	Улсын 3-р эмнэлэг																										
	ГССҮТ																										
	Улсын 1-р эмнэлэг																										
Дорнод	Аймаг, бус нутгийн оношлогооны эмчилгээний төв																										
	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										
Өмнөговь	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Булган	Хүүхдийн хэлтэс																										
Архангай	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Хөвсгөл	Аймгийн нэгдсэн эмнэлэг																										
Дархан-Уул	Аймгийн эрүүл мэндийн хэлтэс																										

График 4-9 Хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл яриа, сонсгол засалчийн томилгоо (Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

Улсын 3-р төв эмнэлэгт (Шастины нэрэмжит эмнэлэг), хөдөлгөөн засалч болон хөдөлмөр засалч нар 2009 оноос эхлэн томилогдон ажилласан бөгөөд Монгол Улсын сэргээн засах эмчилгээний нөхцөл байдалд тааруулсан дэмжлэг үзүүлж, томилогдон ажиллаж байсан газруудаасаа өндөр үнэлгээг авч ирсэн. Улсын 3 дугаар төв эмнэлэгт ирж ажилласан хамгийн анхны японы сэргээн засалч мэргэжилтэн нь 2007-2009 он хүртэл Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвд томилогдон ажиллаж байсан Мичихиса Мэгүми JOCV байсан. Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвд хөдөлгөөн засалчаар ажиллаж ирсэн Мичихиса JOCV томилолтынхоо сүүлийн 3 сарын хугацаанд, тухайн үед сэргээн засалч мэргэжилтэн байгаагүй улсын 3 дугаар төв эмнэлэгт ажилласан. Тэр нь Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвд ажиллаж буй Мичихиса JOCV-г олж харсан улсын 3 дугаар төв эмнэлгийн даргын хүсэлтээр хэрэгжсэн ажээ. Улсын 3 дугаар төв эмнэлэгт, 3-хан сарын богино хугацаанд ажилласан хэдий ч өвчтөн нэг тус бүрт шаардлагатай байсан сэргээн заслыг зургаар зурж, орон дээр нь наасан. Үүнд сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгччин сэтгэлээсээ талархаж, ЖАЙКА-д сайн дурынхныг хүлээн авах хүсэлт гаргасан байна.

4.2.6 Спорт

Биеийн тамирын салбарт сайн дурын гишүүдийг ирүүлэхийг хүссэн хүсэлт Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынханы үйл ажиллагаа эхэлсэн цагаас ирж байсан боловч, японы тал энэхүү мэргэжлээр сайн дурын гишүүн олж, авчирч чадаагүй юм²⁰. Хамгийн анхны

¹⁹ Төслийн зохицуулагч Собашима Кены сүүлийн илтгэл 2015 он

²⁰ Ооно зохицуулагчаас авсан ярилцлага

томилолт авсан биеийн тамирын салбарын сайн дурын ажилтан нь 1994 онд ирсэн гар бөмбөг болон айкидогийн мэргэжилтнүүд байв. Тэд Улаанбаатар хотын гар бөмбөгийн холбоо, Айкидо холбоонд томилогдсон.

ЖАЙКА-ийн гар бөмбөгийн мэргэжилтэй сайн дурын гишүүн нь дасгалжуулагч болон сургагч багшийн хувьд тамирчин бэлтгэх, салбарыг нэлэнхүйд нь хөгжүүлэх зорилготой байж, олон нийтээс өндөр итгэл найдвар хүлээсэн тул Улаанбаатар хотоос гадна орон нутагт хамгийн анх томилолт авсан мэргэжлийн төрөл байсан юм²¹.

“Монголын айкидо холбоо” нь 1993 онд байгуулагдсан, шинэ залуу, жижигхэн холбоо байснаас үйл ажиллагаа явуулах арга хэлбэрээ дөнгөж олж авах шатанд байсан бөгөөд холбогдох хүмүүс нь айкидог нэвтрүүлэх тал дээр бүхий л хүчээ дайчлан зүтгэж, үүний тулд дэлхийд тэргүүлэх Японы айкидогийн арга технологи, заах арга барилаас суралцах хүчтэй сонирхолтой байжээ²². Үүний дараа 2004 он хүртэл нийт 3 ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн томилогдож ажиллажээ.

Тулааны бусад урлаг болох каратэ болон жүдо, сагсан бөмбөг болон бадминтоны (агаарын теннисийн) мэргэжлээр ч гишүүдийг илгээсэн байна. Газрын теннис ба аэробикоор 2 хүн, бейсбол болон гандбол, усанд сэлэлт, ширээний теннисээр тус бүр 1 хүн томилогдож байв.

Биеийн тамир нь спортоор дамжуулан олгох боловсрол гэдэг утгаараа өндөр ач холбогдолтой юм. Биеийн тамирын салбарт сайн дурынхныг илгээх нь, биеийн тамираар дамжуулан нийгмийн хүрэн дэх эелдэг ёс, хичээл чармайлт, мэндлэх хүндлэх ёс зэрэгт суралцаж, өөрийгөө өсгөн хүмүүжүүлэх ач холбогдолтой юм. Эхэндээ, үндэсний багийн түвшинд тамирчид бэлтгэх зорилготой байсан илгээлт, боловсрол олгох утга учир нь давамгайлах болж ирсэн байна.

(1) Гар бөмбөг

Гар бөмбөгийн мэргэжилтнээр томилогдсон JOCV-ийн байдлыг доорхи хүснэгтэд илэрхийлэв. 2016 оны өнөөдрийг хүртэл нийт 26 хүн томилогдсон бөгөөд япон хэлний багшийн дараа орох олон хүн илгээгдсэн мэргэжил болжээ. Үндэсний багийн туслах дасгалжуулагчаас эхлүүлээд биеийн тамирын сургуулийн хүүхэд залуучуудад гар бөмбөгийн гайхамшгийг заахын хамт, Монголын дасгалжуулагчтай гар нийлэн багийн ур чадварыг дээшлүүлэхэд хамтран ажиллаж ирсэн.

Аймаг	Томилгдсон газар/Он	92	93	94	95	96	97	98	99	00	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16	
Улаанбаатар хот	Гар бөмбөгийн холбоо				■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
	МУБТДС Багануур дүүргийн боловсролын газар									■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
Орхон	Биеийн тамир, спортын хороо				■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
Дархан	Спортын хороо																										
Говьсүмбэр	Спортын хороо																										
Сэлэнгэ	Төрөлжсөн сургалттай биеийн тамирын дунд сургууль																										
Дорноговь	Спортын хороо																										
Төв	Спортын хороо																										
Хөвсгөл	Аваргуудын спортын сургууль																										
Дорнод	Соёл, биеийн тамир, аялал жуулчлалын газар																										
Булган	Биеийн тамир, спортын газар																										
Говь-Алтай	Биеийн тамир, спортын газар																										

График 4-10 Гар бөмбөгийн мэргэжлээр илгээгдсэн ЖАЙКА-ийн сайн дурынхны томилгоо (Эх сурвалж: “Монгол Улсад томилсон үзүүлэлт” -Microsoft Excel мэдээлэл -ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар)

²¹ 1993 оны намрын сонгон шалгаруулалтын үеийн сайн дурынхныг хүлээн авах хүсэлтийн судалгаанаас иш татав

²² 1993 оны намрын сонгон шалгаруулалтын үеийн сайн дурынхныг хүлээн авах хүсэлтийн судалгаанаас иш татав

2007 оны 8-р сарын 15-ны өдөр гаргасан төслийн зохицуулагч Үэки Кейкогийн ажлын эцсийн тайланд “Сайн дурын гишүүн ажиллаж буй гар бөмбөгийн багийн гишүүд Монголд алдаршсан өрсөлдөгчөө доромжлох, алдаа гаргасан өөрийн багийн тамирчинг хараах зэрэг муу зуршлаа орхин, өөрийн багийн тамирчнаа урамшуулан, хүчээ нэгтгэх, шүүгчийн шийдвэрийг хүндэтгэх зэргээр сайн өөрчлөлт гарч нэр хүндтэй болсон.” гэж тэмдэглэсэн байдаг.

(2) Жүдо

1999 онд Жүдо Бөхийн Холбоонд анхны сайн дурын гишүүнийг илгээж, түүнээс хойш нийт 8 хүн томилогдсон байна. 2009 онд Улаанбаатар хотын Монголын Жүдо Бөхийн Холбоонд 4 дэх үе болон томилогдсон Огүра Дайки JOCV-ийн тайланд үндэслэвэл, сүүлийн 3 үеийн гишүүдийн илгээлтийн үр дүнд үндэсний шигшээ багийн ур чадвар илт нэмэгдсэн бөгөөд 2006 онд зохион байгуулагдсан Азийн Наадам, 2007 оны Зүүн Азийн Наадамд өндөр амжилт үзүүлсэн. Мөн, 5-20 насны 120 эхлэн суралцагч элсүүлэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн Монгол Жүдо Бөхийн Академи нь “Эрч хүчээ сайн үйлсэд ашигла, Өрөөл бусадтайгаа хамтдаа хөгж” гэсэн философид тулгуурласан, тухайн үедээ Монголын жүдод дутагдаж байсан, хүнийг төлөвшүүлэхийг гол зарчмаа болгосон заах аргыг тасралтгүй хэрэгжүүлж ирсэн.

2011 онд Орхон аймгийн Монголын Жүдо Бөхийн Холбоонд томилогдсон Сасо Юүсүкэ JOCV-ийн тайланд үндэслэвэл, тухайн нутагт жүдо нь ихэд дэлгэрч, 12-18 насны 100 гаруй хүүхэд залуучууд жүдогоор хичээллэж байна. JOCV нь долоо хоногт 5 удаа, үдээс өмнө болон үдээс хойш тус бүр 2-3 цагаар 100 гаруй монгол хүүхдэд хичээл заасан. Мэндчилгээ, цэвэрлэгээ, цаг барих тухай зааварчилгааг монгол багш нараас бараг заагаагүй, жүдогийн суурь хэвшээгүй байдалтай, зөвхөн жүдогийн техникийг суръя гэсэн байдал нийтлэг харагдаж байсан. JOCV нь удирдагч хүн өөрөө өөрчлөгдөхгүй бол сайн дурын гишүүний үйл ажиллагаа нь түр зуурын чанартай зүйл болно гэдгийг ухамсарлан, сурагчдад ахлах ангийнхан нь доод ангийнхандаа, ахмад нь залуустаа зааж сургах гэсэн шугамаар ч зааж сургах арга хэлбэрийг нэвтрүүлж, дасгалжуулагч багш нарт ч сургалт явуулсан. Үйл ажиллагааны сүүлийн жилүүдэд монгол дасгалжуулагч багшаас сурагчид, ахлах ангийнхнаас доод ангийнхандаа мэндчилэх, цэвэрлэгээ хийх, цаг баримтлахыг заадаг хэлбэр бүрэлдэн тогтсон байна.

4.2.7 Голлох 4 салбарын үйл ажиллагааны үр дүн ба цаашид шийдвэрлэх асуудлын тойм

Монголд голлож буй дээр дурдсан: япон хэлний багш, боловсрол, эрүүл мэнд болон биеийн тамирын 4 салбар дахь үйл ажиллагааны үр дүн болон цаашдын асуудлыг нэгтгэв.

Хүснэгт 4-4 Салбар тус бүрийн үйл ажиллагааны үр дүн ба цаашид шийдвэрлэх асуудал

Япон хэлний багш

/үр дүн/

- Голчлон Улаанбаатар хотын бага, дунд, ахлах сургууль болон боловсролын газар гээд томилогдсон газрынхаа сурагчдын япон хэлний чадвар болон япон хэлний монгол багш нарын заах арга барилын чадварыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулж ирсэн. Анх эхэлсэн 1992 онд сургалтын материал дутмаг, сургалтын хөтөлбөрсайн боловсрогдоогүй, хүлээн авагч тал болох монгол багш нарын тоо цөөн, туршлага бага гэх мэт асуудлууд оршиж байсан боловч 2016 оны өнөөгийн байдлаар “Япон төв” ба “Япон хэлний багш нарын холбоо”-ны үйл ажиллагаа тогтворжиж, япон хэлний заах аргын материал боловсронгуй болж, заах аргын дугуйлан идэвхжсэн. Мөн түүнчлэн, Япон Улсад суралцагсадын тоо нэмэгдэж, хамтрагч тал нь Япон Улсад суралцсан туршлагатай, япон хэлээр харилцахад бэрхшээл учрахгүй түвшинд хүрч сайжирчээ.
- 2001 оноос Япон хэлний түвшин тогтоох шалгалтыг Улаанбаатар хотод зохион байгуулдаг болж, мэдлэгийн түвшингээ ахиулах гэсэн зорилго, тэмүүлэл нэмэгдсэн.

/асуудал/

- 2012 онд япон хэлний техникийн зөвлөхийн зүгээс "Япон хэлний сургалтыг нийслэлд

<p>төвлөрүүлэх хэрэгтэй" гэж зөвлөмж болгосон байдаг хэдий ч, орон нутагт япон хэлний дугуйлангаар япон хэл зааж буй JOCV нар ч олон байгаа тул, орон нутаг дахь япон хэлний боловсролын эрэлт хэрэгцээг дахин хянаж үзэх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> • Унаган япон хэлтэй харьцах боломж бололцоо багатай япон хэл суралцагч монгол хүнд зориулсан заах аргыг тусгайлан боловсруулах шаардлагатай. • Урьд өмнө нь Япон Улсад суралцах, япон хэл ашигласан ажилд орох зорилгоор хэл сурдаг байсан бол, одоо харин ажлын байр хангалтгүй болж, япон хэлийг сурах давуу тал багасч байна.
<p>Боловсролын салбар</p> <p>/үр дүн/</p> <ul style="list-style-type: none"> • 2005 онд шинэ стандартыг боловсруулж, нэвтрүүлснээр "хүүхэд төвтэй" сургалт явуулах үүднээс СӨБ, бага сургуулийн боловсрол (ялангуяа дүрслэх урлаг, математик) биеийн тамир, байгалийн ухааны багш нар томилогдож, социалист нийгмийн үеэс зонхилж ирсэн цээжлэхийг голлосон арга барилаас хүүхдүүдээр бодуулж сэтгүүлэх хичээл хийлгэх, түүнийг зохион байгуулах, бэлтгэлийг хангах, заах аргачлалын гарын авлага гаргах зэрэг асуудлаар монгол багш нарт арга барил, технологи шилжүүлэх тал дээр тодорхой үр дүнд хүрсэн. • ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдтэй хамтран ажилласан туршлага бүхий монгол багш нар, тэдний (ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн) хичээлийн бэлтгэл, заах арга барил, хичээл зүтгэлийг өндрөөр үнэлж байсан. <p>/асуудал/</p> <ul style="list-style-type: none"> • Багш нарын заах сэтгэл, заах арга барилын чадвар нь хүн бүрт адилгүй байсан бөгөөд олон жилийн туршид хэрэглэж ирсэн заах аргаа өөрчилж чадахгүй балмагдсан байдал ажиглагдаж байсан тул, ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд сургууль дээр ажиллах, бодитоор хичээл заах явцдаа заах аргаа улам бүр сайжруулах үйл ажиллагааг нь цаашдаа ч дэмжих шаардлагатай. • Асар их мэдээлэл агуулсан сурах бичгээс нэгэн зүйл, цогц зүйлийг аль алийг нь зэрэгцүүлэн агуулсан хичээл болгон заахад хүндрэл учирч байсан бөгөөд хүүхдийн чадварт нийцүүлсэн хичээлийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг туслалцаа хэрэгтэй юм.
<p>Эрүүл мэндийн салбар</p> <p>/үр дүн/</p> <ul style="list-style-type: none"> • Сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эх баригч нар нь өөрсдийн томилогдон очсон газартаа шаардлагатай байсан сувилгааны мэдлэг технологийг сайжруулах үүднээс монгол ажилтантай эмнэлгийн орчинд хамтран ажиллахын зэрэгцээ, сургалт зохион байгуулж гарын авлага хийх зэргээр зохих үр дүнд хүрч байсан. • Хөдөлгөөн засалчийн хувьд, Монгол Улсад шинэ салбар байсан тул суурь технологийг зааж сургах, нөхөн сэргээх кабинет тохижуулах зэргээр зохих үр дүнд хүрсэн. <p>/асуудал/</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний салбарт шийдвэрлэх асуудал их байгаа бөгөөд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх шаардлагатай. • Хөдөлгөөн засалч нь шинэ салбар бөгөөд үргэлжлүүлэн дэмжих шаардлагатай. Мөн түүнчлэн, хөдөлгөөн засалчийн хувьд энэ жил сургууль шинээр төгсөгчид олноор гарах төлөвтэй байгаа тул тэднийг бодит практик дээр зааж сургах, багш сургагчийг мөн заах аргад сургах шаардлагатай байгаа юм.
<p>Биеийн тамирын салбар</p> <p>/үр дүн /</p> <ul style="list-style-type: none"> • Гар бөмбөгийн хувьд, 1990-ээд оноос дотоодын лиг байгуулахад хувь нэмрээ оруулж, Орхон аймгийн эрэгтэй эмэгтэй баг түрүүлсэн зэрэг дотоодын гар бөмбөгийн хөгжлийг нэмэгдүүлэх, арга технологийг сайжруулах, мөн заах аргын гарын авлагыг зохиох зэргээр дасгалжуулагч багш нарыг бэлтгэхэд хувь нэмрээ оруулсан. • Агаарын теннисны хувьд, Монгол Улсад шинэ спортын төрөл байсан бөгөөд энэхүү спортоор хичээллэгсдийг нэмэгдүүлэх, Монголын Бадминтоны Холбоог үүсгэн байгуулах зэрэг зохих

үр дүнд хүрсэн байна.

- Жүдогийн хувьд, Үндэсний шигшээ багийн арга технологийг сайжруулахад хувь нэмэр оруулж, сургасан оюутан нь Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медаль хүртсэн зэрэг үр дүн гаргасан байна.
- Биеийн тамирын салбарт арга технологийг сайжруулахын зэрэгцээгээр хэрэгслийг ариг гамтай ашиглах, цэвэрлэгээ хийх, бэлтгэлийн цагийг чанд баримтлах, мөн түүнчлэн, талархах сэтгэл, хүчин чармайлт, мэндлэх хүндлэх ёс гэх мэт спортын сэтгэлзүй, ёс суртахууныг зааж сургахад хувь нэмэр оруулж ирсэн.

/асуудал/

- Спортын өндөр амжилт гаргахад урт хугацаа хэрэгтэй байдаг тул урт хугацааны төлөвлөлт, дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Үүнээс гадна, арга технологи сурч, ялалт байгуулахыг урьтал болгох хандлага байдаг тул, спортоор дамжуулан хүүхэд залуучуудад хүмүүжил олгоход үргэлжлүүлэн хувь нэмрээ оруулах боломжтой юм.

4.2.8 Бусад ажил мэргэжил

(1) Хүүхэд залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа, хүмүүжлийн сургалт

Биеийн тамир, хүмүүжилд хамаарах мэргэжил “Хүүхэд залуучуудад чиглэсэн арга хэмжээ”-ний гишүүн 2002 оноос эхлэн илгээгдэж өнөөг хүртэл нийт 23 хүн томилогдон ажиллажээ. Хүлээн авах байгууллага нь, Хүүхэд залуучуудын төв, Улсын хүүхдийн асрамжийн газар, аймгийн хүүхдийн ордон, аймгийн хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс, сургууль гэх мэт олон төрлийн байгууллагууд байгаа ба сүүлийн жилүүдэд орон нутагт олон гишүүд очиж ажиллаж байгаа билээ.

(2) Мэргэжил олгох сургалт

Мэргэжил сургалтын салбарт, ТИС (одоогийн ШУТИС)-д 26 хүн, ШУТИС-д 21 хүн, нийт 47 хүн томилогдсон нь хамгийн олон юм. Мэргэжлийн төрлөөр нь үзвэл, бэлэн хувцас, системийн инженер, цахим инженер, компьютер технологи, компьютерийн багш, машины засвар үйлчилгээ, барилга архитектур, дизайн, нийтийн хоол, үсчин зэрэг олон төрөл байна. Илгээлтийн бүс нутгийг авч үзвэл, орон нутагт цөөнх томилогдож, ихэнхи нь Улаанбаатар хотод томилогджээ.

1993 онд системийн инженерээр ТИС-ийн эрчим хүчний факультетэд томилогдсон Итоо Ёосүкэ JOSCV-ийн тайлангаас үзвэл, түүний үйл ажиллагааг компьютер технологийн сургалт болон тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт гэсэн 2 үндсэн хэсэгт хувааж болохоор байна. Ялангуяа, Монголын иргэдэд дутагдаж байсан зүйл болох “Ирээдүйн хөгжлийн төлөв”, “Үр ашиг” гэсэн ойлголтуудыг программчлалаар дамжуулан заасан. Мөн “Дүрэм болон түүний үйлчлэх цар хүрээ, нөхцөл”-ийн тухай ойлголтыг чухалчлан их дээд сургуулиуд дахь хичээлээ явуулсан. 2011 онд компьютерийн багшаар Сэлэнгэ аймгийн мэргэжил олгох сургалтын төвд томилогдсон Кабүраги Тадатака JOSCV-ийн тайлангаас үзвэл, компьютерийн ангид сурагчдын ашиглах 20 гаруй компьютер байсан нь бүгд вирусдэж, хэвийн ажиллах боломжгүй болсон байснаар зогсохгүй хамт ажиллаж байсан багш нарын ИТ-ийн мэдлэг муу байсан зэрэг асуудлууд оршиж байжээ. 2 жилийн үйл ажиллагааны үр дүнд, компьютерийн дэд бүтцийн зохих орчинг бүрдүүлж, томилогдон ирэхээс өмнөх үетэй харьцуулахад сайжруулалт хийж чадсан.

(3) ХБИ-дэд үзүүлэх дэмжлэг

ХБИ-дэд дэмжлэг үзүүлэх салбарт 2001 оноос өнөөг хүртэлх хугацаанд, асаргааны мэргэжлээр 13 хүн илгээгдэж байжээ. Мөн брайль үсэг, протез буюу хиймэл эрхтний үйлдвэрлэл, тусгай сургалт, нийгмийн ажилтан гэсэн мэргэжил бүхий гишүүдийг ХБИ-дэд дэмжлэг үзүүлэхээр илгээж байсан байна. 2009 онд Улаанбаатар хотын 25-р тусгай сургуульд томилогдсон Мизүсава Хидэюки JOSCV-ийн тайлангаас үзвэл, тэрээр 1) ХБХ-ийн бие засах өрөөний орчинг сайжруулах болон хувь хүний нууцлалыг хангахын тулд зөөврийн бие засах газар болон өрөө зааглах хаалт хийж суурилуулах, 2) ХБИ-дэд зориулсан дэмжлэг үзүүлдэг барилга байгууламжийн план зургийг хийх, 3)

Гэрээр боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, 4) Семинар зохион байгуулах, 5) Сургалтын материал танилцуулах, сургалтын материал үйлдвэрлэх болон заах аргын зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа явуулснаа тайлагнажээ.

4.3 Хүлээн авагч талын үнэлгээ (ярилцлага)

ЖАЙКА-ийн сайн дурын гишүүний дэмжлэгийг хүлээн авагч тал болох Монгол Улсын Сангийн яам, гишүүдийг хүлээн авагч байгууллага, хамтрагч нар ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааг хэрхэн үнэлж байгаа тухай асуудлаар холбогдох хүмүүсээс ярилцлага авсан юм. Ярилцлага өгсөн бүх байгууллага, сайн дурын гишүүдийн хүчин зүтгэл, ажлын үр дүнг өндрөөр үнэлж байв. Ялангуяа онцлон тэмдэглэхэд 2010 оны 2-р сард тухайн үеийн Ерөнхий сайд С.Батболд ЖАЙКА-гийн сайн дурынхныг хүлээн авч уулзах үеэрээ “Залуу сайн дурынхан ч ахмад сайн дурынхан ч Монголын хөгжилд их хувь нэмэр оруулж байна. Сая сайн дурын гишүүдийн зүгээс мэндчилж үг хэлснийг сонсоод монгол хэлэндээ маш сайн байгааг үзээд сэтгэл хөдлөн баярлав.” гэж ЖАЙКА-гийн сайн дурын үйл ажиллагааг үнэлж хэлжээ. Мөн 2011 оны 3-р сарын 11-нд Зүүн Японы газар хөдлөлтийн гамшгийн дараа Ерөнхий сайд С.Батболд / тухайн үед/ сайн дурынхны төлөөлөгчийг хүлээн авч уулзахдаа “Японд маш хүнд гамшиг учирчээ. Монгол Улсын ЗГ өнөөг хүртэл Японы ЗГ-аас маш их дэмжлэг авч ирсэн тул боломжтой бүхий л хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ” гэж хэлсэн нь энэхүү гамшгийн үеэр дэлхийн улс орнуудын Засгийн газрын тэргүүдээс хамгийн түрүүнд Японд туслахаа илэрхийлсэн хэрэг байлаа²³.



Ерөнхий сайд С.Батболд ЖАЙКА-гийн сайн дурынхныг хүлээн авч уулзах үеэр
(эх сурвалж: МОНЦАМЭ, 2011 оны 3-р сарын 18-ны өдөр)

4.3.1 Сангийн яам

2003 оноос Япон Улсын зээл тусламжийн хүлээн авагч цонхны үүрэг гүйцэтгэж ирэхдээ элдэв ноцтой асуудал, саад тотгор үүсгэлгүй, сайн харилцааг үүсгэн, хамтран ажиллаж ирсэн билээ. ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагаа нь ODA-ийн үнийн дүнгийн хувьд хэдийгээр бага боловч, тусламжийн хэлбэрийн хувьд сайн жишээний нэг гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл “Өвсний үндэс” хэлбэрийн тусламж бөгөөд боловсролын байгууллага болох бага сургууль, дунд сургуулиудад хэрэгжин, өндрөөр үнэлэгдэж байдаг билээ. Монгол Улс нь дэлхийн улс орнууд болон Олон улсын байгууллагуудаас зээл тусламж авч ирсэн бөгөөд хэлбэр нь харилцан адилгүй юм. Энэхүү төсөл нь хүн хоорондын харилцаагаар дамжуулан хоёр орны харилцааг өргөжүүлэн тэлдэг гэдгээрээ тэдэнтэй үндсэн чанар нь ижил юм. JOCV-ийн залуу сайн дурын гишүүдийн урагшаа тэмүүлсэн чиг хандлага нь ажиллаж буй байгууллагадаа томоохон нөлөө үзүүлж байна. Түүнчлэн онцгойлон тэмдэглэхэд сүүлийн үеийн эмнэлгийн салбарт сэргээн засах эмчилгээ, биеийн тамирын гишүүд томилогдон ажилласнаар эрүүл мэнддээ анхаарал тавих явдал нь нэн чухал зүйл юм гэдгийг ойлгуулсан. Орон нутаг дахь үйл ажиллагаагаа цаашид заавал үргэлжлүүлэхийг хүсч байна. Өвсний үндэс түвшинд хүн хоорондын харилцаа улам тэлнэ гэдэгт найдаж байна гэлээ²⁴.

²³ Элчин сайд асан Такүо Кидокоротой хийсэн ярилцлага (2017 оны 1-р сарын 15-ны өдөр)

²⁴ 2016 оны 10-р сарын 7-ны өдөр авсан ярилцлага

4.3.2 Эрүүл мэндийн яам

2016 оны 9-р сарын сонгуулийн дүн гарснаар бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж өнөөдрийг хүртэл “Эрүүл мэнд, спортын яам” гэж нэрлэгдэж байсан нь “Эрүүл мэндийн яам” болсон. Эрүүл мэндийн салбарт JOCV-ээс гадна KOICA, TICA²⁵, UNV, АНУ-ын Энх тайвны корпусынхан хамтран ажиллаж байгаа билээ. JOCV-ийн гишүүдтэй ажилд томилогдон ирэх, ажлаа хүлээлгэж нутаг буцах үеэр нь л уулзаж мэндчилэх төдий байсан боловч JOCV-ийн үйл ажиллагааны дотоод агуулгыг ойлгон хүлээж авах шаардлагатай гэж үзсэний үндсэн дээр энэ онд анхны санал солилцох уулзалтыг зохион байгуулж, ойлголтоо гүнзгийрүүлэв. Эрүүл мэндийн яам нь JOCV-ийн орон нутаг дахь хамтын ажиллагааг цаашид үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа ба нийслэлийн сэргээн засах эмчилгээний салбарт JOCV-ийн хамтын ажиллагаа цаашид ч шаардлагатай байгаа бөгөөд өндөр үр нөлөө бүхий үйл ажиллагаа гэж ойлгож байна. Монгол Улсын хувьд сэргээн засах эмчилгээний салбар нь шинэ салбар бөгөөд, 2007 онд анхны монгол согог засалч мэргэжилтэн болох хөдөлгөөн засалч төрж гарсан хэдий ч, цаашид мэргэжлийн сургалт, удирдамж шаардлагатай гэж бодож байна. Улаанбаатар хотод тархинд цус харвалт өгсний дараах өвчлөл хамгийн ихээр тохиолддог ба түүний дараа хотод автомашины осол, хөдөөд морьноос унаж бэртэх осол ихээр гардаг учир нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай хүмүүс олон байдаг онцлогтой. JOCV-ийн томилолтын хугацаа 2 жил байгааг 4-5 жилийн урт хугацаагаар сунгаж ажиллуулах нь зүйтэй гэж бодож байна²⁶.

4.3.3 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Цэдэвсүрэн ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд арвин туршлагатай байдаг бөгөөд боловсролын салбарт маш их дэмжлэг үзүүлж байдаг талархал илэрхийлэв. Мөн, Боловсролын яамнаас ХБХ-ийн нялх балчир байх үеэс нь эхлэн дээд сургуульд суралцах хүртэл заах арга боловсруулах баг байгуулсан бөгөөд БНСУ-д сургалтад хамруулан түүнийгээ Монгол Улсад нэвтрүүлэх оролдлого хийж байгаа боловч, олон төрлийн хүндрэл учирч байгаа тул, цаашид ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдтэй хамтран ажиллахыг хүсч байгаагаа илэрхийлэв. “Өмнө нь, "Боловсрол, шинжлэх ухааны яам" байсан нь 2016 оноос "Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам" болон өөрчлөгдснөөр спортын боловсрол төдийгүй 2020 оны Токиогийн Олимпод бэлтгэх арга хэмжээг ч мөн ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдтэй хамтран зохион байгуулахыг хүсч байна. ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдийн үйл ажиллагааны чиглэл нь бидний зорилготой нэгэн адил тул цаашид ч хамтран ажиллах хүсэлтэй байна” хэмээн хэлэв²⁷.



Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Цэдэвсүрэн

4.3.4 Жүдо бөхийн холбоо

Монголын Жүдо Бөхийн Холбооны тэргүүн Машбат, Монголын Жүдо Бөхийн Академийн төлөөлөгч Г.Бат-Эрдэнэ нар JOCV жүдогийн гишүүд Монгол Улсын жүдогийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж ирсэн гэж үнэлэв. Өнгөрсөн 20 жилд эрэгтэй эмэгтэй нийт 8 JOCV нар нь жүдогийн арга технологи сайтай байсан бөгөөд уламжлалт япон жүдогоор дамжуулан Япон Улсын соёлыг бидэнд зааж өгсөн юм. JOCV нар тамирчид бэлтгэх, боловсон хүчин бэлтгэх аль аль тал дээр хүчин зүтгэсэн. Ялангуяа JOCV-ийн японы уламжлалт жүдо 10-19 насны суралцагчидад суурь мэдлэгийг шингээхэд зориулсан дасгал, арга барил маш сайтай, боловсронгуй байсан бөгөөд



Монголын Жүдо Бөхийн Холбооны тэргүүн Машбат, Монголын Жүдо Бөхийн Академийн төлөөлөгч Бат-Эрдэнэ

²⁵ TICA: Turkish International Cooperation Administration (Туркийн хамтын ажиллагаа хөгжлийн агентлаг)

²⁶ 2016 оны 10-р сарын 7-ны өдөр авсан ярилцлага

²⁷ 2017 оны 1-р сарын 18-ны өдрийн ярилцлага

цаашид ч энэхүү арга барилыг хэвээр үргэлжлүүлэхийг хүсч байна. Монгол Улсын орон нутагт нуугдмал авьяастай хүүхдүүд их байгаа учир Монголын Жүдо Бөхийн Холбоо “Judo for Tomorrow” гэсэн сэдвээр орон нутагт идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар 2 JOCV Дархан болон Хөвсгөл гэсэн хөдөө орон нутагт жүдо зааж байна. Баруун аймгийн Увс, Ховдод ч татами бүхий бэлтгэлийн заалтай болсон бөгөөд орон нутаг дахь үйл ажиллагаа урагшилж байна. Зурагтаар л харж байсан японы уламжлалт жүдог шууд амьдаар нь мэдрэх боломжийг өгч байгаа JOCV бол маш чухал тул энэхүү харилцаагаа цаашид ч үргэлжлүүлэх хүсэлтэй байна²⁸.

4.3.5 Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургууль


1992 онд ТИС эхний JOCV-г хүлээн авч, 1997 онд дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургууль болсныхоо дараа 15 гишүүн хүлээн авсан. Уг сургуульд нэгэн зэрэг 5 гишүүн томилогдон үйл ажиллагаа явуулсан үе ч бий бөгөөд урьдчилсан төлөвлөгөөтэйгээр JOCV, SV нарыг хүлээн авдаг байсан учир хангалттай үр дүнд хүрч чадсан. Өөрийн туршлагаас хуваалцахад, Монгол Улсын хүлээн авагч байгууллага дотор JOCV-г хүлээн авах шаардлага шалтгаанаа бүрэн ойлгоогүй байгууллага ч байдаг бөгөөд, хүлээн авч буй зорилго, хүлээж буй үр дүн нь тодорхой бус байгууллага ч бас байдаг. Хүлээн авагч байгууллагын бэлтгэл хангагдаагүй, 2 жил ажиллах төлөвлөгөө нь ч учир дутмаг байна. Хүлээн авагч байгууллагыг үнэлэх үнэлгээ болон түүний жишиг тодорхойгүй байгааг тодорхой стандартад оруулж, түүнийхээ дагуу дүгнэж үнэлэх нь зүйтэй гэж би боддог. Мөн хүлээн авагч тал засвар үйлчилгээ тоног төхөөрөмж горилохоос илүүтэйгээр хүнтэй харилцах оюун санааны ололтыг эрэлхийх нь чухал юм. Тоног төхөөрөмж гэх мэт материаллаг эд зүйлс хэдэн жилийн дараа эвдэрч үгүй болох учир тийм ч чухалчлан авч үзэх зүйл биш юм. ЖАЙКА-ийн сайн дурынхантай харилцаа тогтоож, сэтгэл зүрхээрээ холбоотой байх нь чухал бөгөөд манай сургуулийн багш нар дотор томилолтын хугацаа нь дууссан гишүүдтэйгээ байнга холбоотой байж, харилцаагаа үргэлжлүүлэн, дараагийн хамтын ажиллагааг эхлүүлсэн тохиолдол ч олон бий. JOCV нар нутаг буцсаныхаа дараагаар ч харилцан холбоотой байж шинэ техник технологи танилцуулдаг, манай сургуулийн багш Японд очиж мэргэжил дээшлүүлэх боломж гардаг зэрэг нь оюун санааны холбоог чухалчилж ирсэний үр дүн гэж ойлгодог. Өнөөг хүртэл манай сургуульд сургалт, заавар, удирдамж өгч байсан JOCV, SV нартаа чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье хэмээн ярьлаа²⁹.



Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургуулийн захирал асан Юра

4.3.6 Улсын 3 дугаар төв эмнэлэг

Улсын 3 дугаар төв эмнэлгийн сэргээн засах эмчилгээний тасгийн дарга Урангэрэл, өнөөдрийг хүртэл тус эмнэлэгт ажиллаж байсан сайн дурынхны тухай ярихдаа, “Сайн дурын бүх гишүүд бидний мэддэггүй байсан олон зүйлийг зааж сургасан. Мөн өвчтөнүүдтэй харьцах байдал нь онцгой сайн, бидэнд үлгэр жишээ болдог. Манай эмнэлгийн дарга ч бас алс хол орноос бидэнд туслахын тулд хүрэлцэн ирсэн хүмүүст ямагт талархаж явдаг.” хэмээн үнэлж хэлэв. Өнөөг хүртэл Улсын 3-р төв эмнэлэгт хуваарилагдсан хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалчийн үндсэн үйл ажиллагаа болон ажлын үр дүнг доорхи хүснэгтэд илэрхийлэв.



Сэргээн засах эмчилгээний тасгийн дарга Урангэрэл

²⁸ 2016 оны 10-р сарын 12-ны өдөр авсан ярилцлага

²⁹ 2016 оны 10-р сарын 12-ны өдөр авсан ярилцлага

Хүснэгт 4-5 Улсын 3-р төв эмнэлэгт томилогдсон сэргээн засах эмчилгээний салбарын JOCV нарт хандсан сэргээн засах эмчилгээний тасгийн даргын ярианаас

Томилогдсон он	JOCV-ийн нэр	Сэргээн засах эмчилгээний тасгийн даргын яриа
2009 он	Кандори Нацүэ (хөдөлмөр засалч) Үсами Томохиро (хөдөлгөөн засалч)	ДЭМБ-аас сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөтэй байгаа гэснээр, сэргээн засах эмчилгээний өрөө байгуулах тухай болон хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүдэд тохирсон нөхөн сэргээх эмчилгээний орчинг бүрдүүлэх төлөвлөгөө гаргасан.
2012 он	Шимизү Юка (хөдөлмөр засалч) Коизүми Юүичи (хөдөлгөөн засалч)	Сэргээн засах эмчилгээний тасгийн дарга, Мэдрэлийн тасгийн дарга, Монгол Улсад сурч боловсорсон анхны хөдөлгөөн засалчид бүгд бидний үйл ажиллагааг зөвөөр ойлгодог. Ялангуяа, эхнээсээ хамтран ажиллагч болсон хөдөлгөөн засалчийн хувьд, Япон Улсад очин сургалтад хамрагдаж байсан, анхдагч 1-р үеийн дадлагжигчийн хувьд ажилдаа өндөр хариуцлагатай хандаж байснаар шинэ арга технологи дамжуулах ажлын үр дүн өндөр байв. Бид хоёр өвчтөний нөхцөл байдлыг илүү сайн ойлгохын тулд нөхөн сэргээх эмчилгээний карт нээж, хүйс, нас, өвчний байдал зэргийн хандлагыг судалсан. Ингэснээр, мэс заслын дараа 24-72 цагийн дотор нөхөн сэргээх эмчилгээ явуулах нь үр дүнтэй байдгийг ажилтнууд ойлгон хүлээж авсан. Мөн, нөхөн сэргээх эмчилгээний карттай болсноор, өвчтөний бие махбодийн онцлог, өвчний түүх, амьдралын хэв маягийг харгалзан нөхөн сэргээх эмчилгээг явуулж, хамтрагч тал ч үүний үр өгөөжийг мэдэрсэн.
2014 он	Китагава Юки (хөдөлгөөн засалч)	НҮБ-ын Мянганы сорилтын зорилтын хүрээнд тусгайлан тоноглогдсон сэргээн засах эмчилгээний өрөө болон тоног төхөөрөмжийг улам сайжруулж боловсронгуй болгоход эмнэлгийн төсөв, үйл ажиллагааны зардлаас хөрөнгө гаргаж өгснөөр сэргээн засах эмчилгээний өрөө шинэчилэгдсэн. Нөхөн сэргээх эмчилгээний карт нь цусны диализ хийлгэх хүн, чихрийн шижинтэй хүн гээд бусад төрлийн өвчтөнд хэрэглэх болж, хүрээгээ тэлсэн.
2016 он	Ооцүки Мика (хөдөлмөр засалч)	Үе үеийн сайн дурын гишүүдийн хуримтлуулж ирсэн үйл ажиллагаанд тулгуурлан, Монгол Улсад өөр ямар арга технологи шаардлагатай байгаа талаар өдөр бүр бодож, хамтрагч талтайгаа ажиллаж байна. Мөн, удахгүй төгсөх гэж байгаа Монголын хөдөлмөр засалчдад хичээл заадаг Ооцүки багшаас зөвлөгөө авдаг.

(Эх сурвалж: Улсын 3 дугаар төв эмнэлгийн сэргээн засах эмчилгээний тасгийн даргаас авсан ярилцлагаас иш татав)

4.3.7 Тархины саажилттай хүүхдийн 10 дугаар цэцэрлэг

2001 онд анхны гишүүнээ хүлээн авч 2011 он хүртэлх 10 жилийн хугацаанд 5 гишүүнтэй хамтран ажилласан. Тус цэцэрлэг нь 1964 онд нээгдэж, эхэндээ 48 хоногтойгоос 2 нас хүртэлх нярайн ясли хэлбэртэй байсан бол 1993 оноос ХБХ-ийг авдаг болж 2000 оны үеэс ХБХ-аар дагнах болсон юм. ХБХ-тэй хэрхэн харьцах талаар сурч мэдэх үүднээс тусгай хэрэгцээт боловсролын сургуульд JOCV ажиллаж байгааг сонсоод, ЖАЙКА-д сайн дурын ажилтан ирүүлэх хүсэлт гаргасан юм. Сайн дурын гишүүн томилогдон ирэх болсноос хойш хүүхдийн байр байдлыг ажиглах, эрүүл мэндийн байдлыг ойлгодог болж хүүхэд нэг бүрийн нөхцөл байдалд тохирсон хөтөлбөр зохиож хэрэгжүүлэх болсон. Мөн, өглөөний болон ажил дууссаны дараах уулзалтыг ч JOCV-ийн нөлөөллөөр нэвтрүүлж, өнөөг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Анхны гишүүний санаачилсан “Спартакиад”-ыг Улаанбаатар хотын бусад цэцэрлэгийн ХБХ-үүдтэй



Энхмөнх багш

хамтран зохион байгуулах болж, 16 жил явуулж байна. Тэр болтол хүүхдүүдийг түр харахаас бус боловсролын тал дээр төдийлөн анхаардаггүй байсан. Бусад орны сайн дурынхныг хүлээн авсан туршлага байгаа ч, япон хүмүүс нарийн чанд, хэлсэн л бол хийж гүйцээх сэтгэлийн тэнхээтэй хүмүүс байдаг. Бид маш их зүйлийг сайн дурын гишүүдээс сурч авсан. JOCV-ийг 10-аас дээш жил хүлээн авах боломжгүй гэж дуулсан учраас хүсэлт гаргаагүй боловч боломжтой бол үргэлжлүүлэн хүлээн авмаар байна³⁰.

4.3.8 IV ДЦС

IV ДЦС нь 1979 оны хуучин ЗХУ ба Монгол Улсын Засгийн газрын хоорондын гэрээнд үндэслэн баригдсан. 1996 оны хавар Японоос анхны SV-г хүлээн авч, цахилгаан станцын удирдлага менежментийн зөвлөгөө авсан. 2002 онд 1-р үйлдвэрийн групп (7 хүн), 2005 онд 2-р үйлдвэрийн групп (4 хүн) томилогдон ирж зааварчилгаа авч байсан. Түүний дараагаар, 2007 онд богино хугацаагаар 1 SV, 2008-2010 онуудад жил бүр 1 гишүүн, 2011 онд 2 сайн дурын гишүүн хүлээж авсан. Нийт 17 хүн хүлээж авсан ба



Олон SV нар хувь нэмрээ оруулсан
Дулааны IV цахилгаан станц (гадна талаас)

SV-нүүд зуух, гагнуур, цахилгаан, хяналтын самбар гэх мэт салбар тус бүрээр техникийн зааварчилгаа өгч, өдөр тутмын болон сар бүрт явуулах техникийн хяналт зэрэг ослоос урьдчилан сэргийлэх технологийг сургахад хувь нэмэр оруулсан. SV-гийн зөвлөгөөг 2-3 хүн орчуулж ирснээс гадна хамтрагчийн зарим нь англи хэлээр ойлголцох боломжтой байсан тул зөвөөр ойлголцож байсан. Түүнчлэн, үйлдвэрийн өдөр тутмын ажлын аюулгүй байдлыг хангахыг гардан зааж сургасан нь хамтрагчийн мэдлэг боловсролд дэмжлэг болсон. Өнөөдөр хамтрагч нар SV-ээс сурсан зүйлээ залуу ажилчдад зааж өгч байгаа боловч хүндрэл гарч байна. Өнөөг хүртэл үзүүлж ирсэн ЖАЙКА-ийн тусламж дэмжлэгт гүнээ талархаж байдгаа илэрхийлье³¹.

4.3.9 Эрдэнэт хотын Биеийн тамир спортын газар

Газрын дарга Зулбаатар (Монголын бадминтоны холбооны ерөнхий нарийн бичгийн дарга) ярихдаа, би өөрөө гар бөмбөгийн тамирчин байхдаа Азийн гар бөмбөгийн сургалтад (1992 он, Чиба муж) хамрагдах үедээ анх удаа JOCV-ийн тухай мэдсэн юм. Эргэж ирээд Сайн дурын гишүүн хүлээн авах тухай хүсэлт гаргаж агаарын теннисийн Такэда Норио, гар бөмбөгийн Сүзүки Ясүхиро нарыг хүлээн авсан. Үүний үр дүнд, гар бөмбөгийн чанар сайжирч, Эрдэнэт хот Улсын аварга болж алдаршсан. Мөн агаарын теннис нь Монгол Улсад анх удаагаа спортын нэгэн төрөл болж, Эрдэнэт хотоос Монгол Улсад түгэн дэлгэрсэн. Агаарын теннисийн холбоо байгуулагдаж, лого маркийг нь ч бас JOCV зохиосон. JOCV нар цагийг чанд баримтлах, япон хэл заах, олон Улсын харилцааг хөгжүүлэх зэргээр биеийн тамир, спортоор дамжуулан ихээхэн хувь нэмэр оруулсан. Биеийн тамирын мэрэгжилтэй гишүүдийг хүлээн авахад онцгой хүндрэл байгаагүй, монгол хэлний асуудал эхлээд хэн хүнгүй байдаг боловч гар хөлөөр зангах, үлгэр жишээ болгон биеэр үзүүлэх зэргээр харилцан ойлголцож, ойртон нөхөрлөх боломжтой байдаг. Цаг хугацаа өнгөрөх тутам тэдний хэл ярианы чадвар сайжирч, харилцан ойлголцоход асуудалгүй болдог. Өмнө томилогдож байсан гишүүн, хамтрагч нар тухайн спортын мэргэжлийн хэллэгийг цээжилж тэмцээн шүүх ч чадвартай болсон. Мөн, ахлах сургуулийн захирал болсон хүн ч бий. JOCV-ээс бусад тусламжийн байгууллагуудад хүсэлт гаргаж байгаагүй ч 3-аас дээш удаа нэг газар сайн дурын гишүүдийг илгээхгүй гэдгийг сонссон учир цаашид хүлээн авмаар байгаа хэдий ч чадахгүй байдалтай байна. JOCV-гүйгээр технологи сайжруулахад учир дутагдалтай зүйл их байна. Гэхдээ дунд сургуулийн түвшинд Японтой гадаад харилцаа тогтоосон бөгөөд сурагч солилцох сургалтыг (1 долоо хоног гаруй) зохион

³⁰ 2016 оны 10-р сарын 12-ны өдөр авсан ярилцлага

³¹ 2016 оны 10-р сарын 13-ны өдөр авсан ярилцлага

байгуулж байна. Спортод дуртай хүмүүс олонтой Монголын орон нутагт JOCV сайн дурын ажилтныг илгээнэ гэдэгт найдаж байна гэлээ³².

4.3.10 Дархан-Уул аймаг 18-р сургууль

Судалгааны баг 2001 оноос 2014 онд Дархан хотын 18-р сургуулийн захирлын үүргийг гүйцэтгэж байсан, 30-р сургуулийн захирал (2016 оны 10-р сард) Шугарсүрэнгийн Ядамсүрэнгээс 2007-2009 онд бага ангийн багшаар томилогдон ажилласан Нишимүра Юмигийн талаар асууж ярилцлага (2016 оны 10-р сард) авлаа.

Японы сайн дурын гишүүн хүлээн авахаар хүсэлт гаргах болсон учир шалтгааныг асуухад, тухайн үед уг сургууль болон уг аймагт АНУ-ын Энх тайвны корпусынхан, мөн КОИСА-ийн сайн дурынхан үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд тус аймгийн боловсролын ажилтнуудын дунд гадаадын сайн дурынхны тусламжийн систем их нэр хүндтэй байсан. Гэхдээ чадварын хувьд хүссэнд хүрэхгүй багш нар ч дотор нь байдаг байжээ. Япон Улсаас мэргэжилтэн ирвэл илүү өндөр чанартай байх болов уу гэж бодсоноос японы сайн дурынхны тогтолцоог нэвтрүүлэх санаа төрсөн гэнэ. Тухайн үед материал хомс байсны улмаас хичээл орох боломжгүй байсан дүрслэх урлагийн хичээлийг сайн дурынхнаар заалгах бодол захиралд байжээ. Дүрслэх урлагийн хичээл нь хүүхдүүдийн ирээдүйн амьдралд шаардлагатай технологи сурахад чухал хичээл хэмээн үзэж, өндөр чадвар бүхий багш хайж байжээ.



30-р сургуулийн захирал Ядамсүрэнг

Томилогдон ирсэн Нишимүра JOCV захирлын зорилгыг ойлгон хүлээн авч түүнийг биелэл болгоход бүхий л хүчээ зориулсан гэнэ. Нишимүра JOCV, өөрийн гар доорхи эд зүйлсийг ашиглан олон төрлийн зүйл хийж болохыг хүүхдүүдэд заасан. Тухайлбал, цаасан хайрцгаар шинэ жилийн сүлд мод хийх, хогны сав чимэх зэрэг, түүхий эд материал худалдан авалгүйгээр арга боловсруулж олон зүйл хийн, хийсэн бүтээлүүдээрээ “Хамтдаа хөгжилтэй хийцгээе” гэсэн ном болгон нэгтгэсэн. Мөн түүнчлэн, Нишимүра JOCV нь бүс нутагт ажиллаж байгаа бусад ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдтэй нэгдэн “Чоно, хүн, ургамал, хонь” гэсэн хичээлийг орсон нь хүүхдүүдэд маш ихээр таалагдсан. Энэ нь дэлхий ертөнцийн бүх зүйл харилцан нэг нэгнийгээ дэмжиж байдаг учраас оршин тогтнодог юм байна гэдгийг хүүхдүүдэд ойлгуулсан хичээл байв. Сургуулийн зүгээс энэхүү хичээлийг дүрс бичлэгт буулган авч, сургалтын материал болгон ашиглаж байна.

Нишимүра JOCV-ийн хичээлд хамрагдсан сурагчид дунд ангид элсэхэд, дунд сургуулийн багш нар “18-р сургуулиас ирсэн сурагчид биеэ даасан, юуг ч гэсэн өөрсдөө хийж чаддаг нь гайхалтай” гэж ярьж байхыг сонссон. Мөн, эцэг эхчүүдийн зүгээс гэртээ юм хаяхаа больсон, гэр бүлийн хэн нэгний хаясан зүйлийг ч гэсэн ямар нэгэн өөр зүйл хийхэд ашиглая гэх болсон тухай мэдээлж байсан. Эцэг эхийн хурлаас Нишимүра JOCV шиг багш нарыг урьж ажиллуулах хүсэлт гарч байсан.

Баян-Өндөр цогцолбор сургуулийн хичээлийн эрхлэгч Саранчулуун ярихдаа, дүрслэх урлагийн хичээлийг зааж байсан Кикүчи Ёшиэ JOCV (2001-2003 бага сургуулийн багш)-ийн заах аргачлалын үр дүнд "хүүхдүүд гар доорхи материалаар ямарваа нэгэн зүйл урлан бүтээхийг сурч, монгол багш нар хичээлийн материал байхгүй учир юу ч хийж чадахгүй гэсэн бодлоосоо өөрсдөө бодож боловсруулах хандлагатай болон өөрчлөгдсөн" гэж Кикүчи JOCV-ийн ажлын үр дүнг үнэлж байсан³³.

4.3.11 Дархан хотын Ус сувгийн удирдах газар

Дархан хотын ус сувгийн газрын усны чанарын шинжилгээний лабораторийн дарга Сарангэрэл ярихдаа, 1998 онд томилогдсон JOCV-ийн Хачижин Томохиро (усны чанарын судалгаа) нь 1960 онд Оросын мэргэжилтэн анх ирснээс хойш уг байгууллагад ажилласан анхны гадаад иргэн байжээ. Сайн дурын гишүүнийг хүлээн авснаар гарсан технологийн ололт амжилт бол, бохир усыг бактери

³² 2016 оны 10-р сарын 12-ны өдөр авсан ярилцлага

³³ 2016 оны 10-р сарын 10-ны өдөр авсан ярилцлага

ашиглан цэвэршүүлж Хар голд цутгах урьдчилсан туршилтыг амжилттай явуулж, тэрхүү үйл явцаа гарын авлага болгон нэгтгэж ном болгон гаргасан явдал байлаа. Энэхүү ном нь их дээд сургуулиудын хичээлд ч мөн ашиглагдаж байгаа юм. Үүний дараагаар, ЖАЙКА болон Германы тусламжаар Дархан хотын бохир ус цэвэршүүлэх ажилд ахиц гарч 78%-ийг цэвэршүүлж чадаж байна. Монгол хэлээр харилцахад бэрхшээлтэй байсан боловч сайн дурын гишүүн хүлээн авснаар гадаадын иргэдтэй харьцах дадалтай болсон. Тэр байтугай, гэртээ урин хамт хооллосноор, хөвгүүд маань ч гадаад хүмүүсийг сонирхож, хамтдаа тоглосон. Бага хүү маань Монгол Улсын засгийн газрын тэтгэлгээр АНУ-ын Массачусетсийн Технологийн Институтэд суралцаж байгаа нь ч энэ бүхний нөлөө болов уу гэж бодогддог. Гадаадын иргэдийн оролцоо олон хүмүүст сайн нөлөө үзүүлдэг гэж боддог³⁴.

4.3.12 Булганы 2-р цэцэрлэг

2005-2007 оны үед Булганы 2-р цэцэрлэгт томилогдон ажиллаж байсан Фүрүкава Коүжи JOCV-тэй хамтран ажиллаж байсан хамтрагч, өнөөдөр Булганы 4-р цэцэрлэгт ажиллаж буй Ариунаа багшаас тухайн үеийн талаар асуусан юм.

Хүсэлт гаргаж байсан түүхийг сөхвөл, 2002 онд Булган аймгийн 1-р цэцэрлэгт Миүра Эми томилогдон ажиллаж байсан. Миүра нь Монголын социалист нийгмийн үед ажиллаж байсан багш нарын мэдлэгийг тэр чигээр нь уламжлан зааж сургаж байсан, нэг талыг баримталсан сургуулийн өмнөх боловсролыг халж, хүүхэд тоглож наадангаа сурч боловсрох аргыг практикт хэрэглэсэн. Хүүхдүүд хялбар дууг хамтдаа дуулж, бүжиг болон хэмнэлт тоглоомоор тоглож, хязгаарлагдмал материалаар хийж болох зүйлсийн аргачлалыг боловсруулж, хүүхдүүдэд зурагт ном уншиж өгдөг байсан³⁵. Бага насны хүүхдүүдэд хэтэрхий хүнд агуулгатай байгааг ойлгож байсан ч өнөөг хүртэл хүчээр зааж ирсэн Ариунаа багшийн хувьд дээрхи арга барилыг үзээд гайхал төрсөн. Тухайн үед, 2-р цэцэрлэгт ажиллаж байсан тэрээр 1-р цэцэрлэгийн Миүра багшийг хараад өөрийнхөө цэцэрлэгт ч бас япон багш ирүүлэхийг хүссэнээр Фүрүкава JOCV-тэй холбогдсон байна.

Фүрүкава JOCV нь томилогдсон үеэсээ эхлэн, нэг гартаа монгол хэлний толь бичиг барин багш нартай харилцаж богино хугацаанд дотноссон юм. 2-р цэцэрлэгийн бусад багш нар хамгийн ихээр гайхсан зүйл нь Фүрүкава JOCV хүүхэдтэй харьцахдаа хүүхдүүдийн харах ижил түвшинд тонгойж харьцдаг явдал юм. Тухайн үед багш нар өвдгөө нугалж хүүхэдтэй ярих тухай бодож ч байгаагүй бөгөөд Фүрүкава JOCV-г хараад гайхдаг байсан.

Багш нарын биеэ авч явах байдалд өөрчлөлт илрэх болсон нь хүүхдүүдийн зүгээс Фүрүкава JOCV-д хандах хандлагыг харсаны дараа байсан юм. Хүүхдүүд Фүрүкава JOCV-д хурдан дасаж, Фүрүкава JOCV ч хүүхдүүдтэй хөгжилдөн харьцаж байсан. Үүнийг харсан багш нар, өөрсдийнхөө хүүхэдтэй харилцах харьцаагаа өөрчилсөн нь зөв юм байна гэдгийг ойлгосон. Энэ мэтчилэнгээр, Фүрүкава JOCV цэцэрлэгийн багшийн үнэн зөв төрхийг монгол хүнд харуулснаар монгол багш нар цэцэрлэгийн багшийн арга барилд аяндаа сурсан юм.



Фүрүкава JOCV-ийн тухай ярьж буй
Ариунаа багш



Ариунаа багшийн нандигнан хадгалж буй
Фүрүкава JOCV-ийн ажлын фото зургууд

³⁴ 2016 оны 10-р сарын 13-ны өдөр авсан ярилцлага

³⁵ 2007 оны 8-р сарын 17-ны өдөр гаргасан төслийн зохицуулагчийн ажлын эцсийн тайлангаас иш татав

Монгол дуу хүүхдийн хоолойны хөвчөөр дуулахад хэцүү дуу олонтой байна гэж дүгнэснээр Фүрүкава JOCV японы хүүхдийн дууг монгол хэлэнд орчуулсныг бүгдээрээ дуулж, уран гартай хүн байсан учир амьтны зураг зурж тэр дор нь дуу зохион дуулдаг байсан. Цаасан нугалбар (оригами), дуу, бүжиг, хөгжмөөр дамжуулан хүүхдүүдэд хөгжилтэй арга хэлбэрээр боловсрол олгох арга барил нь бусад багш нараас өндрөөр үнэлэгдэж, сүүлээр 2-р цэцэрлэгээр зогсохгүй, аймгийн төвийн бусад таван цэцэрлэг болон 17 сумын цэцэрлэг гээд нийд 23 цэцэрлэгийг тойрч, цэцэрлэгийн багш нарт сургалт хийх болсон.

Фүрүкава JOCV-тэй нэг үед 1-р цэцэрлэгт томилогдсон Фүтагава Сачико JOCV ч түүний нэгэн адил Булган аймгийн цэцэрлэгт хувь нэмрээ оруулсан. Бусад аймгуудад хуваарилагдсан ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд болох цэцэрлэгийн багш нар нэгдэн дууны ном зохиосон. Энэхүү ном нь өнөөдөр ч Булган аймгийн цэцэрлэгт ашиглагдаж байгаа юм.


Ариунаа багшийн ярианаас үзвэл, Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын үндсэн бодлого нь “хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” болж өөрчлөгдсөнөөр дотоодын олон цэцэрлэгийн багш нар юу хийхээ мэдэхгүй гайхширч байсан. Гэтэл аль хэдийнэ JICA-ийн сайн дурынхнаас сурч, энэхүү бодлогоор боловсрол олгож ирсэн Булган аймгийн багш нарт гайхах зүйл огт байгаагүй. Харин ч гишүүдээс сурч хэрэгжүүлж ирсэн арга барил нь зөв байсанд өөртөө итгэх итгэлийг олсон юм.

4.3.13 Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг


Булган аймгийн нэгдсэн эмнэлэгт, 2012-2014 он хүртэл сувилагчаар ажиллаж байсан Хата Мисато JOCV-ийн тухай, ахлах сувилагч Отгончимэгээс ярилцлага авсан.

Түүний хүсэлт гаргах болсон шалтгаан нь ийм байжээ. 2009-2011 оны үед ЖАЙКА-аар Эх хүүхдийн эрүүл мэндийн хөдөлгөөн (Өвсний үндэс, техникийн хамтын ажиллагааны төсөл, Монгол Улсын Булган аймгийн Булган сумын 3-р багдахь Эх нялхсын төлөө-Иргэдийн оролцоотой эрүүл хот бүтээх төслийг хэлж байгаа болов уу) явагдаж Булган аймагт япон хүн томилолтоор ирсэн байсан. 2011 онд 1 долоо хоногийн хугацаатайгаар Токиод сургалтад хамрагдаж, японы сувилахуйг мэдэжавснаар Япон Улсаас заавар зааварчилгаа авах зорилгоор Эрүүл мэндийн яамтай зөвлөлдсөн юм. Эрүүл мэндийн яамны дэмжлэг хүсэх хурлаар дамжуулан, Орхон аймгийн Эрдэнэт хотын сувилагчаас хамтын ажиллагааны сайн дурын гишүүд эмнэлэгт ирж ажиллавал сайн нөлөө үзүүлдэг тухай энд сонсжээ.

ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдээр заалгаж авах хүсэлтэй байсан зүйл маань ялангуяа яаралтай өвчтөнд үзүүлэх сувилгаа ба тоног төхөөрөмжийг хэрхэн зохистой ашиглах тухай байсан юм. Ахлах сувилагч Отгончимэг Хата JOCV-г эргэн тойронд нь зөвхөн монголчууд байгаа нөхцөлд ганц хүн гэлтгүй их сайн хичээж ажилласан гэж боддог хэмээн магтан хэлээд, тэмдэглүүштэй зүйл гэх юм бол: монгол хэл нь маш хурдан сайжирч, монгол сувилагч нарын ажиллаж байгаа байдлыг сайтар ажиглан ямар хэлбэрээр зааварчилгаа өгвөл зүгээр вэ гэдэг талаар байнга бодож явдаг байсан. Сүүлд, монгол сувилагч нарын засаж сайжруулах шаардлагатай талууд хэмээн 1. Хүнд гэмтэлтэй өвчтөний сувилгаа, 2. Яаралтай сувилгаа, 3. Өвчтөний хэвтрийг засаж, солих арга барил, 4. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ (ялангуяа цэвэрлэх арга), 5. Мэс заслын дараах боолт хийх аргачлал зэргийг онцлон тэмдэглэж сургалт зохион байгуулж зааварчилгаа өгсөн. Эмнэлгийн мэргэжилтний эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх ойлголттой болж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх шаардлагатайг ухамсарласан явдлуудыг ахлах сувилагч онцлон дурдаж байсан юм. Халдвараас урьдчилан



Ахлах сувилагч Отгончимэг



Өнөөдрийг хүртэл хэрэглэгдэж буй JOCV-ийн хийсэн гарын авлага

сэргийлэхтэй холбогдуулан нэг жишээ өгүүлсэн нь, Хата JOCV-г ирэхээс өмнө хүчилтөрөгчийн генераторыг ашиглах үедээ өвчтөн тус бүрт цэвэрлэгээ хийх шаардлагатай гэдгийг мэддэггүй байснаа хүчилтөрөгчийн генератор болон хүчилтөрөгчийн маскны шүүлтүүрийн хэсгийг цэвэрлэх аргыг заалгаж авснаар халдвараас урьдчилан сэргийлэх мэдлэг нэмэгдсэн. Мөн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбогдуулан зүрх судасны сэхээн амьдруулах машиныг хэрхэн зөв ашиглахыг заалгасан хэмээн жишээ татаж ярьсан. Монгол Улсад тоног төхөөрөмж нь байсан ч зөв аргаар ашиглаж чаддаггүй байснаас богино хугацаанд эвдэх явдал урьд өмнө ихээр гардаг байсан. Хата JOCV-ийн удирдлаган дор, тоног төхөөрөмж хэрэглэх сургалтыг зохион байгуулсан. Тэр ч байтугай нутаг буцахынхаа өмнө өөрийн зааж сургасан ажлын горимын арга барилын дэс дарааллыг зургаар авч, тайлбарыг бичсэн монгол сувилагч нарт зориулсан заавар болох гарын авлага хийсэн. Уг зааварчилгаанд бүхий л ажлын горимыг шалгах ёстой жагсаалт хавсаргагдсан нь өнөөдөр ч гэсэн ашиглагдаж байгаа билээ.

5-Р БҮЛЭГ. ЯПОН-МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН ТҮВШИН ДЭХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХАРИЛЦАА

5.1 Япон-Монголын орон нутгийн түвшин дэх хүүхэд залуучуудын харилцаа

1974 онд Монгол, Япон хоёр улс Засгийн газар хоорондын түвшинд Соёлын харилцаа тогтоох тухай Тохиролцоо байгуулж, 1976 онд засгийн газрын тэтгэлгийн анхны оюутан Япон Улсад ирсэн байна. Нөгөөтэйгүүр, 1950 оноос Монгол Улстай харилцах Япон Улсын байгууллагууд үүсэн байгуулагдаж, соёл урлаг, ард иргэдийн харилцааг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсээр ирсэн байна. 1964 онд “Япон Монголын нийгэмлэг”, 1968 онд “Япон Монголын найрамдлын нийгэмлэг” байгуулагдсан. Монгол Улстай найрамдлын хөдөлгөөнийг эхлүүлэгсэд нь Монгол Улсад хоригдож байсан Японы иргэн байсныг онцгойлон дурдах хэрэгтэй юм. Монгол Улсад, Япон Улстай найрамдал нөхөрлөл, соёлын солилцооны 30 гаруй байгууллага байдаг бол Япон Улсад 70 гаруй ийм байгууллага үйл ажиллагаа явуулж, иргэд хооронд болон төрийн бус байгууллага, орон нутгийн захиргааны хоорондын шууд харилцаа идэвхтэй хөгжиж байна³⁶.

5.1.1 Япон Монгол хоёр орны хооронд ах дүүгийн харилцаатай болоод найрамдалт харилцаатай орон нутгийн үйл ажиллагаа

2016 оны 10-р сарын байдлаар Япон Монгол хоёр орны дараах 7 орон нутгийн захиргааны хооронд (3 аймаг муж, 4 хот) ах дүүгийн найрамдалт харилцааны гэрээ байгуулагдсан байна.

Хүснэгт 5-1 Япон Монгол хоёр орны орон нутгийн захиргааны хоорондын ах дүүгийн харилцаа ба найрамдалт харилцаа

Орон нутгийн захиргааны нэр	Орон нутгийн захиргааны нэр	Гэрээ байгуулсан он тоолол	Найрамдалт харилцаанд хүргэсэн хүчин зүйл, процесс
Нагасаки мужийн Мацү-Үра хот	Өвөрхангай аймгийн Хужирт сум	1991/7/27	Нагасаки мужийн Мацү-Үра хотын Такашима тосгон нь Монголчуудын довтолгоо буюу “Гэнкооноэки”-нд өртсөн арал гэдгээрээ олонд танигдсан байдаг боловч, цаашид 2 орны найрамдалт харилцааг үүсгэж, энх тайван, найрамдлыг тогтворжуулан хөгжүүлэхийн төлөө ах дүүгийн харилцааны гэрээнд гарын зурсан. 1993 онд монгол гэрийг буудал болгон барьж “Такашимагийн Монгол тосгон”-ыг нээсэн ³⁷ . (2016 оны 11-р сард түр хаасан)
Хёго мужийн Тоёо-Ока хот	Баянхонгор аймгийн Богд сум	1994/10/9	Оосакагийн Гадаад хэлний дээд сургууль холбон танилцуулж өгснөөр эхэлжээ. 1994 оны 10-р сард Танто тосгонд зохион байгуулагдсан Олон Улсын симпозиум, хөгжмийн наадамд оролцсон сумын засаг дарга, тосгоны дарга хоёр найрамдалт харилцааны гэрээнд гарын үсэг зурсан. Танто тосгон ба Монгол Улс нь Япон Монголын хамтарсан "Говь" төслийг 1985 оноос эхлэн хэрэгжүүлж хамтын харилцааны үйл ажиллагаагаа өрнүүлсээр байна. 1996 онд Япон Монгол үндэстний музей байгуулсан байна.
Тоттори муж	Төв аймаг	1997/7/25	1997 оны 7-р сард Тоттори мужийн Сакаи-Минато хотод гарсан “Сан-ин Юмэ Минато Үзэсгэлэн”-д төв аймгийн засаг дарга бүхий баг оролцож, хөдөө аж ахуйн технологийн

³⁶ Ишлэл: Япон улсад суугаа Монгол улсын ЭСЯ цахим хуудас, <http://www.tokyo.embassy.mn/jpn/index.php?moduls=17> (хандалт 2016/11/29)

³⁷ 2016 оны 11-р сарын 1-ний өдрөөс түр хаасан. Ишлэл:<http://www.mongol-mura.com/> (хандалт 2016/11/29)

			солилцоо, соёлын харилцаа замаар 2 талын харилцан ойлголцол ба найрсаг харилцааг бий болгох зорилгоор найрамдалт харилцааны санамж бичигт гарын үсэг зурав. Ингэснээр, Төв аймаг нь БНХАУ-ын Жилинь муж, БНСУ-ын Канвон муж, ОХУ-ын Приморын хязгаар болон Япон тэнгисийн бүс нутагт болох төрөл бүрийн арга хэмжээнд оролцдог болсон.
Миязаки мужийн Мияако-но-жёо хот	Улаанбаатар хот	1999/11/22	1993 онд Монгол Улсын малчин ардад салхин цахилгаан үүсгүүр бэлэглэх хувийн хэвшлийнхний үйл ажиллагаагаар эхэлж, түүнээс хойш олон төрлийн харилцаа болон өргөжсөн. 1998 онд Мияако-но-жёо хотын дарга, ИТХ-ын дарга нар Улаанбаатар хотод айлчлах үеэр, тус хот болон хотын ИТХ-аас найрамдалт харилцаатай хотын гэрээг санал болгожээ. Тэр жилдээ, Мияако-но-жёо хотод олон нийтийн ба хувийн хэвшлийнхэн Мияако-но-жёо хот болон Улаанбаатар хотын найрамдлын холбоог байгуулж, төрөл бүрийн харилцаа, хамтын ажиллагааг өрнүүлж ирсэн байна. 1999 онд Мияако-но-жёо хотын ИТХ-ын шийдвэрээр албан ёсоор найрамдалт харилцаатай хотууд болсон байна.
Нагано мужийн Саку хот	Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг	2008/08/04	2006 онд “Их Монгол Улс үүсгэн байгуулагдсаны 800 жилийн ой”-г тохиолдуулан Саку хотын агаарын бөмбөлгийг нисгэгчийн хамтаар Монголд илгээсэн нь энэ хамтын ажиллагааны эхлэл болж, Япон Улсад суугаа Монгол Улсын элчин сайдтай хүндэтгэлийн уулзалт хийж, Саку хотоос зохион байгуулдаг арга хэмжээнд урих зэргээр харилцаагаа гүнзгийрүүлж иржээ. 2008 онд тус дүүргийн засаг даргаас нарамдалт харилцаатай хотын гэрээг хүлээн зөвшөөрч буй захидлыг хүлээн авч, тухайн оны хотын ээлжит хуралдаанаар батлан, гэрээнд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг зохион байгуулжээ.
Шизуока муж	Дорноговь аймаг	2011/7/29	2010 онд Элчин сайд байсан Кидокоро гуай Шизуока мужийн засаг дарга Х.Кавакацу, Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг хоёрыг танилцуулснаар 2 талын засаг дарга нар ах дүү мужийн харилцаа тогтоохоор тохиролцож, 4 сарын дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Япон Улсад хийсэн айлчлалын үеэр Төрийн ордонд урьдчилсан байдлаар гарын үсэг зурж, дараа нь 2011 оны 7-р сард албан ёсоор үзэглэсэн байна.
Оосака мужийн Изүмисано хот	Төв аймаг	2013/7/27	Оосакагийн нисэх онгоцны буудал байдаг хотын хувьд хөрш Улс орнуудын орон нутгийн захиргаагаар харилцаа холбоо тогтоохоор эрэлхийлж байх үед Монгол Японы харилцааг дэмжих холбооноос Монгол Улсын Төв аймгийг танилцуулж, 2013 онд хотын дарга тус аймагт айлчилсан байна. 2013 онд Изүмисано хотын хувьд үүсгэн байгуулагдсаны 65 жилийн ой, Төв аймгийн хувьд 90 жилийн ойгоо угтаж, тухайн оны 7-р сард аймгийн 90 жилийн ойн баяртай давхцуулан төв аймагт найрамдалт харилцааны санамж бичигт гарын үсэг зурж, хамтын харилцаагаа эхлүүлжээ.

Эх сурвалж: Орон нутгийн захиргааны олон улсын холбоо, <http://www.clair.or.jp/cgi-bin/simai/j/05.cgi> (хандалт 2016/11/29), Шизуока муж, Элчин сайд асан Такүо Кидокоротой хийсэн ярилцлагаас (2017/1/15)

Доор Тоттори муж ба Шизуока муж, Миязаки мужийн Мияако-но-жёо хот ба Нагано мужийн Саку хотуудын үйл ажиллагааны тухай мэдээлэл цуглуулж ярилцлага авсан судалгааныхаа дүнг тэмдэглэв.

(1) Тоттори муж ба Төв аймаг

1997 оноос найрамдалт харилцаа эхлүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн. ХАА-н салбарт дадлагажигч болон их дээд сургуулиудад оюутан хүлээх авах зэрэг үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ сүүлийн жилүүдэд ЖАЙКА Өвсний Үндэс техникийн хамтын ажиллагаагаар эрүүл мэндийн салбарт мэргэжилтэн илгээх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

Төв аймаг нь 11 улс оронтой ах дүүгийн болоод нөхөрсөг харилцаа байгуулан ажилладаг бөгөөд дээр дурдсан Япон Улсын Тоттори муж ба Осака мужийн Изүмисано хотоос гадна, БНСУ, БНХАУ, ОХУ (Владивосток), Индонези (Жогжакарта), Филиппин (Сэбү), Тайланд (Чэнмай), Вьетнам, Лаос (Луанг Прабанг), Камбож, Малайз байна. Япон Улс, БНСУ, БНХАУ-ын 3 хоттой аймгийн засаг даргын түвшинд хурал зохион байгуулж, ах дүүгийн харилцаатай хот, найрамдалт харилцаатай бүх хотууд жилд нэг удаа хуралдаж, харилцаа холбооны төлөвлөгөө, үнэлэлтээ хийдэг байна.

(2) Миязаки мужийн Мияако-но-жёо хот ба Улаанбаатар хот

“Монгол Улсад салхин цахилгаан үүсгүүр бэлэглэх” төсөл Монгол Улстай хамтын харилцааны эхлэл байсан бөгөөд Монгол Улсын ШУТИС ба Мияако-но-жёо хотын техникийн коллежийн хооронд техникийн харилцаа хөгжиж, эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Мияако-но-жёо хотод өнөөдөр олон төрлийн үйл ажиллагаа төрөл бүрийн хэлбэрээр хэрэгжиж байна. 2016 онд Улаанбаатар хотын залуучуудын харилцаа (13-16 насны 10 хүн, 7 шөнө 8 өдрийн хугацаатай) болон, Монгол Улсад Мияако-но-жёо хотын брэнд Миязаки үхрийн махны амталгаа болон танилцуулах сурталчилгааны ажил, Токиогийн Олимпийг зохион байгуулагчийн санаачлагаар Монгол Улсын чөлөөт бөхийн багийг урих зэрэг ажлууд хийгдсэн. Мияако-но-жёо хотын Иргэдийн ахуй амьдралын газрын Иргэдийн ахуй амьдрал, соёлын хэлтсийн даргын хэлснээр, олон улсын харилцааны үйл ажиллагааны болон тээврийн зардал, тусламжийн эд зүйлс илгээх тээврийн зардал зэрэг төсвийн асуудал хүндрэлтэй байгаа хэдий ч, хоёр орны цаашдын боловсон хүчин бэлтгэх, олон улсын харилцааны үйл ажиллагаанд ялангуяа залуучуудын харилцаа маш чухал үүрэг гүйцэтгэдэг ба нутгийн уугуул иргэдтэй тогтоох харилцааны чухлыг онцлон тэмдэглэх шаардлагатай ажээ³⁸.



Олон улсын харилцааны мэргэжилтэн

Соёлмаа

Соёлмаа нь Монгол Улсын ТИС-ийн гадаад хэлний факультетын япон хэлний тэнхимийн 1-р курсийн оюутан байх үедээ ЖАЙКА-ийн сайн дурын гишүүнээр япон хэл заалгуулж байжээ. Тэрээр хэлэхдээ, тухайн үеийн япон хэлний тэнхимийн оюутнууд япон хэл ойлгодог байсан учир ТИС-д томилогдон ирсэн бусад мэргэжлийн сайн дурынхны үйл ажиллагаанд тусалдаг байсан ажээ.

Мөн тус хэлтсийн олон улсын хэлтсийн мэргэжилтэн, Олон улсын харилцааны мэргэжилтэн солилцооны 5 дахь үе болох Соёлмаа нь Монгол Улсын ТИС-ийн гадаад хэлний факультетын япон хэлний тэнхимийн 1-р курсийн оюутан байх үедээ ЖАЙКА-ийн сайн дурын гишүүнээр япон хэл заалгуулж байжээ. Тэрээр хэлэхдээ, тухайн үеийн япон хэлний тэнхимийн оюутнууд япон хэл ойлгодог байсан учир ТИС-д томилогдон ирсэн бусад мэргэжлийн сайн дурынхны үйл ажиллагаанд тусалдаг байсан ажээ.

Улаанбаатар хотын захиргааны гадаад харилцааны хэлтсийн дарга Наранцэцэг хэлэхдээ³⁹, 2016 оны 10-р сарын байдлаар Токиогийн олимпод бэлтгэн Монгол Улсаас жүдо, чөлөөт бөхийн тамирчдыг Мияако-но-жёо хот руу илгээхээр төлөвлөж байна.

³⁸ Мияконожё хотын иргэдийн амьдрал ахуйн хэсгийн иргэдийн амьдрал ахуй, соёлын хэлтсийн дарга: Инаёши Минору, дэд дарга: Самешима Такаши, олон улсын харилцааны мэргэжилтэн: хатагтай Соёлмаа, Мияконожёогийн олон улсын харилцааны холбооны ерөнхий нарийн бичгийн дарга: Фүжимото Коүчиро, 2016 оны 11-р сарын 4-ний өдөр авсан ярилцлага

³⁹ 2016 оны 10-р сарын 20-ны өдөр авсан ярилцлага

(3) Нагано мужийн Саку хот ба Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг

Энэхүү хоёр орон нутгийн харилцааны гол агуулгыг дурдвал: хоёр орны соёл, урлагийг сурталчилж, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхийн тулд, жил бүр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 5-6 хүүхдийг Япон Улсад хоумстэй хийлгэдэг явдал юм. Гэхдээ, 2016 онд Монгол Улсын Засгийн газраас олон улсын харилцааны хөрөнгө мөнгийг шийдэж өгч чадаагүй учир хэрэгжээгүй байна. Мөн, шаардлагатай үед тамгын газрын мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулдаг байна.

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргээс Саку хоттой холбоо барихад их бэрхшээлтэй байна гэж ярьж байлаа. Холбоо барихын тулд: “Сүхбаатар дүүргийн тамгын газар” ⇔ “Саку хот, Монгол найрамдлын холбоо” ⇔ “Саку хамтын харилцааны холбоо” ⇔ “Саку хотын захиргаа” гэсэн дэс дарааллаар холбогддог учир Саку хотын захиргаатай шууд холбоо тогтоож болохгүй байгаа нь хүндрэлтэй байгаа байдалтай байсан⁴⁰.

Саку хот, Фүрусато (төрсөн нутгаа) барих төслийн төсөв болох 100 сая иенийг ашиглан Саку хотын дунд сургуулийн сурагчдыг жил бүр зуны амралтын хугацаанд 1 долоо хоногоор Монгол Улс, АНУ-д илгээдэг байна. 2010 оноос эхлэн 2016 онд ч мөн илгээсэн. Сургалтын агуулга нь 1. Монгол айлынд болон малчин айлын уламжлалт гэрт Homestay (айлынд байрлаж) хийж аж ахуй, амьдралыг өөрсдийн биеэр мэдрэх, 2. Сэтгэлгээ, уламжлалт заншлыг сурснаар харилцан ойлголцох, 3. Монгол Улсын соёл, түүхийг сурах зэрэг юм.

(4) Шизүока муж ба Дорноговь аймаг

Хоёр аймгийн харилцааны голлох үйл ажиллагаа нь ахлах сургуулийн сурагчдын солилцоо, мал аж ахуйн салбарын дадлагажигч хүлээн авах, эмч зэрэг эмнэлгийн байгууллагын мэргэжилтнийг сургалтад хамруулах, дулааны цахилгаан станцын мэргэжилтэн сургах, Монгол Улсын филармонийг урих зэрэг өргөн цар хүрээтэйгээр явагддаг. Мөн найрамдалт харилцааны баталгаа болгон Шизүока мужийн хот тосгон болоод эмнэлгийн хамтын ажиллагаагаар Дорноговь аймагт гал унтраах машин, түргэн тусламжийн машин, эмнэлгийн тоног төхөөрөмж зэргийг буцалтгүй тусламжаар нийлүүлж байсан. 2014 онд Дорноговь аймгийн ахлах сургуулийн 50 сурагч 1 долоо хоногийн хугацаатайгаар Шизүока мужид айлчилсан. 2013 онд цэвэр бохир усны системийн технологийн солилцоо CLAIR-ээс⁴¹ хүлээн зөвшөөрөгдөж, 2016 онд ЖАЙКА-ийн Өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны тусламжийн хүрээнд багтсан.

“Шизүока Монголын найрамдлын нийгэмлэг” нь хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан 2012 онд төрийн бус /сайн дурын/ байгууллагаар бүртгэгдсэн байна. Голлох үйл ажиллагаа нь: Сайншанд хотын 5-р сургуульд МУБИС-ийн 2 төгсөгчийг ажилд авч, япон хэлний курс байгуулсан. 2016 оны байдлаар япон хэлний боловсрол Монгол Улсын албан ёсны сургалтын хөтөлбөрт багтаагүй тул эдгээр багш нарт найрамдлын нийгэмлэгээс ажлын байр гаргаж, 100% цалинжуулж байгаа юм. Харин ирээдүйд цалингийн хагасыг нь ч болов Дорноговь аймгаас гаргаж өгөх тухай хүсэлт гаргаад байгаа ажээ. МУИС-ийн захиралтай хэлэлцэж, 5-р сургуулийг МУБИС-ын дэргэдэх бага сургууль болгохоор төлөвлөж байгаа. Үүнээс гадна, Япон Улсад суралцахад дэмжлэг үзүүлэх болон, барилга инженерийн сургуулийн барилга байгуулалт, МУИС-тай санамж бичиг (Memorandum of Understanding) үзэглэх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан монгол мэргэжилтнүүдийн боловсролд хувь нэмрээ оруулж байгаа. Төрийн болон хувийн хэвшлийн



Шизүока мужийн засаг дарга, Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг нар ах дүүгийн харилцаа тогтоох гэрээнд урьдчилсан байдлаар гарын үсэг зурах ёслолын үеэр (Токио, Торийн ордон) 2010 оны 11-р сар

⁴⁰ Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Баасанбат, 2016 оны 10-р сарын 20-ны өдөр авсан ярилцлага

⁴¹ Олон улсын харилцааны нутгийн удирдлагын зөвлөл (CLAIR : Council of Local Authorities for International Relations) -ийн Орон нутгийн олон улсын хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа (загвар үйл ажиллагаа). Эх сурвалж: <http://www.clair.or.jp/index.html> (хандалт 2016/11/30)

байгууллагууд ажил үүргээ зөв хуваан үйл ажиллагаа явуулах болно⁴².

5.1.2 Япон Монгол Улсын төрийн бус байгууллагын бусад үйл ажиллагаа

Төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд сурагч хүүхдүүдийг Япон Улсад урих хөтөлбөр их байдаг ба Коочи-Монголын найрамдлын нийгэмлэг нь 1994 оноос эхлэн өнөөдрийг хүртэл бага, дунд сургуулийн нийт 200 сурагчийг Япон Улсад богино хугацааны сургалтанд хамруулсан байдаг. Үүнээс 2 хүн нь Монгол Улсад суугаа Японы ЭСЯ-нд ажиллан хоёр орны харилцаанд өөрсдийн хувь нэмрээ оруулан дипломат салбарт хүчин зүтгэж байна⁴³. Мөн Мичигами Ёосүкэ (16-1), нутаг буцсаныхаа дараагаар Ишикава-Монголын найрамдлын нийгэмлэгт гишүүнээр элсэж, Каназавад төвлөрөн Ишикава мужид амьдарч байгаа Монголчуудад япон хоол зааж, Япон дахь амьдралд нь дэмжлэг үзүүлэх зэргээр олон улсын харилцааг дэмжсээр байна. (2014 онд томилогдон) Өнөөдөр ажиллаж буй Шинохара Гакүжигийн тайланд үндэслэвэл, 2007 оноос эхлэн Монгол Улсад зурагт ном болон хүүхдийн ном хандивлах үйл ажиллагаа явуулдаг “Фүкүи Монголын найрамдлын нийгэмлэг” нь бусад төсөлтэй хамтран ажилладаг хэмээн тэмдэглэжээ. Тус JOCV нь ЖАЙКА-ийн “Дэлхийн инээмсэглэлийн төлөө” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг энэхүү нийгэмлэгийг тусламж хүлээн авагч дээд сургуулийн багштай холбон зуучилсан өмнөх сайн дурын ажилтаны үйл хэргийг үргэлжлүүлж, 2015 оны намрын сонгон шалгаруулалтад бичиг материал бүрдүүлж өгөхөд нь тусалсан байна.

Ийнхүү энд дурдсанчлан Япон, Монгол Улсын хооронд төрөл бүрийн хамтын ажиллагаа хэрэгжиж байгаа бөгөөд, Япон Улстай дотно харилцаа хөгжүүлснээр ЖАЙКА-ийн сайн дурынхан тухайн орон нутагт ажиллах үед тэднийг найрсгаар хүлээн авахад сайнаар нөлөөлдөг гэж үзэж болно.

⁴² Шизүока Монголын найрамдлын нийгэмлэгийн дарга: Китагава Масахиро, 2016 оны 11-р сарын 1-ний өдөр авсан ярилцлага

⁴³ Ишлэл: Олон улсын харилцааны сан-япон хэлний боловсролын далайн чанад дахь харилцаа япон хэлний боловсролын 10-р илтгэл, Олон улсын харилцааны сангийн томилолтын мэргэжилтэн Мүраками Ёшифүми <https://www.jpff.go.jp/j/project/japanese/teach/tsushin/report/010.html> (хандалт 2016/12/1)

6-Р БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦААШДЫН ТӨЛӨВ БА ЗӨВЛӨМЖ

6.1 ЖАЙКА-ийн 25 жилийн сайн дурын үйл ажиллагааны үр дүнгийн тойм

6.1.1 Үр дүнгийн тойм

Монгол Улс руу хандсан Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхны үйл ажиллагаа (JOCV) нь, 1992 оны 4-р сард 2 гишүүн томилсноор үйл ажиллагаагаа эхлүүлж, 2016 оны 10-р сарын байдлаар нийт 505 JOCV томилж, үйл ажиллагаа явуулсан хэмжээнд хүртлээ өсчээ. Энэхүү 25 жилийн хугацаанд Монгол Улсын хүн ам 2,100,000 хүнээс 3,060,000 хүн болон өсч, нэг хүнд ногдох жилийн ДНБ 680 ам.доллараас 3,900 ам.доллар болж эдийн засаг нь огцом өсчээ. 1990 оноос эхэлсэн ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц нь JOCV-ийн түүхтэй давхцдаг ба JOCV нь Монгол Улсын хөгжлийн төлөө үйл ажиллагаагаа явуулж, боловсон хүчин бэлтгэхэд нь ихээхэн хувь нэмэр оруулж ирсэн байна.

Өнөөг хүртэл мэргэжилтэн илгээж ирсэн тэргүүлэх салбар, гол мэргэжил гэвэл анхан шатны япон хэлний боловсрол, СӨБ, бага, дунд, бүрэн дунд боловсрол гээд өргөн хүрээтэй боловсролын салбар, спорт, эх хүүхдийн эрүүл мэнд болон хөдөлгөөн засалч гэх мэт эрүүл мэндийн салбар байгаа бөгөөд одоо ч сайн дурын гишүүдийг тогтмол илгээсээр байгаа юм.

Далайн чанад дахь ахмад сайн дурынхан (SV) нь 2000 оны 11-р сард 3 гишүүн томилогдож, 2016 оны 6-р сар хүртэлх хугацаанд нийт 135 гишүүн томилогдсон байна. SV нар аж үйлдвэрийн хөгжилд шаардлагатай чанарын менежмент, удирдлагын менежментийг сайжруулах салбар, түүнчлэн Япон Улсын ODA-ийн санхүүгийн тусламж үзүүлэх хамтын ажиллагаагаар баригдсан дулааны цахилгаан станц болон дэд бүтцийн менежментийг сайжруулах салбарт томилогдон ажиллаж, Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэж байна.

6.1.2 Монгол Улсын хөгжлийн хэрэгцээг харгалзан үзэх

ЖАЙКА-ийн сайн дурынхан нь Монгол Улсын хувьсан өөрчлөгдөх хөгжлийн хэрэгцээнд тохируулан үйл ажиллагаагаа явуулснаар үр дүнд хүрч, өндрөөр үнэлэгдэж ирсэн гэж хэлж болно. Тухайн жилийн хөгжлийн хэрэгцээний өөрчлөлт ба түүнийг харгалзсан үйл ажиллагааг доор дурдав.

(1) Монгол Улсын ардчилал

ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагаа нь 1990-ээд оны Монгол Улсын ардчилалд шилжих үетэй давхцан эхэлсэн. Гадаад хэлний боловсролын нэгэн хэсэг болгон Япон хэлийг оруулж, япон хэлний багшийн хэрэгцээ нэмэгдэн эхний шатанд япон хэлний багш JOCV олноор томилогдож байсан. 2015 оны 5-р сард Монгол Улсад Япон хэлний боловсрол олгож эхэлсний 40 жилийн ойн симпозиум зохион байгуулагдаж, Улаанбаатар хотод бага дунд боловсролын 20 гаруй сургуульд япон хэлний тэнхим нээгдсэн байсан бөгөөд цаашид ч нийслэл дэх япон хэлний боловсрол, орон нутаг дахь япон хэл сонирхогчдын тоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг үндсэн суурь 2 багана болгон гишүүдийг томилох төлөвлөгөөтэй байгааг зарлажээ. Мөн түүнчлэн, 1995 оны үед орон нутагт спортын JOCV-ийн хэрэгцээг гарсныг хангах үүднээс орон нутагт үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

(2) Шинэ заах аргачлалын тойм

Боловсролын салбарт 1996 оноос СӨБ, 2001 оноос бага дунд боловсролын байгууллагуудад гишүүдийг томилж эхэлсэн. 2005 оны 9-р сард хүүхдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх хүүхэд төвтэй хичээлийг заах шинэ арга барилыг боловсруулжээ. Түүний дагуу боловсрол олгох аргачлалын жишиг болгон ЖАЙКА-ийн сайн дурынхны томилгооны хэрэгцээ нэмэгдэн, бага дунд сургуульд гишүүдийг томилох явдал 2009 оноос огцом өсч, байгалийн шинжлэх ухааны боловсрол (2007 оноос), дуу хөгжмийн боловсрол (2010 оноос)-ын салбаруудад голлон JOCV-г томилж, холбогдох байгууллагуудаас авсан сурвалжлага судалгаанаас үзэхэд JOCV-ийн үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд төвтэй сургалтын аргачлалын тухай ойлголттой болсон гэж өндрөөр үнэлж байсан.

(3) Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030

2016 оны 4-р сард НҮБ-ын баталсан SDGs-д үндэслэн боловсруулсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030" нь УИХ-аар батлагдаж, Монгол Улсын хөгжлийн бодлогод шинэ чиг хандлага гарсан юм. Энэхүү "тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-д тулгуурлан Япон улсаас Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байдаг ба Монгол Улсад тулгарах шинэ асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн дэмжлэг шаардлагатай байна.

6.1.3 Монгол Улсын холбогдох байгууллагуудын үнэлгээ

Энэ удаагийн судалгаагаар Монгол Улсын төрийн байгууллага болон хүлээн авагч байгууллагуудаас сайн дурын үйл ажиллагааг хэрхэн үнэлж байгаа талаар санал асуулга явуулсан. Энэ тухай 4-р бүлэгт өгүүлсэн байгаа ба ижил төстэй тал болон тусгайлан дурдах шаардлагатай зүйлийн талаар доор нэгтгэв.

(1) Ижил төстэй тал

ODA-ийн харилцагч цонх болж буй Сангийн Яаманд залуу JOCV нарын эерэг хандлага маш том нөлөө үзүүлсэн. Мөн, ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд шиг хүмүүсийн хоорондын харилцаа холбоог илүү чухалчилж үзмээр байна гэсэн сэтгэгдэл ч гарсан. Сангийн Яам, Эрүүл Мэндийн Яам, Аймгийн биеийн тамир спортын газраас ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийг өмнө дэмжлэг авч байсан байгууллагуудад үргэлжлүүлэн томилох, орон нутгийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулна гэдэгт итгэж байна гэх дуу хоолой их байсан. Түүнчлэн, Монгол Улсын хэмжээнд туршлага хуримлагдаагүй тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны тусламж нэн шаардлагатай байна. Тухайлбал, 18-р сургуулийн дүрслэх урлагийн хичээлийг заах арга, 2-р цэцэрлэгийн хүүхэд төвтэй заах аргын удирдамж, Нэгдсэн эмнэлэг дэх яаралтай тусламж шаардлагатай өвчтөнд хэрхэн арга хэмжээ авах, БСШУЯ-ны тусгай хэрэгцээт боловсрол зэргийг жишээ болгон татсан билээ.

(2) Тусгайлан дурдах шаардлагатай зүйл

Дүрслэх урлаг, дизайн технологийн дээд сургуулийн өмнөх захирлаас “Монгол Улсын хүлээн авагч байгууллага дотор сайн дурын гишүүдийн үйл ажиллагааг бүрэн ойлгоогүй байгууллага ч байдаг бөгөөд, хүлээн авагч байгууллагуудыг дүгнэн үнэлэх шаардлагатай” гэсэн саналыг тавьсан. Мөн, ЭМЯ-аас томилгооны хугацаа 2 жил байх нь богино байгаа тул урт хугацаагаар томилохыг хүссэн. SV-ийн зааварчилгаан дор ажиллаж байсан СР засвар үйлчилгээг явуулж байгаа хэдий ч, СР нь монгол инженерүүдэд ганцаараа сургалт явуулах нь хүндрэлтэй байгаа тул хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийг IV ДЦС-аас хүссэн байна.

6.2 Монгол Улсын хөгжлийн бодлого ба цаашдын чиг хандлага

6.2.1 Монгол Улсын эдийн засгийн хөгжил

JOCV нарыг томилж эхэлсэн 1990-ээд он хүртэл Монгол Улсыг малчин нүүдэлчдийн орон гэсэн ойлголт зонхилж байсан. 2010 оноос хойш хөрш орон болох БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн нөөцлөл дор уул уурхайн салбарын хөгжил, ялангуяа Оюу толгой, Таван толгойн хоёр томоохон уурхай хөгжсөнтэй холбогдон ашигт малтмалын экспорт огцом нэмэгдэж, нийт экспортын 90%-ийг эзлэх болсон. Үүнтэй уялдан, гадаадын хөрөнгө оруулалтын урсгал, дэд бүтцийн хөгжилд ахиц гарч Монголын эдийн засагт өргөн хэрэглээний бараа, барилга, тээвэр, үйлчилгээний салбарт эрэлт огцом өсч, эерэг өөрчлөлтүүд гарсан нь 2011 онд эдийн засгийн өсөлтийг 17%-д хүргэж эрчимтэй хөгжсөн байна.

Гэвч, сүүлийн жилүүдэд, байгалийн нөөцийн үнэ буурч, хөрш улс орнуудын эдийн засгийн хөгжил саарч, төсвийн алдагдал ихэссэнээс эдийн засгийн зогсонги байдал сүүлийн жилүүдэд ажиглагдав. Дээр нь эдийн засгийн огцом өсөлтийн үр ашиг нийгмийн эмзэг давхаргыг сайн хамарч чадаагүйн улмаас, ажилгүйдэл, ядуурлын түвшин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Ялангуяа, нийслэл

Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл нэмэгдэж, 1992 онд 800,000 хүрэхгүй хүн амтай байсан нь өнөөдөр 1,400,000 хүн болж нэмэгдэснээр дэд бүтцийн шийдэгдээгүй асуудал олширч, агаарын бохирдлоос үүдсэн байгаль орчны асуудал зэрэг хот суурин газрын тулгамдсан асуудал нэмэгдэж, хот болон орон нутгийн орлого, дэд бүтэц, боловсрол зэрэгт тэгш бус байдал үүсч, ардчилалд шилжин орох үетэй харьцуулахад хэлбэр агуулга нь өөр болж ирсэн байна.

6.2.2 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030

Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д, “Тогтвортой өсөлтийн салбаруудад тулгуурлан өндөр орлоготой орнуудын тэргүүлэгч эгнээнд хүрч, тогтвортой орчинд, тогтвортой ардчилсан засаглалыг хэрэгжүүлнэ” гээд, 1 хүнд ногдох ДНБ-ийг 17,500 ам.долларт хүргэх зорилт тавин, Монгол Улсын эдийн засгийн цаашдын өсөлтдөө томоохон итгэл найдвар тавьж байна. Үүн дээр тулгуурлан, тогтвортой нийгмийн хөгжлийг үргэлжлүүлэхийн тулд 1) Ерөнхий өсөлттэй холбогдуулан нийгмийн эрх тэгш байдлын баталгаа (нийгмийн аюулгүй байдал), 2) Үр дүнтэй, өндөр чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээ (эрүүл мэнд), 3) Өндөр мэдлэгтэй нийгэм ба өндөр ур чадвартай улс (боловсрол) гэсэн 3 асуудлыг тавин, тухайн асуудал тус бүрт, нийгмийн эмзэг давхаргынханд тусламж үзүүлснээр ядуурлыг бууруулах, нийгмийн аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эх хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчин, амьдралын буруу хэв маягаас улбаатай өвчлөл зэргийг шийдвэрлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, СӨБ-ын чанарыг дээшлүүлэн, мэргэжил олгох сургалт зэрэг боловсролыг сайжруулах зорилтыг тавьсан байна. Эдгээр нь ЖАЙКА-ийн 25 жилийн туршид хувь нэмрээ оруулж ирсэн салбаруудтай давхцаж байгаа ба зорилгоо биелүүлэхэд ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны хэрэгцээ өндөр хэвээр байх төлөвтэй байна. ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд орон нутгийн иргэдтэй нэг дор амьдрах явцдаа, өөрсдийн технологи болон мэдлэгээ ашиглан тухайн орон нутагт нийцүүлэн асуудлыг шийдвэрлэх боломжтой байдаг бөгөөд бусад ODA-ийн үйл ажиллагаатай ялгаатайгаараа онцлог юм. Энэхүү онцлогийн давуу талыг ашиглан нийгмийн аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсролын салбар дахь хамтын ажиллагааны ач холбогдол нь өндөр байна.

6.2.3 Япон Улсын ХАЁТ үзүүлэх улс орны үзүүлэлт

Монголын эдийн засгийн огцом өсөлтөөс шалтгаалан Япон Улсын ODA үзүүлдэг улс орны хувьд байр суурь нь өөрчлөгдөх магадлалтай юм. Япон Улсын Засгийн газар нь 1990 оноос хойш Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих үүднээс буцалтгүй болон иений хөнгөлөлттэй зээлийн тусламж зэрэг ODA-г үзүүлсээр ирсэн. Эдгээр буцалтгүй болон хөнгөлөлттэй зээлийн тусламжийг үзүүлэх улс орныг сонгохдоо Дэлхийн банкнаас тодорхойлдог тусламжийн стандарт үзүүлэлтийг баримталж ирсэн. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн хөгжил үсрэнгүй байсан тул Монгол Улсын нэг хүнд оногдох ҮНО (ДНБ+гадаадын гуйвуулга) 2014 онд 4,280 ам.долларт хүрч, өөр маягийн дэмжлэг шаардагдах түвшинд очжээ. Иймээс, Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад үзүүлэх тусламжийг авч үзвэл, буцалтгүй тусламж нь яаралтай, хүмүүнлэгийн тусламж голлосон хэлбэрт шилжиж үнийн дүн нь ч буурах хандлагатай болсон бөгөөд үүнийг орлох хэлбэрээр зээл санхүүгийн дэмжлэг болон техникийн хамтын ажиллагаа гол үүрэг гүйцэтгэх болно гэж тооцож байна.

6.3 Япон Улсын Засгийн газрын ODA-ийн чиглэл

6.3.1 Япон Монгол 2 орны гадаад харилцаа

Япон Монголын хооронд байгуулагдсан эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны гэрээнүүдийг доорхи хүснэгтэд харуулав. Түүнчлэн, Япон Улсад сурч буй оюутан суралцагчийн тоо нь хүн амын тоотой харьцуулсан үзүүлэлтээр дэлхийд 1-рт ордог, япон хэл сурах сонирхолтой хүмүүс олон байдаг, сумод олон монгол залуу ирж барилддаг гээд Монгол Японы хооронд халуун дотно харилцаа тогтсон юм. Энэ мэтээр хоёр орны хоорондын харилцааг хөгжүүлэхэд ЖАЙКА-ийн сайн дурын

гишүүдийг идэвхитэй томилон ажиллуулах нь зөв зүйтэй юм. Ялангуяа, Монгол Улсын хүн ам 3,000,000 гаруй буюу бусад улс оронтой харьцуулбал бага байгаа нь, ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны үр ашиг өндөр байхад нөлөөлнө гэж тооцож байна.

Хүснэгт 6-1 Япон Монгол хоёр Улсын хооронд байгуулсан голлох олон Улсын гэрээ хэлэлцээрүүд

Хэлэлцээр, Санамж бичиг	Гарын үсэг зурсан хугацаа	Тайлбар
<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ • Япон-Монголын худалдааны хэлэлцээр • Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхныг хүлээн авах тухай хэлэлцээр • Агаарын харилцааны хэлэлцээр • Найрамдал хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл • Далайн чанад дахь ахмад сайн дурынхныг хүлээн авах тухай протокол • Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хэлэлцээр • Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр • Япон-Монголын Эдийн засгийн Түншлэлийн Гэрээ 	<p>1977 он</p> <p>1990 оны 3 сар</p> <p>1991 оны 3 сар</p> <p>1993 оны 11 сар</p> <p>1998 оны 5 сар</p> <p>1999 оны 7 сар</p> <p>2001 оны 12 сар</p> <p>2003 оны 12 сар</p> <p>2015 оны 2 сард үзэглэсэн</p>	<p>2016 оны 6-р сараас хүчин төгөлдөр болсон</p>

(Эх сурвалж: ГХЯ-ны цахим хуудас)

6.3.2 Хөгжлийн хамтын ажиллагааны үндсэн зарчим

Япон Улсын Засгийн газар 1992 онд баталсан (2003 онд шинэчилж байсан) “Хөгжлийн албан ёсны тусламж ОДА-ийн үндсэн зарчим”-ыг ахин шинэчлэж, 2015 оны 2-р сард “Хөгжлийн хамтын ажиллагааны үндсэн зарчим” болгон Засгийн газрын хуралдаанаар баталсан. Үүнд, сайн дурын үйл ажиллагааны талаар дурдахдаа, энэ хэлбэрийн хамтын ажиллагааг идэвхтэй ашиглахын хамт хөгжлийн хамтын ажиллагаанд нийгмийн бүхий л давхаргын ард иргэдийн оролцоог хангаж, тэдний мэдлэг, нийгэмд оруулах хувь нэмрийг нь дэмжихэд чиглүүлнэ гэсэн байна.

“Хөгжлийн хамтын ажиллагааны үндсэн зарчим”-д стратегийн түншлэлийг бий болгох үүднээс соёл, спортын хөгжилд ч анхаарлаа хандуулсан. Ялангуяа, 2020 оны Токиогийн Олимп, Паралимпийг угтсан арга хэмжээ болгон “Sport for Tomorrow”-ийг хэрэгжүүлж, сургуулийн биеийн тамирын хичээл болон спортоор дамжуулан хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх, мөн ХБИ-ийн спортыг хөгжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг дэмжихээр болжээ⁴⁴. Энэ үүднээс биеийн тамир спорттой хамааралтай ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийг томилох үйл ажиллагаа нь цаашдын нэгэн тулгуур багана болох юм. Монгол Улсад өнөөг хүртэл спорттой холбоотой олон JOCV-г тогтвортой илгээж ирсэн, түүний дотор гар бөмбөг, сагсан бөмбөг, жүдо, агаарын теннис зэрэг төрөлд тодорхой үр дүнд хүрсэн нь цаашдын хамтын ажиллагаанд итгэл төрүүлж байна.

Түүнчлэн, үндсэн зарчмын тэргүүлэх чиглэлд глобал асуудлаар дамжуулан тогтвортой бөгөөд хүчтэй олон улсын хамтын нийгэмлэгийг бий болгохыг зорих, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гамшгаас үүссэн хохирлыг нөхөн сэргээх зэрэг асуудал орж байна.

⁴⁴ “Зөвлөмж: ЖАЙКА-ийн сайн дурынхны ирээдүй -Японы Хилийн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхнаас эхлэх 50 жилийн түүхэнд тулгуурлан-” ЖАЙКА-ийн сайн дурынхны үйл ажиллагааны чиглэлийн тухай хэлэлцсэн дугуй ширээний хурал, 2016 оны 3-р сарын 29-ний өдрөөс иш татав

6.3.3 Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Монгол Улс дахь сайн дурын үйл ажиллагаа нь 2016 оны 4-р сарын ГХЯ-ны “Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу товлогдсон байдаг. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын боловсруулсан “2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-тай нийцүүлэн боловсруулжээ. “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд сайн дурын үйл ажиллагааны голлох салбарууд болгон, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, аж ахуйн нэгжийг хөгжүүлж, мэргэжлийн сургалт, боловсрол, спорт биеийн тамирын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, байгаль орчны хамгааллыг төлөвлөж байна.

6.3.4 Сайн дурын үйл ажиллагааны асуудлууд

ЖАЙКА-ийн үйл ажиллагааны өрнөлд Япон Улсын төрөлт багасч, дундаж нас өндөрсөж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь асуудал болж байна. Японы Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эрхлэн гаргасан “Насжилтын хандлага болон ирээдүйн төсөөлөл” баримт бичгээс үзвэл 2015 онд нийт хүн ам 126,600,000 хүн байгаагийн дотор 15-64 насны хүн ам 76,820,000 хүн байгаа бол, 2030 онд нийт хүн ам 116,620,000 хүн болон буурч 15-64 насны хүн ам 67,730,000 хүн болсноор 9,090,000 хүнээр буурна. Энэхүү төрөлт багасч, хөгшрөлт нэмэгдэж буй асуудал нь сайн дурын ажилтнаар ажиллах хүсэлт гаргагсдын насжилтад шууд нөлөөлөх бөгөөд 2015 оноос 2030 оны 15 жилд, 20-39 насны (JOCV) хүн 28,380,000-аас 23,370,000 (ойролцоогоор 18% буурч) болж, 40-69 насны (SV) хүн 52,220,000-аас 46,770,000 (ойролцоогоор 10% буурна) болон буурна гэсэн тооцоо гарчээ⁴⁵. Ийм учраас, JOCV нь цаашдаа хүсэлт гаргах гишүүдийг олоход хүндрэл гарах магадлалтай болж, нөгөөтэйгүүр SV гишүүдийн тооны хувьд асуудал бага байхаар байгаа хэдий ч JOCV-д бүртгүүлэх хүн нэлээд буурна гэж таамаглаж байна.

6.4 Олон Улсын байгууллагын тусламжийн чиг хандлага

6.4.1 Үйл ажиллагааны тойм

Монгол Улс, өнөөг хүртэл байгалийн баялгийг ашиглах зэргээр эдийн засгаа хөгжүүлж ирсэн боловч үүнтэй зэрэгцэн, ядуурлын асуудал болон нийгмийн дэд бүтцийг сайжруулах нь цаашдын тулгамдсан асуудал болж байна. Эдгээр асуудал нь хөгжиж буй орнуудад нийтлэг зүйл бөгөөд нарийн төвөгтэй, олон талтай болж ирсэн асуудлуудыг шийдвэрлэхийн тулд, 2015 оны 9-р сарын НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас “Тогтвортой хөгжлийн 2030 Хөтөлбөр (SDGs)”-ийг батлан, хэнийг ч замд хаяхгүй, бүх төрлийн ядуурлыг бүрэн арилгана хэмээн тунхагласан бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгтэй хамтран ажиллах шаардлага гарч байна.

Сайн дурынхны үйл ажиллагааны хувьд ЖАЙКА-ийн сайн дурын ажилтнаас гадна, АНУ-ын Энх тайвны корпус (Peace Corps), БНСУ-ын КОЙКА (KOICA), Германы (GIZ) зэрэг нь шинэ маягийн хамтын ажиллагааг эхлүүлж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал байна. Үүнээс гадна, Монгол Улсын дотоодын ТББ-ын хамтын ажиллагаа, чадавхийг бэхжүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг Network of Mongolian Volunteer Organizations (NMVO) нь, гишүүн байгууллага болох 23 байгууллагын үнэлгээ хийх, Монголын сайн дурынхны нийгэмд оруулсан хувь нэмрийг тоо баримтаар гаргах зэрэг үйл ажиллагаа явуулдаг тул ЖАЙКА болон Энх Тайвны Корпус зэрэг сайн дурын байгууллагуудтай "Сайн Дурын Цөм Бүлэг"-ийг бий болгож тогтмол уулзалт зохион байгуулдаг нь хамтын ажиллагаанд зайлшгүй шаардлагатай юм.

6.4.2 Олон Улсын байгууллага гэх мэт бусад тусламжийн байгууллагуудтай хамтран ажиллах

Монгол Улсад тусламжийн байгууллага болон сайн дурын байгууллага олноор үйл ажиллагаа явуулж байна. НҮБ (UN), АНУ-ын Peace Corps, БНСУ-ын КОЙКА, Туркийн TICA зэрэг засгийн газрын байгууллага ба төрийн бус байгууллагын сайн дурынхан, шашинд үндэслэсэн нийгэмлэг

⁴⁵ Эх сурвалж: Үндэсний Нийгмийн аюулгүй байдал, хүн амын асуудлын хүрээлэнгийн цахим хуудас, нас (5 нас), хүйсээр ангилсан Тооцооны үр дүн <http://www.ipss.go.jp/pp-shicyoson/j/shicyoson13/t-page.asp> (хандалт 2016/12/26)

зэрэг нь үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс гадна, найрамдалт, ах дүү хотын харилцаа тогтоосон Япон, Монголын орон нутгийн захиргаад ч мөн адил үйл ажиллагаагаа явуулж байна. Сайн дурын үйл ажиллагааны хүрээнд өөр өөрийн үзэл баримтлалд тулгуурлан, өөр өөрийн арга барилаар үйл ажиллагаагаа өрнүүлж байна.

Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй сайн дурын байгууллагын дотроос БНСУ-ын КОИСА-ийн сайн дурынхны дийлэнх нь нийслэлд үйл ажиллагаагаа явуулдаг ба АНУ-ын Энх тайвны корпусаас томилогдсон гишүүдийн 70% нь англи хэлний багшаар ажилладаг. Цаашид SDGs-ийг хэрэгжүүлэх зорилгоор олон орны сайн дурын байгууллагууд үйл ажиллагаагаа явуулах тохиолдолд, ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны нэгэн адил орон нутгийн хөгжил, олон төрлийн мэргэжлээр үйл ажиллагаагаа явуулдаггүй тул, үйл ажиллагааны агуулга давхцах явдалд санаа зовох асуудал бага гэж хэлж болно.

Нөгөөтэйгүүр, мэдээллийн солилцоо нь үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм. Одоогийн байдлаар, сайн дурын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа нь томилогдсон орон нутгийн тухай мэдээлэл болон аюулгүй байдлын мэдээлэл солилцох, ижил бүс нутагт томилогдсон сайн дурын гишүүдийн харилцаа, хамтын ажиллагаан дээр үндэслэн сургалт семинар зохион байгуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байгаа бөгөөд, цаашид ОУ-ын байгууллага ч, ЖАЙКА ч SDGs-д суурилсан сайн дурын үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахтай холбогдуулан өөр хоорондоо уялдаа холбоотой хамтарч ажилласнаар илүү үр дүнд хүрнэ. Тодруулбал, эдийн засгийн хөгжил хурдацтай явагдаж байгаа, өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол Улсын хувьд мэдээллийн харилцаа холбоо нь бүхий л салбарт зайлшгүй шаардлагатай тул мэргэжлийн баримжаа олгох сургуулиудад компьютер технологи болон программ хангамжийн хичээл орох, мэдээллийн технологийг боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээнд ашиглах зэрэг мэдээлэл харилцааны технологийн (ICT: Information and Communication Technology) салбарын⁴⁶ дэмжлэгийг дурдаж болох юм. Мэдээлэл харилцааны технологи нь бие даан орших бус, төрөл бүрийн салбаруудыг хамран холбож байдаг тул, санхүү болон хүний нөөц гэх мэт олон төрлийн хязгаарлагдмал нөөцийн хэрэгцээг ханган, үр дүнтэй ашиглах зорилгоор ОУ-ын байгууллагуудын хоорондын зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

6.5 ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны цаашдын төлөв

6.5.1 ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны чиг хандлагын уулзалтаар хэлэлцсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх

2016 оны 3-р сард ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны чиг хандлагын уулзалтаар хэлэлцсэн зөвлөмж болох “ЖАЙКА-ийн цаашдын сайн дурын үйл ажиллагаа”-г нэгтгэн гаргасан. Уг зөвлөмжид, Япон Улсаас үзүүлж буй хөгжлийн хамтын ажиллагааны төлөөлөл бүхий “Нүдэнд харагдах тусламж”-ийн тодорхой арга хэмжээний чиглэл болгон дараах 3 зүйлийг заасан нь:

- 1) “Хөгжиж буй орны эдийн засаг нийгмийн хөгжил, сэргээн босголтод оруулах хувь нэмэр”,
- 2) “Соёлын ялгавартай нийгэм дэх харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж, хамтран ажиллах”,
- 3) “Сайн дурын үйл ажиллагааны туршлагад тулгуурлан нийгэмд хувь нэмэр оруулах”-ыг зөвлөсөн.

Монгол Улс дахь ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны хувьд ч энэхүү чиглэлийг баримтлах шаардлагатай байна.

Монгол Улсад үзүүлж байгаа ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны цаашдын өрнөл нь зөвлөмжөөр өгсөн чиглэлийн дагуу байх бөгөөд тодорхойлон хэлбэл уг үйл ажиллагааны өнөөдрийг хүртэлх үр дүн, үзүүлэлт, Монгол Улсын хөгжлийн бодлого ба асуудал, ОУ-ын байгууллагын чиг хандлага, Япон Улсын тусламжийн бодлого зэрэгт тулгуурлан 2030 оны хэтийн төлөв болгосон “сонголт ба төвлөрүүлэлт” шаардлагатай юм. Үүний тулд, Монгол Улсын сайн дурын хэрэгцээг

⁴⁶ Эх сурвалж: "Монголын хөрөнгө оруулалтын гарын авлага" ЖАЙКА, 2013 он

хангахын тулд томилгооны хэмжээг баталгаажуулах, хамтын ажиллагааны салбарыг тодорхойлох, ОУ-ын тусламжийн байгууллагуудтай хамтран ажиллах, орон нутагт үйл ажиллагаагаа өрнүүлэх, хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг зохиох зэргийг анхааралдаа авч үйл ажиллагаагаа явуулах нь чухал байна.

6.5.2 Томилгооны хэмжээ

ЖАЙКА-ийн сайн дурын ажилтны томилгооны цар хүрээ нь Монгол Улсын эрэлт хэрэгцээнээс шалтгаална. Монгол Улсын нийгэм 70 жилийн турш социалист дэглэмтэй байгаад ардчилалд шилжсэнээс хойш дөнгөж 25 жил өнгөрч байгаа бөгөөд нийгэм нь хуучин тогтолцооноосоо бүрэн гараагүй, хууль эрх зүйн тогтолцооны асуудлууд ч үлдсэн хэвээр байна. Мөн, хотжилтын асуудал, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Эдгээр асуудлын шийдэлд хүрэхийн тулд Монголын талаас JOCV болон SV нарын дэмжлэгийн хэрэгцээ цаашид ч байсаар байх бизээ. Түүнчлэн, энэ удаагийн судалгаагаар Монголын холбогдох байгууллагууд бүгд JOCV болон SV нарыг өндрөөр үнэлэхийн зэрэгцээ ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийг үргэлжлүүлэн томилхыг хүсч байсан.

